



МОНГОЛБАНК



ЖИЛИЙН ТАЙЛАН 2008

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН УГ



Эрхэмсэг ноёд, хатагтай нар аа,

2008 он Монголбанкны хувьд зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээс хойш хамгийн хүнд хэцүү он жил болон өнгөрч байна. 2008 онд эдийн засаг 8.9 хувиар өссөн ч улсын төсвийн алдагдал ДНБ-ий 5 хувь, төлбөрийн урсгал тэнцлийн алдагдал 2008 онд түүхэндээ хамгийн өндөр буюу 1 тэрбум ам.долларт хүрч, улсын гадаад валютын албан нөөц 315.7 сая ам.доллараар, банкуудын гадаад цэвэр актив 522.1 сая ам.доллараар буурав.

Төрийн албан хаагчдын цалин, нийгмийн хalamжийн зарлага, мөнгөний нийлүүлэлт болон банкны системийн зээлийн хурдацтай өсөлт, хүнс болон нефтийн бүтээгдэхүүний үнийн огцом өсөлт, дэд бүтэцтэй холбоотой хүндрэлүүд үнийн дарамтыг ихээхэн нэмэгдүүлснээс инфляци 2008 оны эцэст 22.1 хувьтай гарсан бөгөөд энэ нь зорилтот түвшин болох 5.9 хувиас даруй 3.7 дахин их үзүүлэлт юм.

Эдийн засагт хэт халалтын шинж тэмдгүүд илэрч, хүн амын ядууралтай хийх тэмцэлд ухралт гарч болзошгүй үед Монголбанк мөнгөний хатуу бодлогыг баримтлан мөнгөний болон эрэлтийн гаралтай инфляцийг хазаарлахад үндсэн үйл ажиллагаагаа чиглүүлэв. Тухайлбал, 2008 оны 1 дүгээр улиралд Монголбанк заавал байлгах нөөцийг 5 хувиас 5.5 хувь болгон өсгөсөн төдийгүй, мөнгөний бодлогын хүүг 2008 оны 3 дугаар сард 1.35 нэгжээр, 9 дүгээр сард дахин 0.5 нэгж хувиар өсгөж 10.25 хувьд хүргэсэн билээ.

2008 оны 2 дугаар хагасаас Монголбанк валютын интервенцийг хийж төгрөгийн ханшийг чангруулах тал дээр илүүтэй анхаарав. Энэ нь Ази тивдээ хамгийн өндөр түвшинд хүрч байсан жилийн 34 хувийн инфляцийг хазаарлан импортыг хямдруулахад зохих нөлөө үзүүлсэн боловч байнга илүүдэл нөөцтэй явж ирсэн банкны системийн төгрөгийн бэлэн нөөцийг 2008 оны 8, 9 дүгээр сараас огцом буурч эхлэхэд нөлөөлсөн билээ.

Банкны системийн нөөцийн энэхүү бууралт нь дэлхийн санхүүгийн хямралтай давхцсанаар банкуудын төлбөр тооцоо түргэн гүйцэтгэх чадвар доголдох болов. 2008 онд улсын валютын албан нөөц тал хувиар буурсан төдийгүй, зэсийн дэлхийн зах зээлийн үнэ хурдацтай унаж эхэлснээр төгрөгийн гадаад валюттай харьцах ханш огцом суларч, ялангуяа ам.долларын зээл бүхий банк, аж ахуйн нэгж, иргэдийн ханшийн эрсдэл өдрөөс өдөрт нэмэгдэж байв. 2008 оны 9 дүгээр сараас гадаад валютын орох урсгал бараг бүрэн зогсож, Засгийн газрын гадаад төлбөр, импортын хэрэгцээг зөвхөн Монголбанкны нөөцөөс хангаж байв.

2008 онд инфляци хэт хурдацтай өсч байснаас шалтгаалан эдийн засаг дахь бодит хүүний түвшин сөрөг утгатай (2008 оны 5 сард -10.7%, 2008 оны эцэст -2.8%) болсон билээ. Энэхүү байдал нь зээлдэгчдээ ашигтай мэт харгадаж байгаа боловч угтаа банкинд мөнгөө хадгалуулсан, харилцах дансанд хөрөнгөө байршуулсан харилцагчдад хүндээр тусан, улмаар банк санхүүгийн системийн үйл ажиллагааг доголдуулах, санхүүгийн салбарын зуучлалыг тасалдуулах эрсдлийг үүсгэж байв. Харилцах, хадгаламжинд хөрөнгөө байршуулсан иргэд, аж ахуйн нэгжүүд хүүний болон ханшийн өөрчлөлтөд хэт мэдрэмтгий болсноор санхүүгийн захын тогтвортой байдал алдагдах эрсдэл нэгэнт бодитой нүүрлэсэн юм.

Ийм нөхцөлд Монголбанк юуны түрүүнд банкны системийн тогтвортой байдлыг чухалчлан ажиллав. Банкуудын төлбөр тооцоо түргэн гүйцэтгэх чадварыг дэмжихийн тулд Монголбанкаас барьцаат зээлийн журмыг шинээр боловсруулан түүний дагуу банкуудад 2008 оны дүнгээр 221.8 тэрбум төгрөгийн зээлийг олгосон байна. Мөн урвуу репо болон валютын своп хэрэгслүүдийг шинээр нэвтрүүлж, 97.6 тэрбум төгрөгийн урвуу репо санхүүжилт, 113.8 тэрбум төгрөгтэй тэнцэх валютын своп хэллцийг тус тус хийв. 2008 оны 3 дугаар улиралд Монголбанкаас заавал байлгах нөөцийн хувийг 0.5 нэгж хувиар буулган 5.0 хувь болгов. Эдгээр арга хэмжээний үр дүнд банкны системд тулгамдаад байсан төлбөр түргэн гүйцэтгэх чадварын хүндрэлийг даван туулж чадсан билээ.

Монголбанкаас инфляцийг тууштай бууруулах, банкны салбарын болон ханишийн тогтвортой байдлыг хангах тал дээр цаашид онцгой анхааран ажиллах болно. Энэхүү бодлогын үр ашгийг дээшлүүлэхийн тулд төсөв, мөнгөний бодлогын уялдааг хангах, хууль эрх зүйн орчинг улам боловсронгуй болгох, хүүний болон валютын захын бүтцийг сайжруулахад үйл ажиллагаагаа чиглүүлэх болно.



Л.Пүрэвдорж
Монголбанкны ерөнхийлөгч

МОНГОЛБАНКНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ



ГАРЧИГ

1. МӨНГӨНИЙ БОДЛОГО, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ	9
1.1 Мөнгөний бодлого, түүний хэрэгжилт	9
1.2 Мөнгөний үзүүлэлтүүдийн байдал	21
1.3 Валютын нөөцийн удирдлага	28
1.4 Төгрөгийн ханшийн хөдөлгөөн	31
2. БАНКНЫ САЛБАР	35
2.1 Банкны салбарын богино болон дунд хугацааны стратегийн зорилт, түүний хэрэгжилт	35
2.2 Банкны салбарын үндсэн үзүүлэлтүүд	39
2.3 Банкны хяналт шалгалт	44
3. ТӨВ БАНКНЫ БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА	47
4. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ	57
4.1 Монгол Улсын эдийн засгийн тойм	57
4.2 Үнэ	67
4.3 Хөдөлмөрийн бүтээмж, ажил эрхлэлт, цалин	71
4.4 Засгийн газрын санхүү	76
4.5 Хөрөнгийн зах зээл	80
4.6. Төлбөрийн тэнцэл	82
5. МОНГОЛБАНКНААС 2008 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГЫН БА ТЕХНИКИЙН ШИНЖ ЧАНАРТАЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУРААНГУЙ	89
6. АУДИТОРЫН ТАЙЛАН	91
7. СТАТИСТИКИЙН ХАВСРАЛТУУД	147

МӨНГӨНИЙ БОДЛОГО, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ

1.1 Мөнгөний бодлого, түүний хэрэгжилт

Монгол Улсын эдийн засагт мөнгөжих үйл явц үргэлжилж, сүүлийн жилүүдэд мөнгөний үзүүлэлтүүд хэт хурдтай өсч 2007 оноос үнэ өсөх нөхцөл бүрэлдэж эхэлсэн байна. Үүнтэй зэрэгцээд 2007 оны сүүлийн хагасаас инфляцид нөлөөлөх нийлүүлэлтийн талын хүчин зүйлс эрчимжиж, 2008 оны туршид инфляци өндөр байх гол шалтгаан боллоо. Манай улсын эдийн засаг гадаад худалдаанаас хэт хамааралтай, улирлын мөчлөг дагаж идэвхждэг, бодит эдийн засгийн болон санхүүгийн зах зээлийн дэд бүтэц нь хүнсний үйлдвэрлэл, түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн тогтвортой ажиллагааг хангаж чадахааргүй байгаагаас нийлүүлэлтийн огцом өөрчлөлтийг даван туулах чадвар муутай байна. Инфляцийн эсрэг Монголбанкнаас авч хэрэгжүүлсэн шат дараатай бодлогын арга хэмжээ дээрх нийлүүлэлтийн инфляцийг бууруулах, мөнгөний өсөлтөөр инфляцийг үргэлжлүүлэн тэтгэхгүй байхад чиглэгдэж байсан болно. Дээрх арга хэмжээний үр дүнд 2008 оны эхний хагас гэхэд мөнгөний агрегатуудын хурдацтай өсөлт саарсан байна.

АНУ-д үүссэн үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн хямрааас улбаатай хүндрэл бэрхшээл 2008 оны хоёрдугаар хагасаас дэлхий нийтийг хамарсан санхүүгийн хямрал болж хүрээгээ тэлэв. Үүний хор уршиг манай санхүүгийн зах зээлд ихээхэн хүндээр туслаа. Уул уурхайн зарим бүтээгдэхүүний үнэ маш богино хугацаанд огцом буурч, энэ төрлийн үйлдвэрлэлээс хамааралтай дэлхийн бусад эдийн засгийн адилаар манай гадаад худалдааны алдагдал өсч, гадаад валютын нөөц буурч, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш суларч эхэлсэн. Мөн гаднын байгууллагууд манай банк, компаниудад өгсөн зээлээ эргүүлэн татсан, төлөвлөсөн хөрөнгө оруулалтын хугацааг хойшлуулсан, гадаадад амьдарч буй монголчуудын мөнгөн гүйвуулгын хэмжээ буурсан зэргээс хөрөнгийн дотогшлох урсгал буурч, дотоодын банкны салбарт мөнгөн хөрөнгийн хомсдол үүсэх нөхцөл бүрдүүлжээ. Ийнхүү хөрөнгийн хомсдол бий болсноор банкны салбарын эх үүсвэрийн өсөлт буурч “зээлийн тасалдал”-д орсон байна. 2008 оны сүүлийн улиралд мөнгөний бодлого нь банкны салбарын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг алдагдуулахгүй байх, банкны эх үүсвэр гадагшилсан болон салбарын гадаад цэвэр актив хэт түргэн буурсны улмаас үүссэн хүндрэл нь банкны хямрал болон өргөжихэд хүргэхгүй байхад чиглэгдэж байв.

Нөөц мөнгө




Нөөц мөнгөний хэмжээ 2008 онд жилийн 18.4 хувиар өсч 633.7 тэрбум төгрөгт хүрлээ. Нөөц мөнгөний өсөлтийн дийлэнх буюу 56.3 хувийг Төв банк дахь банкуудын харилцах, хадгаламжийн өсөлт, 46.0 хувийг банкнаас гадуурх мөнгөний өсөлт эзэлж байна. Өмнөх онтой харьцуулахад нөөц мөнгөний өсөлтөд банкнаас гадуурх мөнгө болон банкуудын кассын эзлэх хувь харгалзан 18.0 болон 15.8 нэгжээр тус тус буурсан бол Төв банк дахь банкуудын харилцах, хадгаламжийн эзлэх хувь 33.9 нэгжээр өссөн байна. Банкууд тайлант оны эцэст Төв банкинд жилийн 1 хувийн хүүтэйгээр 74.4 сая ам.долларын хадгаламж байршуулсан нь Төв банк дахь банкуудын харилцах, хадгаламж оны эхнээс 55.5 тэрбум төгрөгөөр, өмнөх сараас 66.4 тэрбум төгрөгөөр өсөхөд нөлөөлсөн байна. Эдийн засаг дахь бэлэн мөнгөний хэмжээ буюу банкнаас гадуурх мөнгө оны эхнээс 45.4 тэрбум төгрөгөөр, өмнөх сараас 65.7 тэрбум төгрөгөөр өссөн нь 2008 оны 12 дугаар сард “Анод” банкнаас иргэд, аж ахуйн нэгжүүд их хэмжээгээр харилцах, хадгаламж татсантай холбоотой.

Нөөц мөнгөний бүтцэд банкнаас гадуурх мөнгөний эзлэх хувь буурч, Төв банк дахь банкуудын харилцах, хадгаламж болон банкуудын кассын эзлэх хувь өсөх хандлага 2006 оныг хүртэл ажиглагдаж байсан. Харин Монголбанк банк хоорондын захын илүүдэл нөөцийг удирдах хэрэгсэлдээ өөрчлөлт оруулж, 7 хоногийн хугацаатай ТБҮЦ-ыг банкуудын эрэлтийн хэмжээгээр, тогтмол хүүгээр, 12 болон 28 долоо хоногийн хугацаатай ТБҮЦ-ыг хүүний дээд хязгаар тогтоолгүй, хэмжээг нь хязгаарлах зарчмаар арилжаалдаг болсноор банк хоорондын захын төгрөгийн илүүдэл нөөц буурч, нөөц мөнгөнд банкуудын Төв банк дахь харилцах, хадгаламжийн эзлэх хувь 2007 оноос буурчээ. Банкуудын харилцах, хадгаламжийн нөөц мөнгөнд эзлэх хувь 2008 онд 33.9 нэгжээр нэмэгдсэн нь арилжааны банкууд гадаадын банк санхүүгийн байгууллагуудад байршиж байсан валютын харилцах, хадгаламжкаа Монголбанкинд хадгалуулснаар валютын хадгаламж оны эцэст 74.4 сая ам.доллараар нэмэгдсэнтэй холбоотой. Түр зуурын шинжтэй байсан банкуудын валютын хадгаламжийг эс тооцвол банкуудын харилцах, хадгаламжийн нөөц мөнгөнд эзлэх хувь 27.3 болж өмнөх оноос 4.9 нэгжээр өсөхөөр байв.

Нөөц мөнгөнд банкнаас гадуурх мөнгөний эзлэх хувь өнгөрсөн онтой харьцуулахад тайлант онд 1.1 нэгжээр буурч 51.9 хувь болсон хэдий ч бэлэн бус төлбөр тооцооны дэвшил, нэрлэсэн ДНБ-ий өсөлт зэрэгтэй холбоотойгоор эдийн засаг дахь бэлэн мөнгөний эрэлт өндөр хэвээр байна.

Тайлант онд нөөц мөнгөний хөдөлгөөнийг дараахь 4 үед хувааж болохоор байна.

- *2007 тийн 7-р үе 2008 тийн 2-р дугаар сард нөөц мөнгөний бүрэлдхүүн хэсгүүд болох банкнаас гадуурх мөнгө, банкуудын касс, банкуудын харилцах, хадгаламж бүгд буурсан. Тухайлбал, 2 дугаар сард оны эхнийхтэй харьцуулахад банкнаас гадуурх мөнгө 38.1 тэрбум төгрөгөөр, банкуудын касс 16.0 тэрбум төгрөгөөр, банкуудын харилцах, хадгаламж 46.9 тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь нөөц мөнгө өмнөх оны эцсээс 100.9 тэрбум төгрөгөөр буурахад нөлөөлжээ.*
- *2008 тийн 3-р дугаар сараас банкнаас гадуурх мөнгөний хэмжээ 56.0 тэрбум төгрөгөөр өсч 301.2 тэрбум төгрөгт хүрч, банкуудын харилцах, хадгаламжийн хэмжээ 42.2 тэрбум төгрөгөөр өсч 166.4 тэрбум төгрөгт хүрсэн нь нөөц мөнгө 2 дугаар сартай харьцуулахад 101.8 тэрбум төгрөгөөр өсч 536 тэрбум төгрөгт хүрэхд нөлөөлжээ.*
- *2008 тийн 8-р дугаар сараас 7-р дугаар сард нөөц мөнгөний хэмжээ 19.5 тэрбум төгрөг болон 38.7 тэрбум төгрөгөөр буурсан нь нөөц мөнгө 7 дугаар сартай харьцуулахад 59.8 тэрбум төгрөгөөр буурч, 476.2 тэрбум төгрөгт хүрэхд нөлөөлжээ.*
- *2008 тийн 11-р дугаар сараас 12-р дугаар сард нөөц мөнгөний хэмжээ 157.5 тэрбум төгрөг буюу 33.1 хувиар өссөн. Энэ нь улирлын шинж чанартай холбоотой баяр ёслол болон Анод банкны хадгаламж олгох үйл ажиллагаатай холбоотойгоор банкнаас гадуурх мөнгөний хэмжээ 66.2 тэрбум төгрөгөөр, банкуудын касс 11.7 тэрбум төгрөгөөр, Засгийн газрын зардал болон банкуудын валютын хадгаламжтай холбоотойгоор банкуудын харилцах,*



хадгаламж 79.6 тэрбум төгрөгөөр тус тус өссөнөөс шалтгаалсан байна. Гэхдээ банкуудын төгрөгийн харилцахын үлдэгдэл 32.6 тэрбум төгрөгөөр буурч, Монголбанкнаас авсан зээл 150.7 тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

Тайлант оны эцэст нөөц мөнгө өссөн нь түүний бүрэлдэхүүн хэсэг болох банкнаас гадуурх мөнгө, Төв банк дахь банкуудын харилцах, хадгаламж нэмэгдсэнээс голлон шалтгаалжээ. Харин нөөц мөнгөний бүрэлдэхүүн хэсэг болох банкуудын касс бага хэмжээгээр буурсан байна.

Манай улсын эдийн засгийн байдал улирлын шинж чанартай өөрчлөгддөг тул нөөц мөнгө болон түүний бүрэлдэхүүн хэсгүүдэд улирлын хэлбэлзэл өндөр ажиглагддаг. Нөөц мөнгөний улирлын хэлбэлзэл тайлант онд бага хэмжээгээр өссөн нь Төв банк дахь банкуудын харилцах, хадгаламжийн улирлын хэлбэлзэл бага зэрэг нэмэгдсэнээс шалтгаалсан байна. Харин банкнаас гадуурх мөнгөний улирлын хэлбэлзэл сүүлийн жилүүдэд тогтвортой байна.


Мөнгөний бодлогын хүү

2008 он нь Монголбанк мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхдээ Мөнгөний бодлогын хүүг ашигласан 2 дахь жил. Бодлогын хүүгийн түвшинг эдийн засгийн байдалтай зохицуулан өөрчлөх эсэхийг Монголбанкны захирлуудын зөвлөлийн зөвлөснөөр Монголбанкны Ерөнхийлөгч шийдвэрлэнэ. Монголбанкны бодлогын хүү нь банкуудаас 7 хоногийн хугацаагаар хөрөнгө татан авах хэлцэл болох 7 хоногт төлөгдөх Төв банкны үнэт цаасны хүү юм. Нэгэнт банк хоорондын захын хамгийн бага эрсдэлтэй оролцогч нь төв банк байх тул энэ хүү үндсэндээ банк хоорондын захын хүүний доод хязгаар болно.

2008 оны 3 дугаар сард бодлогын хүүг жилийн 8.4 хувиас 1.35 хувиар нэмэгдүүлж 9.75 хувь болгосон нь нэг талаас, инфляцийг улам эрчимжүүлж байсан хүчин зүйлс супрахгүй байсан тул цаашид инфляци нэмэгдэх дарамт улам ихэссэн, нөгөөтэйгүүр, төсвийн үргэлжилсэн тэлэлтээс үүдсэн сөрөг үр дагавраас сэргийлэх арга хэмжээ байлаа. Бодлогын хүүг ингэж нэмэх тухай нийтэд мэдээлжэдээ олон улсын зах зээлд хүнсний зарим бүтээгдэхүүн, нефтийн бүтээгдэхүүний үнэ цаашид нэмэгдэх, БНХАУ-ын юанийн ханш чангараах зэрэг гадаад худалдааны сөрөг нөлөө үүсч болох боломжтой байгааг дурьдаж байжээ.

Бодлогын хүүг 2008 оны 9 дүгээр сард дахин 0.5 нэгжээр нэмэгдүүлж, 10.25 хувь болгов. Нефтийн бүтээгдэхүүний үнэ 8 сард 30 гаруй хувиар огцом нэмэгдэж цаашид инфляцийг улам эрчимжүүлэх байдал бий болсон, хүнсний бүтээгдэхүүний үнэ дорвитой буурах нөхцөл бүрдэхээргүй байсан нь ийм шийдвэр гаргах гол үндэслэл болжээ. Бодлогын хүүний өөрчлөлтийн үр дүн тодорхой хугацааны дараа гарах тооцоотой байсан бөгөөд шатахууны үнийн өсөлтийг даган нэмэгдэх үнийн өсөлтийг мөнгөний өсөлтөөр тэтгэхгүй байх зорилготой байв.

Бодлогын хүүг 2008 оны 11 дүгээр сард бууруулж 9.75 хувь болгов. Монголбанкнаас нийтэд мэдээлжэдээ инфляци буурч эхэлсэн, гол экспортын барааны үнэ буурсан, худалдааны түнш орнуудын эдийн засгийн өсөлт саарсан зэргийг үндэслэл болгосон тухай дурджеэ.



Зураг 1.4.

Нөөц мөнгө болон түүний бүрэлдэхүүн хэсгүүдийн улирлын хэлбэлзлийн хандлага

Ийнхүү бодлогын хүү нь мөнгөний бодлогын өөрчлөлтийн чигийг заагаад зогсохгүй өөрчлөгдж буй эдийн засгийн орчны ирээдүйд үзүүлэх нөлөөллийг зохицуулах шийдвэрийн тухай олон нийтэд нээлттэй мэдээлэх хэрэгсэл болон хөгжиж байна.

Төв банкны үнэт цаас

Тайлант онд ТБҮЦ-ны арилжааг тогтмол хүүтэй болон хүүгээр өрсөлдөх хоёр төрлөөр явуулав. Долоо хоногийн хугацаатай үнэт цаасны арилжааг тогтмол хүүтэй буюу арилжааны хүүг Монголбанкнаас зарлах зарчмаар явуулж, харин 12, 28 долоо хоногийн хугацаатай үнэт цаасыг хүүгээр өрсөлдүүлэх зарчмаар тус тус арилжааллаа. Тайлант онд Монголбанк нийт 70 удаа ТБҮЦ-ны арилжаа зарлаж, 1328.8 тэрбум төгрөгийн үнэт цаасыг борлуулав. Оны эцсийн байдлаар ТБҮЦ-ны үлдэгдэл 120.6 тэрбум төгрөгт хүрчээ. Энэ нь өмнөх улиралтай харьцуулахад 2.8 дахин, өмнөх оны мөн үеэс 15.4 хувиар өссөн үзүүлэлт юм. Монголбанк 2008 оны туршид өдөрт дунджаар 67.9 тэрбум төгрөгийн ТБҮЦ-ыг банкуудад байршуулж байсан нь 2007 оныхоос 43.9 хувиар буурсан байна.

ТБҮЦ-ны жигнэсэн дундаж хүү 2008 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 14.7 хувь байгаа нь өмнөх улирлынхаас 1.36 нэгж хувиар доогуур, 2007 оны эцсээс 4.83 нэгж хувиар өндөр байна. Тайлант онд Монголбанк ТБҮЦ-ны хүүний зардалд 7.8 тэрбум төгрөг төлөв. Энэ нь өмнөх оныхоос 0.1 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлт юм.

Мөн тайлант онд банкуудын илүүдэл нөөцийг татах зорилгоор 12, 28 долоо хоногийн хугацаатай ТБҮЦ-ыг арилжаалав. Тайлант оны эцсийн байдлаар 12 долоо хоногийн хугацаатай үнэт цаасны үлдэгдэл 7.6 тэрбум, 28 долоо хоногийн хугацаатай үнэт цаасны үлдэгдэл 26.8 тэрбум төгрөг, жигнэсэн дундаж хүү нь харгалzan 17.77, 16.73 хувь байсан байна.

Барилгын дахин санхүүжилт

Монголбанк барилгын салбарт зээл олгосон арилжааны банкуудын үйл ажиллагааг цаашид эрсдэлд оруулахгүй байх үүднээс банкуудын орон сууцны барилгад олгосон зээлийг дахин санхүүжүүлэх замаар 80-аас дээш хувийн гүйцэтгэлтэй байгаа орон сууцны барилгыг дуусгахад зориулж хоёр арилжааны банкинд нийт 55.7 тэрбум төгрөгийн дахин санхүүжилт олгов. Монголбанк банкуудаас дуусаагүй барилгад хэдий хэмжээний нэмэлт санхүүжилт хэрэгтэй байгаа талаар судалгаа авсан бөгөөд үүний 70 хувийг Монголбанк санхүүжүүлж, үлдэх 30 хувийг банк өөрөө санхүүжүүлэхээр гэрээг байгуулав.

Банкууд ихэвчлэн урьд нь зээл олгосон барилгын компаниудад орон сууцны барилгын ажлыг гүйцэтгэж дуусгахад нь зориулан нэмж зээл олгосон байна. Монголбанкнаас дахин санхүүжилт авах зарчим нь банкууд эхлээд Монголбанкнаас тавьсан шаардлагыг хангасан дэд зээлдэгчийг судлан зээл олгох шийдвэрээ гаргаж, дараа нь дахин санхүүжилт авах хүсэлтээ Монголбанкинд ирүүлэх юм.


Хүүний хөдөлгөөн 2008



Зураг 1.5.

Бодлогын хүү,
банк хоорондын
захын хүү,
ТБҮЦ-ны
дундаж хүү,
ex-post
тооцоолсон
зээл болон
хадгаламжийн
хүү

Төв банкны бодлогын хүү ба ТБҮЦ-ны жигнэсэн дундаж хүү



Зураг 1.6.

Төв банкны
бодлогын хүү
ба ТБҮЦ-ны
жигнэсэн дундаж
хүү

Банкуудад олгож буй дахин санхүүжилтийн хугацаа 180 хүртэл хоног, хүү нь жилийн 12 хувь, санхүүжилтийн хэмжээ нь барилгын ажлыг дуусгахад шаардагдах нэмэлт хөрөнгийн 70 хүртэл хувь байна. Банкууттай байгуулсан дахин санхүүжилтийн гэрээгээр банкууд эцсийн зээлдэгчид олгох зээлийн эрсдэлийг бүрэн хариуцах тул эцсийн зээлдэгчийн үйл ажиллагаанаас үл хамааран гэрээнд заасан хугацаанд Монголбанкинд зээлээ буцаан төлөх үүрэгтэй юм.

Үрвуу репо арилжаа

Монголбанкаас банкуудын хөрөнгийн удирдлагад дэмжлэг үзүүлэх, банкны салбар дахь мөнгөн хөрөнгийн түр зуурын дутагдлыг нөхөх, банк хоорондын захын тогтвортой байдлыг хангах зорилгоор Монголбанкны Ерөнхийлөгчийн 2008 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн 399 тоот тушаалаар “Төв банкны зарласан урвуу репо арилжааны журам”-ыг шинээр батлан, Төв банкны зарласан урвуу репо арилжааны хэрэгслийг нэвтрүүлэв.

Тус хэрэгслийг нэвтрүүлснээр банк хоорондын зах дээр хөрөнгийн хомдол бий болох тохиолдолд Монголбанкны зүгээс банкны салбарын тогтвортой байдал, үндэсний төлбөр тооцооны системийн хэвийн үйл ажиллагааг хангахад нөлөөлөх боломж бүрдэх юм. Тус хэрэгслийн Төв банкны бусад санжүүжилтийн хэрэгслүүдээс ялгагдах онцлог нь хугацааны хувьд урт бөгөөд Монголбанк нь өөрийн санаачилгаар репо арилжаа зарлаж ямар тохиолдолд хэдий хэмжээний арилжаа зарлахаа мөнгөний бодлогын төлөвлөлт, банк хоорондын захын байдал, төв банкны нөөцийн эрэлт, нийлүүлэлтийн таамаглал зэрэгт үндэслэн тухай бүр шийдвэрлэдэг.

Урвуу репо арилжаа хоёр хэлбэрээр явагдана. Үүнд:

1. Монголбанк арилжааны хэмжээ болон хүүг зарлаж, банкууд авах саналаа ирүүлэх;
2. Монголбанк арилжааны хэмжээг зарлаж, банкууд хэмжээ болон хүүний саналаа ирүүлэх.

Хоёр дахь тохиолдолд хүүний зөрүү үүсгэхгүйн тулд Монголбанк хүүний доод хязгаарыг Монголбанкны бодлогын хүү байхаар журамд тусгав.

Цаг зуурын шинж чанартай үйл явдлаас шалтгаалан 2008 онд банк хоорондын зах дээр илүүдэл нөөцийн хэмжээ тогтмол буурч байв. Тухайлбал, Сангийн яамнаас 2008 оны нэгдүгээр улирлаас эхлэн арилжааны банкуудад хадгаламж хэлбэрээр 60-70 тэрбум төгрөгийг 2 удаа тус бүр 3 сарын хугацаатайгаар байршуулсан бөгөөд тус хадгаламжийн хугацаа 8 дугаар сарын сүүлийн 10 хоногт дуусч, Сангийн яамнаас дахин байршуулаагүй, банкны салбараас Роснефть компанийн дансаар дамжин 60 орчим тэрбум төгрөг 9 дүгээр сарын сүүлийн хагаст шатахууны төлбөрт шилжсэн зэрэг гэнэтийн мөнгөн хөрөнгийн гадагшлах урсгалыг нөхөх зорилгоор Монголбанк тухай бүр урвуу репо арилжааг зохион байгуулан, банк хоорондын захын тогтвортой байдлыг ханган ажиллав.

Тайлант 2008 онд Төв банкнаас зарласан урвуу репо арилжааг нийт 10 удаа зарлаж, нийт 84 тэрбум төгрөгийн санхүүжилт урвуу репо арилжаагаар банкуудад олгожээ. Тайлант оны эцсийн байдлаар банкуудад олгосон урвуу репо санхүүжилтийн үлдэгдэл

17.3 тэрбум төгрөг, жигнэсэн дундаж хүү нь 12.19 хувь байв. Банкууд урвуу репо санхүүжилтийг ихэвчлэн 21 хоногийн хугацаатай авч, Монголбанктай засгийн газрын үнэт цаас, төв банкны үнэт цаасаар урвуу репо хэлцэл хийсэн байна.

Барьцаат зээл

Тайлант оны сүүлийн хагаст валютын ханшийн огцом хөдөлгөөн, инфляцийн хурдацтай өсөлт болон банкуудын талаарх цуу яриа зэрэг олон шалтгааны улмаас олон нийтийн дунд банкинд итгэх итгэл буурч, улмаар банкуудын эх үүсвэрийн гадагшлах урсгал нэмэгдэх болов. Энэхүү байдал нь ялангуяа тайлант оны сүүлийн улиралд ихээхэн хүчтэй мэдрэгдэж эхэлсэн бөгөөд энэ үед Монголбанкнаас санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг сайжруулах зорилгоор шат дараатай авч хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд хэд хэдэн хэрэгслийг шинээр нэвтрүүлсний нэг нь барьцаат зээл бөгөөд Монголбанкнаас 2008 оны 11 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлэн “Банкинд олгох барьцаат зээлийн журам”-ыг мөрдүүллээ.

Тус журмын гол зорилго нь Монголбанкнаас банкуудын богино хугацааны төлбөр түргэн гүйцэтгэх чадварын хүндрэлээс үүдэлтэй санхүүгийн түр зуурын бэрхшээлийг даван туулахад нь туслахад оршиж байгаа бөгөөд Монголбанк тухайн банкийг өөрийн үйл ажиллагааны үр дүнд уг хүндрэлээс богино хугацаанд гарч чадна гэж үзсэн тохиолдолд барьцаат зээлийг 90 хүртэлх хоногийн хугацаатайгаар, онцгой тохиолдолд олгоно. Төв банкнаас олгож буй барьцаат зээл нь банкуудын хувьд эх үүсвэр олох сүүлийн арга хэмжээ буюу зээл хүсэгч банк нь Монголбанкннд барьцаат зээл авах хүсэлт ирүүлэхээс өмнө банк хоорондын зах дээрх бүх боломжит хөрөнгийн эх үүсвэр болон Төв банкны бусад санхүүжилтийн хэрэгслүүдийг ашигласан нөөцөнд олгогдож буй юм.

“Банкинд олгох барьцаат зээлийн журам” батлагдсанаас хойши хугацаанд нийт 7 арилжааны банкнаас ирүүлсэн хүсэлтийн дагуу 221.8 тэрбум төгрөгийн барьцаат зээлийг олгосон бөгөөд үүнээс хуваарийн дагуу 54.4 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдж, 167.3 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Үүнээс Анод банкинд 118.3 тэрбум төгрөгийн барьцаат зээл олгосноос 34.0 тэрбум төгрөг нь эргэн төлөгдж, нийт 84.3 тэрбум төгрөгийн барьцаат зээлийн үлдэгдэлтэй байв. Монголбанк ийнхүү хөрөнгийн дутагдалд орсон Анод банкинд Бүрэн эрхт төлөөлөгчдийн зөвлөлийг томилон ажиллуулж, тухайн үеийн банкны хүндрэлийг салбарын шинжтэй болон даамжраахаа урьдчилан сэргийлж чадсан юм. Харин хүүний хувьд журамд заасны дагуу банк хоорондын захын сүүлийн 3 сарын дундаж хүү буюу 13.86 хувь байв.

Монголбанкны хувьд барьцаат зээлийг олгож эхэлснээр тайлант оны сүүлийн улиралд банкны салбарт бий болоод байсан салбарын тогтвортгүй байдал (Анод банкинд бүрэн эрхт төлөөлөгч томилсноор салбарын хэмжээнд үүссэн болгоомжлол), иргэдийн хадгаламжаа их хэмжээгээр татаж байснаас үүдсэн төлбөр түргэн гүйцэтгэх чадварын хүндрэл зэргийг цаг алдалгүй даван туулахад чухал үүрэг гүйцэтгэсэн гэж үзэж байна.

Заавал байлгах нөөцийн шаардлага

Монголбанкнаас тогтоосон заавал байлгах нөөцийн хувь хэмжээ нь мөнгөний нийлүүлэлтийг хянах чухал хэрэгслийн нэг юм. Инфляцийн түвшин өндөр байсан 2008 оны эхэн үед эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлтийг багасгах зорилгоор харьцаангуй хатуу мөнгөний бодлого явуулж, заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 0.5 нэгж хувиар нэмэгдүүлж 5.5 хувьд хүргэв.

Монголбанк 2008 оны 4 дүгээр улирлаас инфляци эрчимжихгүй байх боломжтой, газрын тос, хүнсний үнэ огцом нэмэгдэхгүй байх нөхцөл бүрдэж эхэлж байсан, мөн Засгийн газраас инфляцийн эсрэг шийдвэртэй алхмууд авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зэрэг нь ирэх онд инфляцийг бууруулах нөхцлийг бүрдүүлж байна гэж үзэн, заавал байлгах нөөцийн хувь хэмжээг **0.5 нэгжээр бууруулж 5.0 хувьд** хүргэв. Ингэснээр банкуудад мөнгөн хөрөнгөө хөрвөх чадвар өндөртэй активт байршуулах нэмэлт болодшоо одгосон байна.

Тайлант хугацаанд нийт 26 удаа заавал байлгах нөөцийн хэмжээг төгрөгөөр болон валютаар банк тус бүрээр тогтоож, түүний хангалтыг тооцож холбогдох арга хэмжээ авч ирлээ. Нөөцөө хангаагүй банк 2008 онд цөөхөн байсан бөгөөд салбарын хэмжээгээр нийт 1.9-26.2 тэрбум төгрөгөөр нөөцийн илүүдэлтэй байв. Энэ нь өнгөрсөн онтой харьцуулахад, 44.3 тэрбум төгрөг буюу 23.8 хувиар бага байгаа нь банкуудын хөрөнгийн эх үүсвэр харьцангуй буурсныг харуулж байна.


Засгийн газрын цэвэр зээл

Тайлант оны эцэст банкны салбарын нэгдсэн дүнгээр Засгийн газраас авах авлага 2.5 тэрбум төгрөг, төвлөрсөн болон орон нутгийн төсвийн хөрөнгө 522.7 тэрбум төгрөг болж, Засгийн газрын цэвэр зээлийн хэмжээ сөрөг 520.2 тэрбум төгрөгт хүрэв. Энэ дүнг 2007 онтой харьцуулбал төвлөрсөн болон орон нутгийн төсвийн хадгаламж 227.9 тэрбум төгрөгөөр, Засгийн газраас авах банкны салбарын авлага 21.6 тэрбум төгрөгөөр тус тус буурчээ. Зэс, алтны дэлхийн зах зээлийн үнэ өндөр байх үетэй харьцуулахад Засгийн газар нөөц эх үүсвэрээ ашиглахад хүрч энэ хэмжээгээр төсвийн харилцах хадгаламж эрс хорогдсон нь энэ жилийн мөнгөний тоймын онцлог уйл явдал байлаа.

Тайлант оны эцэст Монголбанк Засгийн газраас авах авлагагүй байна. Засгийн газраас авах банкуудын авлагын 52 хувь нь Засгийн газрын богино хугацаатай үнэт цаас, 34.8 хувь нь банкуудаас улсын төсөвт урьдчилж төлсөн болон хойшлогдсон татвар, 13.2 хувь нь хуримтлуулж тооцсон хүүний авлага тус тус эзэлж байна. Банкууд 2008 оны эцсийн байдлаар нийт 1.3 тэрбум төгрөгийн Засгийн газрын үнэт цаас эзэмшиж байгаагийн 1.0 тэрбум төгрөг Голомт банкинд, 0.3 тэрбум төгрөг ХАС банкинд байна.


Банкны салбар дахь улсын төсвийн хөрөнгө болон харилцах, хадгаламж тайлант оны эцэст 522.7 тэрбум төгрөгт хүрсний 39.9 хувь нь Монголбанкинд, 60.1 хувь нь банкуудад байршиж байна. Нийт төсвийн хөрөнгийн 55.9 хувь нь төрийн сангийн нэгдсэн данс болон Засгийн газрын харилцах дансны хөрөнгө, 22.5 хувь нь хугацаагүй болон хугацаатай хадгаламж, 19.8 хувь нь Засгийн газрын санхүүжилтийн хөрөнгө, 1.8 хувь нь орон нутгийн төсвийн хөрөнгө эзэлж байна.

ТБҮЦ-ны үлдэгдэл ба хугацааны бүтэц



Зураг 1.7.

ТБҮЦ-ны
үлдэгдэл ба
хугацааны
бүтэц



Зураг 1.8.

Заавал байлгах
нөөц

Төв банкнаас дамжуулан олгосон төслийн зээлүүд

Одойдоо аж ахуйн зорилго нь илүү үр ашигтай, зах зээлд чиглэсэн, хөдөө аж ахуйн салбарын тогтвортой санхүүжилтийг хөгжүүлж, бүтээмж, ашигт ажиллагааг сайжруулснаар орлогын түвшинг нэмэгдүүлэн ядуурлыг бууруулах явдал юм.

ХААСХХ төсөл нь Завхан, Увс, Ховд, Говь-Алтай, Дархан-Уул, Сэлэнгэ, Баянхонгор, Баян-Өлгий аймгуудад Анод, ХААН, Зоос, Монгол шуудан, Хадгаламж, ХАС зэрэг банкаар дамжин амжилттай хэрэгжин дуусч байгаа бөгөөд 2008 онд төслийн эргэлтийн сангийн эх үүсвэрийг дахин ашиглах зорилгоор Дэлхийн банкны Бичил санхүүгийн хөгжлийн хөтөлбөрт шилжүүлэх шийдвэр гарч хэрэгжих шатандаа явж байна.

Ажлын байр нэмэгдүүлэх 1290-МОН төсөл

Тайлант онд Азийн хөгжлийн банкны “Ажлын байр нэмэгдүүлэх 1290-МОН төсөл”-д Голомт, Эрэл, Анод банкууд оролцлов. Ажлын байр нэмэгдүүлэх төслийн эх үүсвэр 2008 оны эцсийн байдлаар 3.4 тэрбум төгрөг байв. Монголбанк ажлын байр нэмэгдүүлэх төслийн эргэлтийн сангийн эх үүсвэрээс 2008 онд нийт 1.56 тэрбум төгрөгийн зээлийг төсөлд оролцогч банкуудад дамжуулан олгож, банкуудын зээлийн өрийн үлдэгдэл оны эцсийн байдлаар 1.65 тэрбум төгрөг болов. Тус төслийн хүрээнд Голомт банк 294, Эрэл банк 135 ажлын байрыг 2008 онд шинээр бий болгожээ.

Хөтөлбөрийн хүрээнд анх 10.0 сая марк буюу 5.1 сая евро, 2 дугаар хөтөлбөрийн хүрээнд 3.6 сая евро, нийт 8.7 сая европийн зээлийг авсан. Тайлант онд тус хөтөлбөрт Капитрон, Монгол Шуудан, Худалдаа хөгжлийн банкууд оролцлоо.

Төслийн үндсэн эх үүсвэрийг бүрэн ашиглаж дууссан бөгөөд банкуудаас эргэн төлөгдсөн зээлийн эх үүсвэрээр төслийн зориулалтын дагуу дахин зээл олгож ирэв. 2008 онд төсөлд оролцогч банкуудад 702.9 мянган европийн зээлийг дамжуулан олгож, банкуудын төслийн зээлийн өрийн үлдэгдэл тайлант оны эцсийн байдлаар 11.5 тэрбум төгрөгт хүрсэн байна.

1.2 Мөнгөний үзүүлэлтүүдийн байдал

Тайлант онд эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлтийн хэмжээ оны эхнээс 3.4 хувиар буюу 82.4 тэрбум төгрөгөөр буурч 2.3 их наяд төгрөгт хүрлээ. Мөнгөний нийлүүлэлт буурсан нь бараг мөнгө буюу хадгаламж буурснаас (8.4 хувь буюу 152.5 тэрбум төгрөг) шалтгаалжээ. Харин M1 мөнгө буюу харилцахын үлдэгдэл өмнөх оноос 11.9 хувиар буюу 70.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт өмнөх оны мөн үеийн өсөлтөөс 59.7 нэгж хувиар саарчээ. Мөнгөний үзүүлэлтүүд сүүлийн 6 жилийн турш өндөр хурдтай өсч, эдийн засаг дахин мөнгөжих процесс явагдлаа. Харин 2007 оны 4 дүгээр улирлаас мөнгөний өсөлт үнийн өсөлтийг дагуулах болов. Нөгөө талаар 2007 оны сүүлийн хагас жилээс эхлэн нийлүүлэлтийн талын хүчин зүйлс инфляцийн дарамтыг өстөх болсон тул Монголбанкнаас инфляцийн эсрэг шат дараатай арга хэмжээ авах замаар мөнгөний бодлогоо хатууруулсан, дэлхийн эдийн засгийн хямрааас шалтгаалж хөрөнгийн гадагшлах урсгал явагдсан, банкууд эх үүсвэрийн дутагдалд орсон зэргээс хамаарч анх удаагаа M2 мөнгөний жилийн өсөлт -3.4 хувь хүртэл буурав. Мөн дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн бууралтаас шалтгаалан дотоодын эдийн засагт гадаад худалдааны тэнцэл муудсан, төгрөгийн амдоллартай харьцах ханш суларсан, хөрөнгө гадагшаа урссан зэргээс дотоодын банкны салбарт мөнгөн хөрөнгийн хомсдол бий болох нөхцөл бүрдсэн байна. Ийнхүү хөрөнгийн хомсдол бий болсноор банкны салбарын эх үүсвэрийн өсөлт багасав. Мөнгөний нийлүүлэлтийг бүтцээр нь авч үзвэл, бараг мөнгө 71.5 хувь (үүнд төгрөгийн хадгаламж 40.3 хувь, гадаад валютын хадгаламж 19.0 хувь, гадаад валютын харилцах 12.2 хувь), M1 мөнгө 28.5 хувийг тус тус эзэлж байна. Мөнгөний нийлүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн өөрчлөлтийн хандлагыг авч үзвэл, өмнөх жилд тогтвортой өсч байсан M1 мөнгөний жилийн өсөлтийн хурдац тайлант оны нэгдүгээр сараас хойш тасралтгүй буурч оны эцэст 11.9 хувьд (төгрөгийн харилцах өмнөх оны өсөлтөөс 100 нэгж хувиар буурсан) хүрчээ. Дээрх бууралтад банкны салбараас хөрөнгө зугтах буюу харилцах, хадгаламж буурч байсан нь голчлон нөлөөлжээ.



Тайлант онд мөнгөний нийлүүлэлтийн бууралтад бараг мөнгө, түүний дотор иргэд, аж ахуйн нэгжийн төгрөгийн хадгаламжийн бууралт зонхилох нөлөө үзүүлсэн байна. Ялангуяа, сүүлийн улиралд банкны салбарын эх үүсвэрийн дутагдал, ханшийн суралттай холбоотойгоор бараг мөнгө 263.3 тэрбум төгрөгөөр багасав.

Хүснэгт 1.1. Мөнгөний үзүүлэлт

	2004	2005	2006	2007	2008	M2 мөнгөнд эзлэх хувь
Бага мөнгө -M1	221,327.6	269,124.4	331,903.4	590,471.6	660,616.3	28.5%
өсөлт (%)	4.0%	21.6%	23.3%	77.9%	11.9%	
Банкнаас гадуурх мөнгө	143,512.7	152,369.5	185,126.7	283,325.3	328,724.0	14.2%
өсөлт (%)	9.1%	6.2%	21.5%	53.0%	16.0%	
Төгрөгийн харилцах	77,814.9	116,754.9	146,776.7	307,146.3	331,892.3	14.3%
өсөлт (%)	-4.3%	50.0%	25.7%	109.3%	8.1%	
Бараг мөнгө	625,704.9	871,014.4	1,204,590.0	1,810,778.1	1,658,251.3	71.5%
өсөлт (%)	27.6%	39.2%	38.3%	50.3%	-8.4%	
Нийт хадгаламж	517,410.3	671,708.6	995,405.1	1,489,716.9	1,374,291.5	59.3%
өсөлт (%)	42.3%	29.8%	48.2%	49.7%	-7.7%	
Төгрөгийн хадгаламж	300,976.4	426,033.6	692,483.4	1,113,729.7	934,092.0	40.3%
өсөлт (%)	25.3%	41.6%	62.5%	60.8%	-16.1%	
Валютын хадгаламж	216,434.0	245,675.0	302,921.7	375,987.2	440,199.5	19.0%
өсөлт (%)	75.6%	13.5%	23.3%	24.1%	17.1%	
Валютын харилцах	108,294.5	199,305.8	209,184.9	321,061.2	283,959.8	12.2%
өсөлт (%)	-14.7%	84.0%	5.0%	53.5%	-11.6%	
Нийт мөнгө-M2	847,032.4	1,140,138.8	1,536,493.3	2,401,249.7	2,318,867.6	100.0%
өсөлт (%)	20.4%	34.6%	34.8%	56.3%	-3.4%	

Тайлант онд төгрөгийн бусад валюттай харьцах ханшийн өөрчлөлт, түүний ирээдүйн хүлээлтээс хамааран төгрөгийн хадгаламж болон валютын харилцах, хадгаламжийн өсөлт оны турш харилцан адилгүй байлаа. Төгрөгийн ам.доллартай харьцах ханш тогтвортой байсан сарууд буюу оны эхний 10 сард төгрөгийн хадгаламжийн жилийн өсөлт буурч байсан ч өсөлт нь эерэг буюу 1.3 хувь байсан бол сүүлийн 2 сард төгрөгийн ханш супарснаар төгрөгийн хадгаламжийн өсөлт оны эцэст -16.1 хувьд хүрчээ. Харин гадаад валютын харилцах, хадгаламж жилийн 3.9 хувиар өслөө.

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг байршуулалт талаас нь авч үзвэл тайлант оны эхний таван сард өмнөх оны адилаар нийт өсөлтийн дийлэнхийг гадаад цэвэр актив (ГЦА)-ын өсөлт хангаж байсан бол сүүлийн хагас жилд дотоод цэвэр актив (ДЦА)-ын өсөлт давамгайлах болов. Өмнөх жилүүдэд ГЦА-ын өсөлт нь дэлхийн зах зээл дээрх алт, зэсийн үнийн өсөлттэй холбоотойгоор гадаад цэвэр албан нөөцийн өсөлтөөр хангагдаж байсан бол тайлант онд тухайлбал, хоёрдугаар хагаст гол экспортын бүтээгдэхүүний үнэ буурсан, төгрөгийн ханш супарсан, улмаар гадаад валютын албан нөөц буурсан зэргээс шалтгаалж ГЦА буурав.



M1 мөнгө

Тайлант оны эцэст M1 мөнгө өмнөх оны мөн үеэс 11.9 хувь буюу 70.1 тэрбум төгрөгөөр өсч 660.6 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт мөнгөний 28.5 хувийг эзэлж байна. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө өмнөх оны мөн үеэс 43.1 тэрбум төгрөг буюу 11.8 хувиар өсч 407.2 тэрбум төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна. Банкнаас гадуурх мөнгө гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний 80.7 хувийг эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 2.9 нэгжээр өссөн байна. Мөн банкнаас гадуурх мөнгө M2-ын харьцаа 14.2 хувь болж, өмнөх оны мөн үеэс 2.4 нэгжээр өсчээ.


Сүүлийн жилүүдэд тасралтгүй хурдасч байсан мөнгөний нийлүүлэлтийн өсөлт 2008 оны туршид саарсан байна. Тухайлбал, 2007 оны эцэст жилийн 56.3 хувиар өсч байсан нийт мөнгөний өсөлт 2008 оны эцэст -3.4 хувь болж буурчээ. Энэ нь мөнгөний хумих бодлого болон дэлхийн эдийн засгийн хямралаас шалтгаалж хөрөнгийн гадагшлах урсгал явагдсан, банкууд эх үүсвэрийн дутагдалд орсон зэргээс хамаарсан байна. Бага мөнгө өнгөрсөн оны мөн үеэс 70.1 тэрбум төгрөгөөр өссөнөөс 35.3 хувь нь төгрөгийн харилцах дансны өсөлт, 64.7 хувь нь банкнаас гадуурх мөнгөний өсөлтөөр хангагджээ.

Гадаад болон дотоод цэвэр актив

Нийт мөнгийг 2008 оны эцсийн байдлаар байршуулалт талаас нь авч үзвэл дотоод цэвэр актив нь гадаад цэвэр активаас 2 дахин их байна. Гадаад цэвэр актив (ГЦА)-ын өсөлт 2007 онд удааширч, 2008 оны 2 дугаар сараас бусад саруудад өмнөх сартай харьцуулахад 0.6-20.4 хувиар багасч, харин оны эцэст 2.8 хувиар өсчээ. Тайлант онд гадаад валютын нөөц огцом багассан нь ГЦА буурахад нөлөөлсөн байна.


Дотоод цэвэр актив (ДЦА)-ын өөрчлөлтийг авч үзвэл 2005 онд их хэмжээний өөрчлөлт гараагүй, харин 2006 онд буурсан байна. Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн татвар буюу тухайлбал, алт, зэсийн үнийн өсөлтөөс хамаарсан 68.0 хувийн татварыг 2006 онд шинээр авч эхэлсэн. Энэхүү татварын орлогоор төсөвт хөрөнгө төвлөрч, улсын нэгдсэн төсөв ашигтай гарсан бөгөөд төсвийн хөрөнгийг банкны салбарт байршуулсан нь банкны салбарын Засгийн газраас авах цэвэр авлага буурахад нөлөөлж, улмаар ДЦА-ыг багасгасан байна. Харин ДЦА 2007 өссөн нь дотоодын зээлийн өсөлттэй холбоотой байв. 2008 оны эцэст банкны салбарын нэгдсэн дунгэрээр засгийн газраас авах авлага 2.5 тэрбум төгрөг, төвлөрсөн болон орон нутгийн төсвийн хөрөнгө 522.7 тэрбум төгрөг болж, засгийн газрын цэвэр зээлийн хэмжээ -520.2 тэрбум төгрөгт хүрчээ.

Засгийн газраас авах авлага банкны салбарын хэмжээгээр 2007 оноос 21.6 тэрбум төгрөгөөр буурч тайлант оны эцэст 2.5 тэрбум төгрөг болов. ДЦА өмнөх оны мөн үеэс 56.5 хувиар нэмэгдсэн нь өнгөрсөн оны өсөлтөөс 102.8 нэгжээр буурсан бөгөөд эх үүсвэрийн өсөлт саарсан нь ДЦА-ын өсөлт буурахад нөлөөлсөн байна.



Зураг 1.11.

Мөнгөний
нийлүүлэлтийн
өөрчлөлт,
өмнөх оны мөн
 $y_e=100\%$



Зураг 1.12.

ГЦА, ДЦА,
M2-ийн
жилийн өсөлт,
хувиар


Зураг 1.13.

Бараг мөнгө,
түүний бүтэц
(жилийн
өөрчлөлт)




Зураг 1.14.

Төгрөг,
валютын
хадгаламж
(сарын
өөрчлөлт)



Зураг 1.15.

Мөнгөний
уржуулэгчид
нөлөөлөх хүчин
зүйл (жилийн
өөрчлөлт)



Бараг мөнгө

Тайлант онд бараг мөнгө 152.5 тэрбум төгрөг буюу 8.4 хувиар буурч 1.7 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд нийт мөнгөний 71.5 хувийг эзэлж байна. Бараг мөнгө 2007 он хүртэл эдийн засгийн өсөлт, иргэд, аж ахуйн нэгжийн төгрөг, валютын хуримтлал, гадаадаас шилжин ирэх мөнгөн гүйвуулга нэмэгдэхийн хэрээр өсч байв. Харин тайлант онд дэлхийн зах зээл дээрх олборлох үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний үнэ буурч, Монголыг чиглэсэн гадаад валютын урсгал багасч, гаднын байгууллагууд манай банк, компаниудад өмнө нь өгсөн зээлээ эргүүлэн татсан, төлөвлөсөн хөрөнгө оруулалтын хугацаа хойшилсон, гадаадад амьдарч буй монголчуудын мөнгөн гүйвуулгын хэмжээ эрс буурсан зэргээс шалтгаалж төлбөрийн тэнцлийн алдагдал нэмэгдсэн байна. Бараг мөнгийг бүтцээр нь авч үзвэл, төгрөгийн хадгаламж оны эхнээс 16.1 хувиар буюу 179.6 тэрбум төгрөгөөр буурч, гадаад валютын харилцах хадгаламж 3.9 хувиар буюу 27.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Санхүүгийн хямралтай холбоотойгоор дэлхийн эдийн засгийн өсөлт саарч, эрдсийн бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрх үнэ ихээхэн хэмжээгээр буурсан нь манай орны гадаад худалдааны орлого багасч, худалдааны тэнцлийн алдагдал үлэмж хэмжээгээр нэмэгдэхэд нөлөөлжээ. Энэ нь төгрөгийн ханшийг ам.долларын эсрэг хүчтэй сурлах нөхцөл бүрдүүлж, улмаар бараг мөнгөний бүтцэд хүчтэй нөлөөлөв. Төгрөгийн хадгаламжийн бараг мөнгөнд эзлэх хувь хэмжээ өмнөх оныхоос 5.2 нэгжээр буурч 56.3 хувиig бүрдүүлэх болсон байна.

Тайлант оны эцсийн байдлаар нийт хадгаламжийн 68.0 хувь нь төгрөгөөр, 32.0 хувь нь валютаар байгаа нь 2007 онтой харьцуулбал төгрөгийн хадгаламж 6.8 нэгжээр буурсан бол валютын хадгаламж 6.8 нэгжээр өссөн байна. Энэ нь 2008 оны сүүлийн улиралд төгрөгийн ханшийн суралтаас шалтгаалан хадгаламж төгрөгөөс гадаад валютад шилжсэнтэй холбоотой.

Мөнгөний үржсуулэгч, мөнгөний эргэлтийн хурд

Мөнгөний юдьёдөөи őöдөй гэдэг нь эдийн засагт нийлүүлэгдэж буй мөнгө жилд хэдэн удаа эргэлтэнд орж байгааг илэрхийлдэг үзүүлэлт юм. Тайлант оны эцсийн байдлаар мөнгөний эргэлтийн хурд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.7 нэгжээр өсч 2.6 болсон нь мөнгөний нийлүүлэлт жилд дунджаар бараг 3 орчим удаа арилжаанд хэрэглэгдэж буйг илтгэж байна.

Тайлант онд *i%y'eé ðæz̥eýð ðóðä* гэдэг нь эдийн засагт нийлүүлэгдэж буй мөнгө жилд хэдэн удаа эргэлтэнд орж байгааг илэрхийлдэг үзүүлэлт юм. Тайлант оны эцсийн байдлаар мөнгөний үржүүлэгч ийнхүү буурсан нь тайлант оны хоёрдугаар хагаст мөнгөний нийлүүлэлтийн өсөлт нь нөөц мөнгөний өсөлтөөс бага байсантай холбоотой байна.

1.3 Валютын нөөцийн удирдлага

Монголбанкнаас 2008 оны санхүүгийн жилд гадаад валютын улсын нөөцийн хэмжээг нэмэгдүүлэх, эрсдэл багатай, үр өгөөжтэй санхүүгийн хэрэгслүүдэд байршуулах, удирдлагын оновчтой тогтолцоог бүрдүүлэх зэрэг чиглэлээр ажиллалаа. Уг ажлын хүрээнд 2008 онд дараах үндсэн гол арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн болно. Үүнд:

1. Өмнөх жилүүдэд Монголбанк гадаад валютын нөөцийг ихэвчлэн ам.доллараар байршуулдаг байсан бол 2008 онд нөөц байршуулах гадаад валютуудын хувь хэмжээг Монгол Улсын гадаад төлбөр тооцоо, импортын болон экспортын төлбөртэй уялдуулан тодорхойлсон нь гадаад валютын улсын нөөцийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг сайжруулж, гадаад төлбөр тооцоог ханшийн эрсдэлгүйгээр хийх боломжийг нээсэн.
2. Онгөрсөн жилүүдэд гадаад валютын улсын нөөцийг олон улсын банк санхүүгийн байгууллагуудад богино хугацаат хадгаламж хэлбэрээр байршуулах, санхүүгийн үүсмэл хэрэгслүүд болох форвард, опшин гэх мэт хэллцүүдийг ашиглах зэргээр удирдлаг байсан бол 2008 оноос эхлэн валютын нийт нөөцийг богино, урт хугацаат хөрөнгө оруулалт гэж хоёр хуваан, багцлан удирддаг боллоо. Ингэснээр валютын нөөцийн тодорхой хэсгийг АНУ, ХБНГУ-ын Засгийн газрын урт хугацааны үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийж ирээдүйд тохиож болох хүүний болон зах зээлийн эрсдэлээс сэргийлэх боломжтой болсон юм.

Дэлхийн зах зээл дээр нефтийн бүтээгдэхүүний үнэ өссөнтэй холбогдож Монгол Улсын импортын долоо хоногийн хэрэгцээ 2008 онд өмнөх оны мөн үеэс 1.9 дахин өсч гадаад валютын эрэлтийг нэмэгдүүлсэн, түүнчлэн дэлхий нийтэд болж буй эдийн засгийн хямралтай уялдан мөнгөн гүйвуулга, зээл, хөрөнгө оруулалтын хэлбэрээр орж ирдэг гадаад валютын орлого татарсан, манай экспортын гол бүтээгдэхүүний нэг зэсийн дэлхийн зах зээл дээрх үнэ огцом унасан нь гадаад валютын нийлүүлэлтэд муугаар нөлөөлж гадаад валютын нөөцийн хэмжээ багасах болон нөөцийн өгөөж буурахад шууд нөлөөлжээ.

Дээрх шалтгаануудын улмаас 2008 онд гадаад активын дүн 343.2 сая ам.доллараар багасч, мөн пассивын дүн 5.1 сая ам.доллараар буурснаар, гадаад валютын цэвэр албан нөөцийн хэмжээ 2008 оны эцсийн байдлаар 637.2 сая ам.долларт хүрлээ. Энэ нь манай улсын импортын 10.26 долоо хоног буюу 2.6 сарын хэрэгцээг хангахуйц хэмжээ юм.

Гадаад валютын энэхүү бууралтын 99.1 хувь нь нөөцийн бодит өөрчлөлт байсан бол 0.9 хувь нь валютын ханшийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Монголбанк алт олборлогч 104 аж ахуйн нэгж, давхардсан тоогоор 173 иргэдээс бохир жингээр 8.2 тонн, цэвэрт шилжүүлснээр 7.3 тонн алтыг 232.9 тэрбум төгрөгөөр шууд болон арилжааны банкуудаар дамжуулан худалдан авсан байна. Энэхүү худалдан авсан алтны бохир жинг өмнөх онтой харьцуулахад 2.38 хувиар буюу 0.2 тонноор буурчээ. Сүүлийн 3 жилд иргэд, аж ахуйн нэгжээс тушаах алтны хэмжээ буурсан дүнтэй байна.



Зураг 1.16.

Гадаад валютын
цэвэр албан
нөөцийн
хөдөлгөөн
/1999-2008/



Зураг 1.17.

Монголбанкинд
тушаасан алт
(бохир жингээр)

Гадаад валютын нөөцийн хэмжээ багассан, мөн гол валютын хадгаламжийн хүү буурсан учраас санхүүгийн хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн хүүний орлого 22 сая ам.доллар болж өнгөрсөн оноос 1.79 дахин буурсан байна. Харин мөнгөжсөн алт, гадаад валют, үнэт цаасны спот арилжааны орлого өмнөх оноос 62.5 дахин өсч 12.5 сая ам.долларт хүрлээ.

Тайлант онд нийт хөрөнгө оруулалтын дундаж үр өгөөж бэлэн валютыг оруулахгүйгээр жилийн 2.39 хувь, бэлэн валютыг оруулсаар жилийн 2.2 хувьтай байна. Энэ нь 2007 онтой харьцуулахад 1.74, 1.89 нэгжээр тус тус буурсан үзүүлэлт юм.

Гадаад валютын улсын нөөцийн эрсдэлийн удирдлага

Монголбанк нь гадаад валютын улсын нөөцийн удирдлагын найдвартай байдлыг хангах, хөрвөх чадварыг алдагдуулахгүй байх, үр өгөөжийг нэмэгдүүлэх гэсэн зарчмын дарааллаар хэрэгжүүлж ирлээ. Гадаад валютын улсын нөөцийн урт хугацаанд баримтлах эрсдэлийн удирдлагын бодлогын чиглэлийг тодорхойлон, хэрэгжилтэд өдөр тутмын хяналт тавин ажиллаж байна.

Тайлант онд Монголбанкны эрсдэлийн хүлээн зөвшөөрөгдөхүйц түвшинд гадаад валютын улсын нөөцийн бүтцийг батлан ажиллалаа. Гадаад валютын улсын нөөцийн тухайн жилд баримтлах бүтцийг тогтоох, түүнийг хэрэгжүүлэх явцад Монголбанкны Ерөнхийлөгчөөс гарах шийдвэрт мэргэжлийн зөвлөмжөгч, санал боловсруулах үүрэгтэй Хөрөнгө оруулалтын хороог 2008 онд байгуулан, үйл ажиллагааг тогтмолжуулаад байна. Ерөнхий бүтцийн хүрээнд гадаад валютын улсын нөөцийн активын бүтэц, гадаад валютын бүтэц, багцын бүтэц, урт хугацаатай хөрөнгө оруулалтын зохицой хугацаа, хөрөнгө оруулалтын боломжит хэрэгслүүдийг тус тус тодорхойлов. Мөн гадаад валютын улсын нөөцийн хөрөнгө оруулалтуудын зах зээлийн үнэлгээг тогтмол хийж, зах зээлийн эрсдэлүүдийг тооцох, зээлийн эрсдэл болон холбогдох лимитүүдэд хяналт тавих, дэлхийн зах зээлийн байдлыг байнга ажиглан холбогдох мэдээ тайлан бэлтгэх зэрэг ажлуудыг гүйцэтгэлээ.

2007 оны дунд үеэс эхэлсэн АНУ-ын үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн хямрал улам гүнзгийрч, дэлхийн санхүүгийн зах зээлийг бүхэлднь хамран улмаар бодит эдийн засгийн өсөлтийг сааруулаад байна. Тайлант онд зах зээлд үнэ, ханш өндөр хэлбэлзэлтэй байсан, гадаадын банк, санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа хүндэрсэн, дотоодын зах зээлийн байдал тогтвортгүй байсан зэрэгтэй холбоотой тодорхойгүй байдал нэмэгдсэн юм. Иймд гадаад валютын улсын нөөцийг түүний найдвартай байдал, төлбөр тургэн гүйцэтгэх чадварыг хангах зорилгоор биет хэлбэрээр байршуулсан алт, Төв банкууд дахь харилцах данс, Олон улсын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хадгаламж, Олон улсын төлбөр тооцооны банкны богино ба дунд хугацаатай үнэт цаас, АНУ-ын засгийн газрын урт хугацаатай үнэт цаас зэрэг эрсдэлгүй хөрөнгө оруулалтанд хийх чиглэлийг баримтлан ажиллалаа. Мөн зах зээлийн тодорхойгүй байдалтай холбоотой гадаад орны банк, санхүүгийн байгууллагуудад хөрөнгө байршуулах ажиллагааг түр хугацаанд зогсоох, тэдгээрт хөрөнгө байршуулах лимитийн хэмжээг бууруулах, алтыг биет хэлбэрт шилжүүлэн байршуулах зэрэг түр хугацааны арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн болно. Эдгээрийн үр дүнд харилцагчийн болон хөрөнгө оруулалтын хүндрэлтэй холбоотой аливаа эрсдэлийг Монголбанк хүлээгээгүй юм.

1.4 Төгрөгийн ханшийн хөдөлгөөн

Төгрөгийн нэрлэсэн хани

Гадаад эдийн засгийн нөхцөл байдал, макро эдийн засгийн суурь хүчин зүйлс, экспортын гол бүтээгдэхүүнүүдийн гадаад зах дээрх үнийн хандлага нь төгрөгийн ханшинд дарамт үүсгэснээр төгрөгийн ам.доллартай харьцах ханш суларч, 2008 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар оны эхнээс 8.3 хувиар буюу 97.54 төгрөгөөр суларч, 1267.51 төгрөгт хүрчээ. Экспортын гол бүтээгдэхүүн болох алт, зэсийн дэлхийн зах зээл дээрх үнэ өсч, манай улсын гадаад худалдааны нөхцөл сайжирснаар гадаад валютын дотогшлоо цэвэр урсгал 2004 оноос эхлэн нэмэгдэж, урсгал данс 2006 онд 372.2 сая ам.долларын, 2007 онд 171.8 сая ам.долларын ашигтай гарсан. Энэ нь төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2006 онд 4.6 хувиар чангач, 2007 онд 0.4 хувиар сулрах буюу харьцангуй тогтвортой байхад нөлөөлж байсан юм.

Төлбөрийн тэнцлийн урсгал дансны ашигтай байдал, Засгийн газраас хэрэгжүүлсэн бодлого нь улсын болон хувийн секторын орлогоос давсан хэрэглээг, ялангуяа улсын төсвийн нийгмийн халамжийн зардлыг хавтгайруулах, мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлж, банкны салбарын зээлийн огцом өсөлтийг урамшуулж улмаар эдийн засгийн бодит боломжоос давсан эрэлт буюу “эдийн засгийн халалт”-ыг сүүлийн жилүүдэд бий болгов. Гэтэл олон улсын санхүүгийн зах зээл хямарч, худалдааны нөхцөл огцом доройтсноос үүдэн төлбөрийн тэнцлийн урсгал данс 2008 оны 1 дүгээр улирлаас эхлэн алдагдалтай болж, 2 дугаар улиралд алдагдлын хэмжээ өссөн дүнгээр 170.4 сая ам.долларт хүрсэн нь гадаад валютын дотоодын зах дээрх валютын цэвэр эрэлтийг нэмэгдүүлж, төгрөгийн ам.доллартай харьцах ханш сулрахад хүчтэй нөлөө үзүүлэв.


Нөгөөталаастөсвийн зарлагын тэлэлт, импортын барааны үнийн өсөлттэй холбоотойгоор инфляцийн түвшин 2008 оны 2 дугаар улирлаас хурдацтай өсч, 5 дугаар сард жилийн 27.1 хувьд хүрсэн тул импортлогдож буй инфляцийн дарамтыг саармагжуулж, үнийн өсөлтийг бууруулах зорилгоор ханшийг тогтвортжуулах шаардлага гарч ирсэн.

Төлбөрийн тэнцлийн урсгал данс алдагдалтай хэдий ч санхүүгийн дансны хөрөнгө оруулалт, зээлийн дотогшлоо урсгалын илүүдлээр нөхөгдсөн хувьд нөхцөлд инфляцийн өсөлтийг хязгаарлах зорилтын хүрээнд дээрх бодлогыг хэрэгжүүлж, Монголбанкнаас 2008 оны эхний хагас жилд банк хоорондын захад 444.3 сая ам.долларыг нийлүүлснээр төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2008 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар оны эхнээс 1 хувиар буюу 11.85 төгрөгөөр чангараа. Сүүлийн хагас жилийн эхээр инфляцийн түвшин улам нэмэгдсэнээр Монголбанкнаас төгрөгийн нийлүүлэлтийг хумиж, ханшийг тогтвортой байлгах бодлогыг үргэлжлүүлэв. Банк хоорондын захад 7-10 дугаар саруудад нийт 329.6 сая ам.долларыг нийлүүлснээр төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2008 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар сүүлийн 5 жилийн хамгийн бага түвшин буюу 1143.78 төгрөгт хүрч чангараа. Энэ нь оны эхнээс 2.2 хувь, эхний хагас жилийн эцсээс 1.2 хувиар чангарсан үзүүлэлт юм.

Дээрх хугацаанд Засгийн газар, өрхийн орлогоосоо давсан хэрэглээ хангалттай түвшинд буураагүй, олон улсын санхүүгийн зах зээлийн хямрал улам гүнзгийрч, санхүүгийн дансны хөрөнгө оруулалт, зээлийн дотогшлох ургсал татарсан, экспортын гол бүтээгдэхүүнүүдийн үнэ, орлого буурсан хэвээр байсан нь ургсал дансны алдагдлыг 3 дугаар улиралд 215.9 сая ам.доллар, 4 дүгээр улиралд 290.7 сая ам.доллар, гадаад валютын цэвэр албан нөөцийг оны эцэст 637.2 сая ам.доллар болж буурахад хүргэсэн байна.


Төгрөгийн ханшинд нөлөөлөгч дээрх суурь хүчин зүйлс нь төгрөгийн ханш сулрах чиглэлд хүчтэй нөлөөлсөн хэвээр байсан, төгрөгийн ам.доллартай харьцах ханш чангарсан зэрэг шалтгаануудын улмаас төгрөгийн ам.доллартай харьцах ханш 11, 12 дугаар саруудад огцом буюу өдөрт дунджаар 0.24 хувиар суларч, оны эцэст 1267.51 төгрөгт хүрч 10 дугаар сарын 22-ны өдрийн ханшаас 10.8 хувиар буюу 123.73 төгрөгөөр суларчээ.

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш ийнхүү огцом сулрахад эдийн засгийн суурь хүчин зүйлсээс гадна гадаад валютын захын дэд бүтэц сул, мэдээллийн ургсал хязгаарлагдмал, дотоодын төлбөр тооцоонд ам.долларыг хэрэглэх явдал хавтгайрч, ам.долларын зохиомол эрэлтийг нэмэгдүүлсэн, иргэдийн дунд ханшийн сулралтын талаарх хүлээлт хүчтэй байсан зэрэг нь давхар нөлөөлсөн юм.



Зураг 1.18

Төгрөгийн
ам.доллартай
харьцах
ханшийн
жилийн
өөрчлөлт



Зураг 1.19

Төгрөгийн
ам.доллартай
харьцах
ханш – 2008
онд

2.1 Банкны салбарын богино болон дунд хугацааны стратегийн зорилт, түүний хэрэгжилт

Монголбанк нь банкны салбарын тогтвортой байдлыг хангах үүднээс банкуудын үйл ажиллагаанд хяналт тавихын зэрэгцээ банкуудын төлбөрийн чадвар, зохистой удирдлагыг сайжруулахад чиглэсэн богино болон дунд хугацааны дараах стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэхээр ажиллаж ирлээ. Үүнд:

1. Банк санхүүгийн байгууллагуудад хийх хяналт шалгалтыг сайжруулах ажлын хүрээнд банкинд илэрсэн зөрчил дутагдлыг залруулах, төлбөрийн чадваргүй болсон банкуудад авах албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх, банкны үйл ажиллагаатай холбоотой бүх төрлийн эрсдэлүүд, ялангуяа үйл ажиллагааны болон хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагад тавих хяналт шалгалтыг сайжруулах, банкны хянан шалгагчдын эрх ашгийг хамгаалах хууль эрх зүйн тогтолцоог нэвтрүүлэх, хяналт шалгалтын үйл ажиллагааны бие даасан байдлыг хангах, Олон улсын төлбөр тооцооны банкнаас гаргасан Basel II стандартыг нэвтрүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.

Тайлант онд Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан удирдамжийн дагуу 16 банкинд газар дээрх иж бүрэн шалгалтыг банкуудын санхүү, төлбөрийн чадварын байдалд анхаарал хандуулан хийж гүйцэтгэн, шалгалтын дүнг Монголбанкны Захирлуудын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулж, биелэлтэд нь хяналт тавин ажиллав.

Иж бүрэн шалгалтын хүрээнд хөрвөх чадварын, зээлийн, банкны ерөнхий эрсдэлийн түвшин өндөр гэж тогтоогдсон банкуудын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх зорилгоор өөрийн хөрөнгийн зохистой харьцааны үзүүлэлтийн байвал зохих доод хэмжээг 2 нэгжээр нэмэгдүүлэн 12 хувь болгох шаардлагыг хэрэгжүүлэв. Үүний зэрэгцээ Анод банкинд 2008 онд хийсэн шалгалтаар тухайн банкны зээлийн ангилал үнэн зөв хийгдээгүй, өөрийн хөрөнгө нь алдагдсан, ихээхэн хэмжээний алдагдал авлагыг нуун дарагдуулсан зэрэг ноцтой зөрчил дутагдал илэрсэн тул Банкны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн дагуу онцгой дэглэм тогтоон, бүрэн эрхт төлөөлөгчийг томилон албадлагын арга хэмжээ авлаа. Түүнчлэн, 2008 онд есөн банкинд газар дээрх хэсэгчилсэн шалгалтыг хийж гүйцэтгэлээ. Банкны салбарын хувьд хамгийн эрсдэл бүхий үйл ажиллагааны төрөл болох зээл, гадаад тооцооны үйл ажиллагаанд давхардсан тоогоор 11 удаа хэсэгчилсэн шалгалт хийлээ.

Банкинд зайнаас хяналт тавих үйл ажиллагаагаар банкнаас ирүүлсэн мэдээлэл, тэдгээрийн динамик үзүүлэлт болон ашигт ажиллагаа, активын чанарыг илэрхийлэх үзүүлэлтүүдэд үндэслэн санхүү төлбөрийн чадварын байдалд дүгнэлт өгч, холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ аван ажиллаж байна.

Банкны хөрвөх чадварын удирдлагыг сайжруулан төлбөр түргэн гүйцэтгэх чадвар муудсаны улмаас банкинд итгэх олон нийтийн итгэлийг алдуулахгүй байх нь тухайн жилийн банкны салбарын гол асуудал байв. Иймд банкуудын хөрвөх чадварын удирдлагыг сайжруулах үүднээс Монголбанкны Ерөнхийлөгчийн 2008 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн 239 дугаар тушаалаар “Хөрвөх чадварын эрсдэлийг удирдах зөвлөмж”-ийг баталсан. Энэхүү зөвлөмжийн дагуу банкуудад дотооддоо хөрвөх чадварын эрсдэлийг удирдах бодлого, стратеги, заавар журмыг

боловсруулан мөрдөж ажиллахыг даалгасан бөгөөд газар дээрх болон зайнаас тавьж буй хяналт шалгалтын хүрээнд хөрвөх чадварын удирдлагад нь тогтмол үнэлгээ дүгнэлт хийж байна.

Монголбанкнаас санал болгосны дагуу “Санхүүгийн салбарын үнэлгээний хөтөлбөр”-ийг Базелийн банкны хяналт шалгалтын хорооноос батлан гаргасан “Базелийн банкны үр ашигтай хяналт шалгалтын үндсэн зарчим”-д үндэслэн санхүүгийн салбарын өнөөгийн байдал болон хууль эрх зүйн орчны талаар үнэлгээ өгч, ололттой болон дутагдалтай талуудыг танин мэдэж, олон улсын түвшинд хүрэхэд цаашид хийх шаардлагатай ажлын талаар зөвлөгөө өгөх зорилгоор Олон улсын валютын сан болон Дэлхийн банк хамтран 2007 онд Монгол Улсад анх удаа хэрэгжүүлсэн билээ. “Санхүүгийн салбарын үнэлгээний хөтөлбөр”-ийн тайлангаас үзвэл Монгол Улстай нийгэм, эдийн засгийн хөгжлийн хувьд ойролцоо түвшний улс орнуудтай харьцуулахад манай улсын санхүүгийн салбар харьцангуй сайн үнэлгээтэй байна. Уг нэгтгэлд ашигласан банкуудын үйл ажиллагаанд тогтвортой байдлын шинжилгээ (stress testing)-гээр банкны салбарын төлбөрийн чадварын үзүүлэлтүүд болон эрсдэл даах чадвар сайн байна гэсэн дүгнэлтэд хурч байгаа хэдий ч эдийн засгийн хүчтэй цочрол, хэлбэлзэл үүсэхэд банкуудын өөрийн хөрөнгө болон төлбөрийн чадварын үзүүлэлтүүд муудаж болзошгүй тул эдгээр үзүүлэлтүүдийн байвал зохих доод түвшинг нэмэгдүүлэх шаардлагатай болсон. Түүнчлэн, “Базелийн банкны үр ашигтай хяналт шалгалтын үндсэн зарчим”-ын хэрэгжилтийн хувьд нийт 25 зарчмын ихэнх хэсгийн биелэлт хангалттай түвшинд хэрэгжиж байна гэсэн дүгнэлт хийгдсэн. Энэ нь Монголбанкны хяналт шалгалтын үйл ажиллагаа нь олон улсын стандартад дөхөж очсоныг илтгэж байна.

2. Банкнаас санал болгож буй бүтээгдэхүүн, үзүүлж буй үйлчилгээнд тогтоосон үнэ, хүүний түвшинд төрийн эрх бүхий байгууллагаас зохицуулалт хийх бодит шаардлага гарахаас бусад тохиолдолд хязгаарлалт тогтоохгүй байх, банкны удирдлага болон зээлийн үйл ажиллагаанд зүй бусаар оролцохгүй.

Арилжааны банкууд зах зээлийн зарчмын дагуу бүтээгдэхүүн, үйлчилгээндээ үнэ тогтоож, зээлийн болон бусад үйл ажиллагаагаа явуулахдаа Монголбанк болон бусад төрийн байгууллагуудаас хараат бус бие даасан байдлаа хадгалж ирсэн. Харин 2008 онд санхүүгийн салбар хямарч магадгүй гэсэн болгоомжлолоос үүдэн харилцагч, хадгаламж эзэмшигчдийн зүгээс банкнаас хөрөнгөө татах хандлага гарснаар эх үүсвэрийн хомсдол бий болж банкуудын хувьд үйл ажиллагаагаа хэвийн явуулахад тодорхой хүндрэлүүд үүсч эхэлсэн. Эх үүсвэр татан төвлөрүүлэхийн төлөө санхүүгийн байгууллагууд хоорондоо шударга бусаар өрсөлдөх буюу банкны санхүүгийн нөхцөл байдал, эрсдэлийн түвшинг тооцохгүйгээр хэт өндөр хүү тогтоо байдал ажиглагдаж байгаа тул банкны салбарын тогтвортой байдлыг хангах үүднээс Монголбанкнаас арилжааны банкуудын удирлагуудад энэ талаар анхаарч ажиллахыг мэдэгдэв.

3. Банкны салбарын хөрвөх чадварын үзүүлэлтийг таамаглах, эрсдэлийг удирдах, санхүүгийн салбарын хүндрэлийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг (contingency planning) боловсруулж хэрэгжүүлэх аргачлалыг боловсруулна.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2008 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн тушаалаар “Хөрвөх чадварын эрсдэлийг удирдах зөвлөмж”-ийг баталж, зөвлөмжийн утга, агуулгын талаар нэгдсэн ойлголтуудыг өгөх зорилгоор банкуудад сургалт семинар зохион байгууллаа. Уг зөвлөмжийн дагуу банкууд нь хөрвөх чадварын удирдлагын бодлого, стратеги, журам зааврыг болон хүндрэлийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан Монголбанкинд ирүүлээд байна. Энэхүү журам, төлөвлөгөө нь бодит байдалд нийцэж, хэрэгжих боломжтой эсэх тал дээр дүгнэлт хийж, төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт хийх шаардлагатай банкуудад үүрэг даалгавар өгч, сайжруулах талаар хамтран ажиллаж байна.

Улсын Их Хурлаас 2008 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр “Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хууль”-ийг батлан гаргасан бөгөөд энэхүү хуулинд зааснаар тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа арилжааны банкинд хадгалуулсан мөнгөн хөрөнгөнд 2012 оныг хүртэл 4 жилийн хугацаанд терөөс баталгаа (blanket guarantee) гаргаж буй юм.

4. Санхүүгийн салбарын үйл ажиллагааг гүнзгийрүүлэх, хууль эрх зүйн тогтолцоог сайжруулах ажлын хүрээнд одоо мөрдөгдөх буй хууль тогтоомж, заавар журамд өмчийн, иргэний, компанийн болон санхүүгийн эрх зүйтэй холбоотой харилцааг зохицуулах нэмэлт өөрчлөлтүүдийг оруулж, шинээр боловсруулж, батлуулна.

Санхүүгийн салбарын дэд бүтэц болох хууль эрх зүйн орчин болон хяналт шалгалтын үйл ажиллагааг сайжруулах үүднээс 2007-2008 онд дараах хууль эрх зүйн баримт бичгүүдэд нэмэлт өөрчлөлт оруулах, шинээр боловсруулах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Банкны тухай болон Төв банкны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулж Улсын Их Хуралд өргөн барьсан. Сүүлийн жилүүдэд Монголын банкуудын уламжлалт үйл ажиллагаа өөрчлөгдөн дэлхийн зах зээл дээрх шинэ төрлийн үйл ажиллагаа руу чиглэгдэж байгаа болон олон улсын стандартуудыг банкны удирдлага болон банкинд тавьж байгаа хяналт шалгалтын үйл ажиллагаанд хэвшүүлэх зайлшгүй шаардлагын улмаас банкуудын хөрөнгийн зах зээл дээрх үйл ажиллагаа, нэгдсэн хяналт шалгалт болон зохистой удирдлагын тогтолцоог зохицуулах харилцааг банкны тухай хуулинд тусгахаар хуулийн төсөлд орууллаа.

“Хөрвөх чадварын эрсдэлийг удирдах зөвлөмж”-ийг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар баталж, зөвлөмжийн утга, агуулгын талаар нэгдсэн ойлголтуудыг өгөх зорилгоор банкуудад сургалт семинарыг зохион байгуулав.

Хадгаламжийн даатгалын тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн барьсан.

Зээлийн мэдээллийн сангийн шинэ программ хангамжийг боловсруулж байгаатай уялдуулан “Зээлийн мэдээллийн сангийн журам”-ыг шинэчлэн боловсруулах ажил хийгдэж байна.

“Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, хяналт тавих журам”-ыг шинэчлэн баталсан. Шинэчилсэн журмаар банкуудын тогтвортой үйл ажиллагааг хангах, эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх зорилгоор

өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийг нэгдүгээр зэрэглэлийн болон нийт өөрийн хөрөнгийн хувьд харгалzan 5 байсныг 6 хувь болгож, 10 хувь байсныг 12 хувь болгож нэмэгдүүлэн тогтоолоо. Түүнчлэн, гадаад валютын эрсдэлийг “Хамгийн их эрсдэлийн арга”-аар тооцож үнэлэх зөвшөөрлийг авахад банкинд тавих шалгууруудыг нэмэгдүүлэв.

Сүүлийн үед ажиглагдаж буй дэлхийн санхүүгийн хямралын үед Монголын банк санхүүгийн байгууллагуудын тогтвортой байдлыг хангах, төлбөрийн чадварын хүндрэлтэй банкуудад хөрөнгөө байршуулсан хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор “Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хууль”-ийг батлуулав.

5. Банкны салбарын тогтвортой байдлыг хангах, эрсдэл даах чадварыг сайжруулах зорилгоор оновчтой хөрөнгө оруулагчдыг татах, дүрмийн сангаа нэмэгдүүлэхэд банкуудад дэмжлэг үзүүлж, банк санхүүгийн байгууллагын зохистой удирдлагыг сайжруулах ажлыг үргэлжлүүллээ.

Банкны дүрмийн санд нэмж хөрөнгө оруулах, хувьцааг бусдад бэлэглэх, худалдах замаар шинээр хувь нийлүүлэгчдийг бүртгүүлэх хүсэлтүүдэд Банкны тухай хууль болон “Банк, түүний нэгж байгуулах зөвшөөрлийн журам”-ын холбогдох заалтуудын дагуу тодорхой шалгуурыг хангасан (fit and proper test) эсэхийг хянан үзэж, хариуг тухай бур Монголбанкаас өгч байлаа. Ингэхдээ мөнгө угаах, терроризмийн үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилготой, шударга бус өрсөлдөөнийг нэмэгдүүлэх болон санхүүгийн тогтвортой байдлыг алдагдуулж болзошгүй, шаардлага хангагүй хөрөнгө оруулагчдын хүсэлтийг буцаах, дотоодын санхүүгийн зах зээлд нэвтрүүлэхгүй байх зарчмыг баримталж ажиллалаа. Харин тайлант онд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, нэр хүнд бүхий банк санхүүгийн үйл ажиллагаагаар мэргэшсэн Европын сэргээн босголт хөгжлийн банк (EBRD), Олон улсын санхүүгийн корпораци (IFC), Кредит Свисс (Credit Swiss) зэрэг байгууллагуудаас хөрөнгө оруулалт хийхээр ирүүлсэн хүсэлтүүдийг хянан үзэж, холбогдох зөвшөөрөл олгосон байна.

Дээр дурдсан “Санхүүгийн салбарын үнэлгээний хөтөлбөр”-ийн дүгнэлтэд банкуудад зохистой удирдлагыг бодитойгоор хэрэгжүүлэхэд манайд тулгараад буй гол бэрхшээл бол арилжааны банкуудын дээд түвшний удирдлага зохистой удирдлагын талаар нэгдсэн ойлголтгүй байгаа явдал гэжээ. Банкны удирдлагуудыг зохистой удирдлагын талаар нэгдсэн ойлголттой болгох ажлын хүрээнд Монголбанк Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (JICA)-тэй хамтран *Ààïéíû ïðæéàðûí ÷àäàððééä ïàéæðóóëàð, ðåðíééðéééí ðàïðûí àæéëéàðàáíû ð°ñéééä* хэрэгжүүлж байна. Энэ төслийн хүрээнд Монголбанкаас 2006 онд гаргасан “Банкны зохистой удирдлагын зарчмуудыг хэрэгжүүлэх журам”-ын биелэлтийг бодитоор үнэлэх боломжийг бий болгох зорилго бүхий энхүү журмын заалтуудын талаарх дэлгэрэнгүй тайлбар бүхий зөвлөмж, зохистой удирдлагын хэрэгжилтийг үнэлэх аргачлалуудыг тус тус боловсруулж, Хяналт шалгалтын газрын хянан шалгагч, банкуудын Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага болон дотоод аудитын нэгжийн холбогдох албан тушаалтнуудад дээрх баримт бичгүүдийн утга агуулгын талаар нэгдсэн сургалт зохион байгууллаа.

2.2 Банкны салбарын үндсэн үзүүлэлтүүд

Банкны салбарын нийт татан төвлөрүүлсэн хөрөнгө тайлант онд 3.3 их наяд төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 301.8 тэрбум төгрөг буюу 10.0 хувиар өссөн хэдий ч санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа тодорхой хэмжээгээр саарах хандлагатай байлаа. Нийт харилцахын дүн 2.0 хувиар буурч 615.9 тэрбум төгрөгт хүрсэн бол нийт хадгаламж 7.7 хувиар буурч 1374.3 тэрбум төгрөгт хүрсэн байна. Харин хадгаламжийг валютын төрлөөр нь задалж үзвэл, ам.долларын хадгаламж 12.3 хувиар, төгрөгийн хадгаламж 16.1 хувиар буурсан нь бусад валютын хадгаламжтай харьцуулахад хамгийн өндөр үзүүлэлтэд тооцогдож байна. Иргэдийн хугацаатай хадгаламж 93.7 тэрбум төгрөг буюу 10.3 хувиар, хугацаагүй хадгаламж 69.4 тэрбум төгрөг буюу 15.6 хувиар буурсан байхад улсын байгууллага, хувийн хэвшил болон санхүүгийн байгууллагууд зэрэг бусад хадгаламж эзэмшигчдийн хувьд харьцангуй тогтвортой буюу бага хэмжээгээр өсөх хандлагатай байжээ. Энэ нь бусад хадгаламж эзэмшигчдтэй харьцуулахад эдийн засагт үүсээд буй одоогийн нөхцөл байдалд иргэд хамгийн мэдрэмж өндөртэй байгааг харуулж байна.

Зарласан хүү хугацаагүй хадгаламжийн хувьд өнгөрсөн онтой харьцуулахад 1.7 нэгжээр өсч жилийн 12 хувьд, хугацаатай хадгаламжийн хувьд 0.1 нэгжээр өсч 19.4 хувьд тус тус хүрчээ. Оны эцсийн байдлаар хадгаламжийн бодит төлөгдсөн хүү 11.9 хувь байгаа бөгөөд сүүлийн 2 жилийн дундаж хэлбэлзэл 0.19 хувьтай байлаа. Энэхүү хэлбэлзэл нь өмнөх оноос 0.03 нэгжээр бага байгаа тул хадгаламжийн хүү харьцангуй тогтвортой байна гэсэн дүгнэлтэд хургэж буй юм.

Ийнхүү банкуудын харилцах, хадгаламж хэлбэрээр татан төвлөрүүлсэн хөрөнгө буурахын хэрээр үүсээд байгаа эх үүсвэрийн дутагдлыг нөхөх шаардлагын үүднээс банк хоорондын захын үйл ажиллагаа тодорхой хэмжээгээр идэвхэжжээ. Өөрөөр хэлбэл, эх үүсвэрт эзлэх хувь хэмжээгээрээ харилцах, хадгаламжийн дараа ордог банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр 2008 оны эцэс гэхэд өнгөрсөн оныхоос 68.3 хувиар буюу 239.5 тэрбум төгрөгөөр нэмэгдэв. Энэхүү өсөлтийн дийлэнх хувийг Монголбанкаас авсан зээлийн өрийн үлдэгдэл бүрдүүлж байгаа нь банкууд эх үүсвэрийн дутагдлаа нөхөхийн тулд зах зээл дээрх харьцангуй өндөр өртөг бүхий эх үүсвэрт найдах хандлагыг бий болгож буйг илтгэж байна.

Банк санхүүгийн зуучлал хумигдахын хэрээр банкны ашигт ажиллагаа тодорхой хэмжээгээр багасч өөрийн хөрөнгө 9.5 хувиар буюу 35.8 тэрбум төгрөгөөр буурахад хүргэлээ. Банкны салбар 2008 онд нийт 66.9 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байдалд Анод банкны үйл ажиллагаа эрс муудсан тул газар дээр нь шалгалт хийж тогтоосон их хэмжээний эрсдэлийн санг холбогдох журам, зааврын дагуу байгуулсан нь томоохон нөлөө үзүүллээ. Мөн гадаад валютын ханш өндөр хэлбэлзэлтэй байгаагаас зарим богино позицтой банкууд шууд алдагдал хүлээсэн нь тодорхой нөлөөллийг үзүүлжээ. Харин Анод банкны алдагдлыг банкны салбарын ашигт ажиллагаанд оруулахгүйгээр тооцвол салбарын хэмжээгээр 64.1 тэрбум төгрөгийн ашигтай ажиллажээ.

Манай улсын эдийн засгийн өсөлт тодорхой хэмжээгээр саарч эхэлсэн нь банкны салбарын тэнцлийн актив талын үзүүлэлтүүдийн өөрчлөлтөөс давхар харагдаж байна. Нийт актив 2007 онд жилийн 45.9 хувиар буюу 1063.8 тэрбум төгрөгөөр өсч байсан

бол тайлант онд нийт активын өсөлтийн хурд 7.9 хувь болж 5.8 дахин буурсан байна. **Түүнчлэн, банкны салбарын нийт активын ДНБ-д эзлэх хувь хэмжээ 14.1 нэгжээр буурч 59.5 хувьд хүрэв.**

Монгол Улсын санхүүгийн зах зээл дээр нийт 16 банк, 1 гадаадын банкны төлөөлөгчийн газар нийт 1080 салбар, нэгжээр дамжуулан санхүүгийн зуучлалын үүрэг гүйцэтгэж байна. Өмнөх онтой харьцуулахад банкны салбарын нийт харилцагч иргэд, байгууллагуудын тоо 20.1 хувиар өсч 2.4 саяд, зээлдэгчдийн тоо 5.4 хувиар өсч 516.8 мянгад, хадгаламж эзэмшигчдийн тоо 11.2 хувиар өсч 1.3 саяд тус тус хүрлээ.


Хэдийгээр тайлант онд банкуудаас олгосон зээлийн өсөлтийн хурд өмнөх онуудтай харьцуулахад удааширсан байгаа боловч өмнөх оноос цэвэр дүнгээр 453.5 тэрбум төгрөг буюу 21.4 хувиар өссөн байна. Ингэснээр нийт активт орлого авчирдаг активын эзлэх хувь хэмжээ өмнөх оноос 5.4 нэгжээр өсч 74.5 хувьд хүрчээ. Гэхдээ мөнгөн хөрөнгө болон богино хугацаат хөрөнгө оруулалт мөнгөн дүнгээрээ буурахын зэрэгцээ нийт активт эзлэх хувийн жин нь 0.7 болон 6.4 нэгжээр тус тус буурчээ.

Харин Монголбанкны үнэт цаасны үлдэгдлийг өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад 25 хувиар өсч 120.6 тэрбум төгрөгт хүрсэн нь богино хугацаат хөрөнгө оруулалтын 94.8 хувийг эзэлж байна.

Тайлант оны эцсийн байдлаарх зээлийн бутцийг эдийн засгийн салбараар нь ангилан үзэхэд 22.7 хувь нь худалдаа үйлчилгээний салбарт, 29 хувь нь боловсруулах болон барилгын салбаруудад, 6.4 хувь нь уул, уурхайн салбарт, 2.6 хувь нь хөдөө аж ахуйн салбарт олгогдсон байна. Өмнөх оны эцэстэй харьцуулахад хөдөө аж ахуйн салбарт олгосон зээлийн нийт зээлийн багцад эзлэх хувийн жин 5 нэгжээр буурсан нь 2008 онд гарсан байгалийн гамшгийн улмаас хөдөө аж ахуйн зээлийн эрсдэл ихээхэн хэмжээгээр нэмэгдсэнтэй холбоотой юм. Нэг жилээс дээш жилийн хугацаатай зээлийн хэвийн зээлд эзлэх хувь хэмжээ 61.8 хувь байна.


Харилцах хадгаламж ихээхэн хэмжээгээр 2008 оны 4 дүгээр улиралд гадагшилсан нь санхүүгийн зуучлалын үйл ажиллагааны цар хүрээг хумиж, улмаар үл хөдлөх хөрөнгийн борлуулалтыг бууруулах замаар нийт зээлийн багцын багагүй хувийг эзэлж буй барилгын салбарт зогсонги байдлыг үүсгээд байгаа бөгөөд энэ нь эргээд зээлийн багцын чанарт тодорхой сөрөг нөлөөг үзүүлж байна.

Хэдийгээр дээр дурдагдсан нөхцөл байдлаас эх үүсвэрийн хүү өсөх хандлага гарсан, урт болон дунд хугацаанд банкны салбар дахь өрсөлдөөн нэмэгдэж байгаатай холбоотойгоор зээлийн хүүний ерөнхий түвшин буурч улмаар хүүний цэвэр зөрүү багассан байна. Хүүний цэвэр зөрүү буюу 2008 онд бодитоор орсон, гарсан зээл, хадгаламжийн хүүний зөрүү 5.8 хувь байгаа нь өмнөх оноос 0.6 нэгжээр буурчээ. Жилийн эцсийн байдлаар жигнэсэн дундаж хүү төгрөгийн зээлийнх 20.4 хувь, гадаад валютын зээлийнх 16.8 хувь байсан бол хугацаатай хадгаламжийн хүү 2.4-19.4 хувийн болон хугацаагүй хадгаламжийнх 4.8-12.0 хувийн хооронд байлаа. Тайлант онд инфляцийн түвшин өндөр байсан, зээлийн бүтээгдэхүүний нийлүүлэлт буурсан зэргээс шалтгаалан 2008 оны эцсийн байдлаарх төгрөгийн зээлийн зарласан хүүний жигнэсэн дундаж өмнөх онтой харьцуулахад 0.5 нэгжээр өсчээ.




Зураг 2.1.

Банкуудын
харилцах,
хадгаламж,
түүний ДНБ-д
эзлэх хувь



Зураг 2.2.

Банкны
салбарын эх
үүсвэрийн
бүтэц




Зураг 2.3.

ДНБ-д эзлэх
банкны салбарын
нийт актив


Зураг 2.4.


Банкны
салбарын
активын
бүтэц



Зураг 2.5.


Банкуудын
зээлийн өрийн
үлдэгдлийн
эдийн засгийн
салбарт эзлэх
байдал





Зураг 2.6.

Зээлийн зарласан хүний жигнэсэн дундаж ба полиминаль хандлага



Зураг 2.7.

Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувийн жин

Дэлхийн зах зээл дээр эрдэс металлын үнэ буурсан, ихэнх улс орнууд санхүүгийн хямралд орсон болон дотоодын эдийн засгийн хумигдалтай холбоотойгоор банкуудын зээлийн эрсдэл тодорхой хэмжээгээр нэмэгджээ. Сүүлийн 5 жилийн турш чанаргүй зээлийн нийт зээлийн багцад эзлэх хувийн жин тогтмол буурах хандлагатай байсан бол 2008 онд энэхүү үзүүлэлт 7.2 хувь буюу 188.7 тэрбум төгрөгт хүрсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад 2.2 дахин өссөн байна. Нийт чанаргүй зээлийн 36.8 хувь буюу 69.4 тэрбум төгрөг нь муу зээлд ангилагджээ. Харин банкны салбарын үзүүлэлтүүдэд томоохон сөрөг нөлөө үзүүлсэн Анод банкны үзүүлэлтүүдийг хасч тооцвол чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 78.8 тэрбум төгрөг болж чанаргүй зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь хэмжээ 3.2 хувь болж буурч байна.

2.3. Банкны хяналт шалгалт


Өөрийн хөрөнгийн зохицой харьцаа

Тайлант оны эцсийн байдлаар банкны салбарын хэмжээгээр өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа 2.8 нэгжээр буурч 11.4 хувьд хүрчээ. Эдийн засагт үүссэн тодорхой бус нөхцөл байдал нь банкуудын шийдвэр гаргалтыг зогсонги байдалд оруулж зээл олголтыг багасгасан, инфляцийн огцом өсөлт нь харилцах, хадгаламжийг ихээхэн хэмжээгээр бууруулсан, эх үүсвэрийн эрчимтэй бууралт нь зээлдэгч байгууллагуудын зээлийн эргэн төлөлтийг удаашруулж, зээлийн чанар муудах хандлагатай болсон зэрэг нь өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийг бууруулахад нөлөөлжээ. Харин Анод банкны үзүүлэлтүүдийг хасч тооцвол өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт өмнөх оноос 1.1 нэгжээр өсч 15.3 хувь болжээ. Гэхдээ өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт өмнөх оноос ийнхүү буурсан байгаа хэдий ч Базелийн хорооны стандарт буюу 8 хувиас өндөр хэвээр байгаа юм.

Хөрвөх чадвар

Банкны салбарын нийт активын 25.6 хувь 2008 оны эцсийн байдлаар нэгээс дээш жилийн хугацаатай байна. Актив хөрөнгийн эргэн төлөгдөх дундаж хугацаа 9.2 сар байгаа нь өмнөх оноос 1.5 сараар нэмэгдсэн үзүүлэлт байлаа. Энэ нь нийт зээлийн 33 хувийг дунд болон урт хугацааны төслийн санхүүжилтэд зарцуулсантай шууд холбоотой юм. Харин банкуудын эх үүсвэрийн дийлэнх хэсэг буюу 69.7 хувь нь 1 жил хүргэл хугацаатай байгаа бөгөөд нийт пассивын эргэн төлөгдөх дундаж хугацаа өмнөх оноос 1.5 сараар нэмэгдэж 5.7 сар болжээ. Үүнээс банкуудын харьцангуй тогтвортой эх үүсвэр болох хугацаатай хадгаламжийн эргэн төлөгдөх дундаж хугацаа 7 сар байгаа юм.

Банкны салбарын хөрвөх чадварын үзүүлэлт өмнөх оноос 6.7 нэгжээр буурч 23.9 хувь болсон нь эх үүсвэр сүүлийн хагас жилд ихээр гадагшилж байсантай холбоотой байлаа. Монголбанкаас банкуудын хөрвөх чадварын удирдлагыг сайжруулах болон дэмжих үүднээс санхүүгийн зах зээл дээр хэд хэдэн бүтээгдэхүүнийг нэмж гаргасны зэрэгцээ банкуудын боловсон хүчиний чадавхийг сайжруулах тал дээр анхааран ажиллаж байна.



Зураг 2.8.

Өгийн
хөрөнгийн
зохицой
харьцаа



Зураг 2.9.

Гадаад актив,
пассивын нийт
актив, пассивт
эзлэх хувийн
жин

Тухайлбал, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2008 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн тушаалаар “Хөрвөх чадварын эрсдэлийг удирдах зөвлөмж”-ийг гаргасан. Түүнчлэн, дотоодын банк хоорондын зах дээр урвуу репо, гадаад валютын своп, барьцаат зээл зэрэг санхүүгийн хэрэгслүүдийг шинээр нэвтрүүлсэн байна.

Гадаад валютын эрсдэлийн үзүүлэлт

Монголбанкнаас тогтоосон журмын дагуу арилжааны банк нь гадаад валютын нээлттэй позици, өөрийн хөрөнгийн харьцааг нэг валютын хувьд +/-15 хувийн дотор, нийт нээлттэй позицийн хувьд +/-40 хувийн дотор барьж байх ёстой. Тайлант оны эцсийн байдлаар банкны салбарын гадаад валютын зохистой харьцааны нэгдсэн үзүүлэлт 6.9 хувьтай байгаа нь Монголбанкнаас тогтоосон хязгаарыг хангаж байгаа юм.

Гадаад валютын актив 2008 онд 11.9 хувь буюу 152.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 1426.5 тэрбум төгрөгт хүрсэн бол гадаад валютын пассив 41.4 хувь буюу 425.1 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 1458.4 тэрбум төгрөгт хүрчээ. Харин бүтцийн хувьд авч үзвэл, гадаад валютын активын нийт активт эзлэх хувийн жин 0.4 нэгжээр өсч 39.3 хувь болсон бол гадаад валютаар илэрхийлэгдсэн пассивын хувийн жин 8.7 нэгжээр өсч 40.2 хувьтай болжээ. Энэ нь манай улсын эдийн засгийн долларжих хандлага үргэлжилсээр байгааг илтгэж байна.

Гадаад валютаар олгосон зээлийн өрийн үлдэгдэл 911.6 тэрбум төгрөг байгаа нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 33.6 хувийг эзэлж байгаагаас 83.6 хувь нь ам.доллараар олгосон зээл байна. Түүнчлэн, нийт гадаад валютын зээлийн 5.4 хувь нь чанаргүй зээлд ангилагдсан бөгөөд энэ нь өмнөх оноос 2.3 нэгжээр өссөн үзүүлэлт юм. Өөрөөр хэлбэл, ам.долларын ханшийн өсөлт нь гадаад валютаар зээл авсан зээлдэгчдийн төлбөрийн чадварт сергөөр нөлөөлж **улмаар банкуудын зээлийн багцын чанар муудахад багагүй нөлөө үзүүлэхээр** байна.

ТӨВ БАНКНЫ БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА

Удирдлага, зохион байгуулалт

Төв банк нь 7 газар, 2 бие даасан алба, орон нутаг дахь Монголбанкны 17 салбар, Лондон дахь төлөөлөгчийн газар бүхий бүтэц зохион байгуулалтаар үйл ажиллагаа явуулж байна. Банкны сургалтын төв Монголбанкны удирдлагад ажиллаж байна. Монголбанкинд нийт 336 ажилтан ажиллаж байгаагийн 177 буюу 52.7 хувь нь эрэгтэй, 159 буюу 47.3 хувь нь эмэгтэй ажилтан байна. Нийт ажилтнуудын 71.7 хувь нь Төв аппаратад ажиллаж байна.

Ажилтнуудын мэргэжил мэдлэгийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн түвшинд хүргэх, сурч боловсрох эрхийг хангаж олон улсын байгууллага, өндөр хөгжилтэй орнуудын Засгийн газрын шугамаар зохион байгуулагдаж байгаа сургалтад хамрагдахыг дэмжиж ажилласнаар Монголбанктай сургалтын гэрээ байгуулсан 17 мэргэжилтэн АНУ, Австрали, Япон зэрэг орнуудад суралцаж байна. Тайлант онд гадаад, дотоодын урт богино хугацааны сургалтад төв аппаратаас 69, орон нутгийн салбаруудаас 16 нийт 85 ажилтан оролцуулсан ба 14 ажилтан хамтын ажиллагаатай олон улсын банк санхүүгийн байгууллагуудын хурал зөвлөлгөөнд, 10 ажилтан ОХУ-д зохион байгуулсан танилцах аялалд оролцлоо.

Бүх ажиллагсдын 76 хувь нь банк санхүү, нарийн мэргэжлийн инженер, эдийн засагч мэргэжилтэй мэргэжлийн боловсон хүчин байгаа бол үйлчилгээний албан тушаалтнуудын 38 орчим хувь нь дээд боловсрол эзэмшсэн байна. Монголбанкны ахмад настанд хүндэтгэл үзүүлэх, нэмэгдэл тэтгэвэр тэтгэмж олгох тухай журмыг шинэчлэн мөрдөж байгаа ба журмын дагуу ахмадууддаа 2 удаа хүндэтгэл үзүүлэв.

Дотоод аудит

Монголбанкны Дотоод аудитын газар нь үндсэн чиг үүргийнхээ дагуу дотоод аудитын 2007-2011 онуудад хийх урт хугацааны төлөвлөгөө, болон 2008 оны төлөвлөгөөний дагуу Монголбанкны газар, хэлтэс, алба болон орон нутаг дахь салбар (нэгжүүд)-т шалгалт хийж эдгээр нэгжүүдийн Төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа нь Монгол Улсын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хэрхэн хангаж байгаад хяналт тавьж ажиллав.

Тайлант онд Монголбанкны нэгжүүдэд төлөвлөгөөт аудит 8, төлөвлөгөөт бус 9, бусад Монголбанкны удирдлагуудаас өгсөн үүрэг даалгаврын дагуу бүрэн, хэсэгчилсэн, гэнэтийн нийт 20 удаа шалгалт хийж, үр дүнг нь Монголбанкны Захирлуудын Зөвлөлд танилцуулан илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, үйл ажиллагаа нь Төв банкны үндсэн чиглэлтэй нийцэж байгаа эсэх, Монголбанкны нэгжүүд өөрт өгсөн үүрэг даалгаврыг зөв зохистой биелүүлж, боловсронгуй болгон дотоод хяналтыг сайжруулж, учирч болзошгүй эрсдэлийг илрүүлэх, бууруулах талаар үүрэг даалгавар, санал зөвлөмж өгч, Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаал гаргуулан ажиллалаа. Түүнчлэн Монголбанкны дотоод аудитын дүрэмд зааснаар дотоод аудитын үйл ажиллагааг нэгтгэн дүгнэж, Монголбанкны Ерөнхийлөгч болон Хяналтын зөвлөлд цаг тухайд нь тайлагнасан болно.

Хөндлөнгийн аудитын байгууллага, Монголбанкны Хяналтын зөвлөлөөс Монголбанкинд өгсөн зөвлөмжийн биелэлт, үр дүнд хяналт тавин ажиллахын зэрэгцээ эдгээр байгууллага болон Захирлуудын Зөвлөлийн гишүүдэд танилцуулж, холбогдох шийдвэрийг гаргууллаа.

Дотоод аудитын газар нь тайлант онд “Эрнст энд Янг” хөндлөнгийн аудитын байгууллагаар Монголбанкны 2007 оны санхүүгийн тайланг баталгаажуулахаар аудит хийлгэх ажлыг зохион байгуулж, Монголбанкинд өгсөн зөвлөмжийн биелэлтэд хяналт тавин мөрөөр нь холбогдох арга хэмжээ авч ажиллав.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр 2008 онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Санхүүгийн мэдээллийн алба (СМА) 2008 онд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг банкуудын оролцоотой зохион байгуулах, СМА-ны мэдээлэл хүлээн авах, мэдээллийн сан үүсгэх, түүнд дун шинжилгээ хийх үйл ажиллагааг хөгжүүлэх зорилтыг тавьж ажиллалаа.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2008 онд баримтлах үндсэн чиглэлд тусгагдсаны дагуу СМА-ны үйл ажиллагааг чиглүүлж гадаад, дотоодын холбогдох эрх бүхий байгууллагуудтай Санамж бичиг, хууль эрх зүйн бусад баримт бичигт үндэслэн хамтран ажиллах үндсийг тавилаа. Тухайлбал, ОХУ-ын Санхүүгийн хяналтын холбооны алба болон Бүгд Найрамдах Турк Улсын Санхүүгийн тагнуулын албатай харилцан мэдээлэл солилцох Санамж бичигт гарын үсэг зурав. Мөн БНХАУ-ын Мөнгө угаахын эсрэг мониторингийн төвтэй хамтран ажиллах эрх зүйн үндсийг бүрдүүллээ.

СМА нь 2008 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт 15 банкнаас бэлэн мөнгөний гүйлгээний 92000 тайлан, Сэжигтэй гүйлгээний 13 тайланг хүлээн авч мэдээллийн сандаа бүртгэлээ. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг банкуудад зохион байгуулах, хууль, эрх зүйн шаардлагыг тэдгээрт ойлгуулах зорилгоор СМА-aac 2008 онд нийт 3 удаа банк, санхүүгийн бусад байгууллагын холбогдох ажилтан, албан тушаалтнуудад сургалт, семинар зохион байгуулав. Терроризм, түүнийг санхүүжүүлэхийн эсрэг тэмцэхтэй холбогдуулж НҮБ-aas террорист хэмээн зарлагдсан байгууллага, этгээдийн дансыг илрүүлэх, тэдгээртэй холбоотой гүйлгээг зогсоо тухай журмыг банкуудад зориулж гарган ажиллаж байна.

Түүнчлэн, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үүднээс дотоодын холбогдох хууль хяналтын байгууллагуудын хамтын ажиллагааг дээшлүүлэх зорилгоор эрх зүйн баримт бичигт тулгуурласан байгууллага хоорондын мэдээлэл солилцох үйл ажиллагааг эхлүүлэв. Тухайлбал, Монгол Улсын хилээр их хэмжээний бэлэн мөнгө тээвэрлэх зорчигчоор деклараци бөглүүлэх системийг гаалийн байгууллагад хэрэгжүүлэх, гаалийн байгууллага, Санхүүгийн мэдээллийн албадын хооронд мэдээлэл байнга солилцохоор тохилоо.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Ази номхон далайн Олон улсын байгууллагын үйл ажиллагаанд Монгол Улсыг төлөөлөн тогтмол идэвхтэй оролцож мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх салбарт олон улсын хамтын

нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргээ манай улс хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар болон түүний идэвх чармайлтын талаар дэлгэрэнгүй тайлагнаж, тодорхой дэмжлэгүүдийг хүлээн аваад байна.

Бэлэн мөнгөний хангалт

Гүйлгээний эрэлт хэрэгцээ, шаардлага болон дэвсгэртийн зохистой бүтцийг хангах зорилгоор 1, 5, 50, 100 төгрөгийн цаасан дэвсгэртүүдийг чанар, нууцлалын өндөр түвшинд шинээр хэвлүүлж 2008 онд гүйлгээнд гаргав. Аймаг, орон нутгийн салбар банкуудаар дамжуулан бэлэн мөнгөөр хангах, муудсан мөнгөн тэмдэгтийг татаж устгах, давтан тоолох, хянах үйл ажиллагааг тогтмол явуулж ирлээ.

Тайлант онд 36.7 тэрбум төгрөгийн 27.9 сая ширхэг муу дэвсгэртийг устгав. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө 2008 оны эцсийн байдлаар 407.2 тэрбум төгрөгт хүрсэн байна. Мөнгөн тэмдэгтийг тоолох, ялгах ажлыг орчин үеийн тоолох машинаар гүйцэтгэх чиглэл баримталж 2008 онд ХБНГУ-аас мөнгө тоолох, ялгах “БПС204” маркийн 2 ширхэг машин худалдан авч ашиглаж байна. Үүний үр дүнд мөнгө тоолох гар ажиллагааг халж, хуурч, гэмтэж муудсан мөнгөн тэмдэгтийг бүрэн илрүүлж байна. Тоолж шалгаагүй мөнгөний үлдэгдэл өмнөх онд 53178 боодол буюу 383.7 тэрбум төгрөг байсан бол түр тоологч гэрээгээр авч ажиллуулах, илүү цагаар ажиллах зэрэг арга хэмжээ авсны үр дүнд тайлант оны эцэст 1169 боодол буюу 7.2 тэрбум төгрөг болж буурав.

Төлбөр тооцооны системийн хөгжлийн зорилт, түүний хэрэгжилт

Монголбанк нь төлбөр тооцооны системийг хөгжүүлэх, төлбөр тооцооны эрсдэлийг бууруулах, найдвартай, тасралтгүй байдлыг хангах бодлогыг боловсруулан, түүний хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй Төлбөрийн бодлого, зохицуулалтын албыг Төлбөр тооцоо бүртгэлийн газрын бүтцэд 2008 оны 1 дүгээр сараас байгуулан ажиллуулж байна.

Үндэсний төлбөр тооцооны системд Монголбанкны эзлэх байр суурь, гүйцэтгэх үүрэг, хэрэгжүүлэх бодлогыг системийн нийт оролцогч талууд, олон нийтэд мэдээлж, ил тод байдлыг хангах үүднээс “**Монголбанкнаас баримтлах төлбөр тооцооны системийн бодлого**”-ын баримт бичгийг боловсруулж батлав. Энэхүү баримт нь санхүүгийн эрх бүхий байгууллага, бусад орнуудын Төв банктай хамтарч ажиллахад Монголбанкны байр суурийг нээлттэй болгох ач холбогдолтой юм.

Монголбанкны ерөнхийлөгч, Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2008 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн хамтарсан тушаалаар батлагдсан Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн дэргэдэх Төлбөр тооцооны үндэсний зөвлөл /TTY3/ нь эхний хоёр хуралдаанаа хийж, “**Үндэсний төлбөр тооцооны системийг 2009-2014 онд хөгжүүлэх стратеги**” баримт бичгийг баталсан. Уг баримт бичгийн агуулга нь нийт эдийн засаг болон санхүүгийн секторт хийгдэж буй төлбөр тооцоог тасралтгүй, найдвартай, шуурхай гүйцэтгэж, санхүүгийн тогтвортой байдлыг хангах урьдчилсан нөхцлийг баталгаажуулахад оршиж байна.

Түүнчлэн “Төлбөр тооцооны системийн онцгой байдлын үед ажиллах төлөвлөгөө”-г баталж, төлбөр тооцооны системийн тасралтгүй ажиллагааг хангах, төлбөр тооцооны системийн онцгой байдлын үед мөрдөх төлөвлөгөөг боловсруулж, мөрдлөг болгон ажиллах тухай банкуудад зөвлөмж гаргаж, энэ чиглэлээр хяналт тавин ажиллаж байна.

Монголбанкны зүгээс банк хоорондын их дүнтэй гүйлгээний бодит цагийн систем (“Банксүлжээ”)-ийг 2009 онд багтаан нэвтрүүлэх зорилт тавьж, 2008 онд уг системийг нэвтрүүлэх төсөл боловсруулж, тендерийг зохион байгуулан, системийг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг 2008 оны 4 дүгээр улирлаас эхлүүлсэн болно.

“Банксүлжээ” системийг нэвтрүүлснээр Монгол Улсын төлбөрийн систем олон улсын жишигт хүрэх, банк хоорондын төлбөр тооцоонд оролцогч талуудын зээлийн, төлбөрийн, хөрвөх чадварын эрсдэлүүд буурах, эдийн засаг, санхүүгийн салбарт хийгдэж буй их дүнтэй төлбөр тооцоо тасралтгүй, найдвартай, шуурхай хийгдэх, нууцлал сайжрах зэрэг олон талын ач холбогдолтой юм.

Банк хоорондын төлбөр тооцоо

Хүснэгт 3.1. Банк хоорондын гүйлгээний тоо

	2002	2003	2004	2005	2006	2007	2008
I улирал	222.2	406.4	586.3	620.2	689.7	758.7	999.1
өсөлт %	22.9%	82.9%	44.3%	5.8%	11.2%	10.0%	31.7%
II улирал	287.1	611.7	793.5	797.5	851.5	968.3	1,266.1
өсөлт %	25.6%	113.1%	29.7%	0.5%	6.8%	13.7%	30.8%
III улирал	295.6	561.9	617.3	541.6	762.8	829.1	603.4
өсөлт %	56.9%	90.1%	9.9%	-12.3%	40.8%	8.7%	-27.2%
IV улирал	405.9	636.8	727.1	391.0	910.6	1,098.5	746.2
өсөлт %	68.3%	56.9%	14.2%	-46.2%	132.9%	20.6%	-32.1%
Бүгд	1,210.8	2,216.8	2,724.2	2,350.3	3,214.6	3,654.6	3,614.9
өсөлт %	44.3%	83.1%	22.9%	-13.7%	36.8%	13.7%	-1.1%

Сүүлийн 7 жилийн үзүүлэлтээс авч үзэхэд 2003 онд нийт гүйлгээний тоо хамгийн их өссөн буюу өмнөх оныхоос 83.1 хувиар өссөн бол 2005 онд нийт гүйлгээний тоо хамгийн их буюу 13.7 хувиар буурсан байна. 2008 оныг 2007 онтой харьцуулахад гүйлгээний тоо I улиралд хамгийн их буюу 31.7 хувиар өссөн бол IV улиралд хамгийн бага буюу 32.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 3.2. Банк хоорондын гүйлгээний дүн, улирлаар

	2002	2003	2004	2005	2006	2007	2008
I улирал	471,476.0	850,168.0	1,086,387.0	1,481,785.0	1,787,632.0	2,358,713.0	3,952,503.0
өсөлт %	13.9%	80.3%	27.8%	36.4%	20.6%	31.9%	67.6%
II улирал	581,978.0	1,000,429.0	1,429,326.0	1,809,396.0	2,742,823.0	3,421,237.0	4,663,908.0
өсөлт %	33.2%	71.9%	42.9%	26.6%	51.6%	24.7%	36.3%
III улирал	718,179.0	986,840.0	1,400,152.0	2,057,196.0	2,145,663.0	3,312,149.0	4,435,284.0
өсөлт %	45.1%	37.4%	41.9%	46.9%	4.3%	54.3%	33.9%
IV улирал	972,338.0	1,249,533.0	1,746,268.0	2,222,723.0	2,847,428.0	5,230,050.0	5,300,084.0
өсөлт %	81.6%	28.5%	39.8%	27.3%	28.1%	83.7%	1.3%
Бүгд	2,743,973.0	4,086,971.0	5,662,133.0	7,571,101.0	9,523,548.0	14,322,150.0	18,473,032.0
өсөлт %	45.9%	48.9%	38.5%	33.7%	25.8%	50.4%	28.9%

Хамгийн их гүйлгээ IV улиралд хийгддэг бөгөөд энэ үед тухайн оны эцсийн гүйлгээнүүд хийгддэгтэй холбоотой. Харин хамгийн бага гүйлгээний дүн I улиралд гарч байгаа нь оны эхэнд төсвийн санхүүжилт дөнгөж хийгдэж эхэлдэгтэй холбоотой юм. Сүүлийн 5 жилд нийт гүйлгээний дүнгээр хамгийн их өсөлт ажиглагдсан жил нь 2007 он (50.4 %) байна.

Төлбөрийн картын хэрэглээ

Сүүлийн жилүүдэд манай улсад өргөн хэрэглэгдэж байгаа төлбөрийн картын хэрэглээний тоон үзүүлэлтүүдийг нэгтгэж, түүний өөрчлөлт ба өсөлтийг хэмжих зорилгоор төлбөрийн картын үйлчилгээ үзүүлдэг 10 банкны төлбөрийн картын судалгаа хийлээ. Судалгаанд 2005-2008 оны эхний хагас жилийн үзүүлэлтүүдийг хамруулав. Карт эзэмшигчдийн тоо (давхардсан тоогоор) 2005 онд 333 мянга байсан бол 2008 онд 1182 мянгад хүрч, жилийн дундаж өсөлт нь 54 хувьтай байна.

Хүснэгт 3.3. Карт эзэмшигчид, карт ашиглагчдын тоо

Он	Карт эзэмшигчдийн тоо	Өөрчлөлт	Карт ашиглагчдын тоо	Өөрчлөлт
2005 он	333,005		236,839	
2006 он	417,697	25.4%	310,238	31.0%
2007 он	691,903	65.6%	227,810	-26.6%
2008 он	1,182,526	70.9%	470,773	106.7%
Нийт өөрчлөлт:		54.0%		37.0%

Өдөрний таасуулалт

Банкууд картын төлбөр тооцоонд ПОС (POS-point of sale буюу үйлчилгээний байгууллагуудад байршуулсан карт уншиж, гүйлгээ хийх хэрэгсэл), ПОБ (POB-point of banking буюу банк, түүний салбар нэгжид байршуулсан карт уншиж, гүйлгээ хийдэг хэрэгсэл), ATM (автомат теллерийн машин) гэсэн ангиллын төхөөрөмжийг ашиглаж байна.

Хүснэгт 3.4. Төхөөрөмжийн тоо

Төхөөрөмжүүд	2005 он	2006 он	2007 он	2008 он	Өсөлт (2007-2008)	Жилийн дундаж өсөлт
ПОС терминал	1,154	2,191	2,852	6,358	122.9%	81.0%
ПОБ терминал	38	156	848	2,176	156.6%	303.6%
АТМ төхөөрөмж	35	85	125	346	176.8%	122.2%
Нийт:	1,227	2,432	3,825	8,880		168.9%

ПОС терминалын тоог ПОБ, ATM төхөөрөмжийн тоо, ширхэгтэй харьцуулахад харьцангуй олон бөгөөд жигд өсөлттэй байгаа бол ПОБ терминал, ATM төхөөрөмжийн хувьд 2006- 2007 онд хурдацтай өсөлт ажиглагдаж байна. Харин 2008 оныг 2007 онтой харьцуулбал ПОС төхөөрөмжийн тоо 122.9 хувиар, ПОБ – 156.6 хувиар, ATM – 176.8 хувиар тус тус өсчээ. ПОС терминалаар 2008 онд 298.2 тэрбум төгрөгийн 1.8 сая гүйлгээ хийгдсэн нь өмнөх оныхоос гүйлгээний дүн 44.4 хувиар, гүйлгээний тоо 51.4 хувиар буурчээ.

Хүснэгт 3.5. ПОС, ПОБ, ATM төхөөрөмжөөр хийгдсэн гүйлгээний тоо, дүн

	ПОС -ын гүйлгээ		ПОБ -ын гүйлгээ		АТМ -ын гүйлгээ		Нийт	
	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо
	/тэрбум төгрөг/	/сая ширхэг/						
2005 он	157.3	2.1	12.6	0.1	35.6	0.6	205.5	2.9
2006 он	623.3	4.8	32.4	0.3	82.9	1.4	738.6	6.5
2007 он	671.1	3.5	210	1.5	172.7	3.4	1053.7	8.5
2008 он	298.2	1.8	462.7	4.1	492.3	9.1	1253.3	15
Нийт	1749.9	12.2	717.7	6	783.5	14.7	3251.1	32.9
Жилийн дундаж өсөлт (%)	83%	16%	275%	237%	142%	144%	107%	77%

Нийт төхөөрөмжүүдээр хийгдсэн гүйлгээний тоо, дүнг авч үзэхэд жилээс жилд нэмэгдсэн боловч ПОС терминалаар хийгдсэн гүйлгээний тоо ширхэг болон дүн 2006 оноос буурсан бол ПОБ, ATM төхөөрөмжүүдээр хийгдсэн гүйлгээ 2007 оноос хойш огцом өссөн байна. Энэ нь сүүлийн жилүүдэд карт эзэмшигчид картаар төлбөр тооцоо хийхээс илүү картаас бэлэн мөнгө гарган, бараа үйлчилгээний төлбөрт хэрэглэх болсонтой холбоотой.

Мэдээллийн технологийн талаар

Монголбанкны Мэдээллийн технологийн газар нь мэдээллийн технологийн бодлого чиглэлийг тодорхойлж, дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх, мэдээллийн системийн найдвартай ажиллагааг хангахын төлөө ажиллаж байна. Банк хоорондын төлбөр тооцоог үнэн зөв, түргэн шуурхай гүйцэтгэх боломжийг бүрдүүлэх зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Бодит цагийн төлбөрийн систем /RTGS/-ийг нэвтрүүлэх бэлтгэл ажил хийгдлээ.

Монголбанкны нягтлан бодох бүртгэлийн системийг олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэх, нягтлан болох бүртгэлийг сайжруулах зорилгоор одоогийн ашиглагдаж буй системд шаардлагатай нэмэлт өөрчлөлтүүдийг хийж гүйцэтгэлээ.

Монголбанк дахь олон улсын төлбөр тооцооны СВИФТ системийн техник технологийн шинэчлэлтийн хоёрдугаар үе шатыг амжилттай хийж дуусгалаа.

Монголбанкны дотоод үйл ажиллагааг шуурхай, боловсронгуй болгох ажлын хүрээнд Монголбанкны дотоод цахим хуудас, цалингийн, архивын, гэрээний нэгдсэн бүртгэлийн сан зэрэг програм хангамжуудыг боловсруулан ашиглалтад оруулав.

2009 онд Банк хоорондын төлбөрийн системийг бодит цагийн горимд бүрэн шилжүүлэх, Банкны салбарын мэдээллийн нэгдсэн санг байгуулах, Зээлийн мэдээллийн сангийн шинэ системийг ашиглалтад оруулах, Монголбанкны мэдээллийн системүүдийг улам боловсронгуй болгох ажлуудыг хийхээр төлөвлөн ажиллаж байна.

Банкны тухай хууль тогтоомж

Тайлант онд санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах үүднээс УИХ-аас “Банкин дахь мөнгөн хадгаламжинд баталгаа гаргах тухай хууль” /2008 оны 11 дүгээр сарын 25-нд/-ийг баталснаар мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий, Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкин дахь мөнгөн хадгаламжид төрөөс баталгаа гаргаж, хууль үйлчилж эхэлснээс хойш 4 жилийн хугацаанд учирсан хохирлыг төр бүрэн хариуцахаар зохицуулав.

Гадаад хамтын ажиллагаа

Тайлант хугацаанд Монголбанк олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай тогтоосон хамтын ажиллагаагаа үргэлжлүүлж, үйл ажиллагааны хүрээг өргөжүүлэх чиглэлийг барьж ажиллалаа.

“Монголбанк, Оросын Холбооны Улсын Төв банк хоорондын хяналт шалгалтын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр” болон “Гэмт хэрэг үйлдэж олсон орлого, эд хөрөнгийг хууль ёсны болгох (мөнгө угаах) үйл ажиллагаатай тэмцэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд Монголбанк, Оросын Холбоот Улсын Санхүүгийн Хяналтын албаны хоорондын хамтын ажиллагааны гэрээ”-г байгууллаа.

Монгол Улс болон БНХАУ-ын хооронд худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх үүднээс хоёр улсын банкуудын найдвартай, шуурхай төлбөр тооцооны системийг бий болгох зорилгоор банкуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх тухай Монголбанк, БНХАУ-ын Ардын банк /Төв банк/ хоорондын төлбөр тооцооны гэрээг 2004 онд байгуулсан ба энэхүү гэрээний хэрэгжилтийн үр дүнг хэлэлцэн, цаашдын шийдвэрлэх асуудлыг тодорхойлох зорилгоор “Монгол, Хятадын хил худалдааны төлбөр тооцооны банк хоорондын дугуй ширээний уулзалт”-ыг жил бүр хоёр улсад эзлжлэн зохион байгуулдаг билээ. Ийнхүү Монгол, Хятадын банк хоорондын V дугаар зөвлөлдөх уулзалтыг Улаанбаатар хотноо зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах, хэлэлцэх асуудлаар Хятадын талтай тохиролцоод байна.

УИХ-ын 87 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2008 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын зээлжих зэрэглэлийг 2008 онд тогтоолгоо Монголбанк зэрэглэл тогтоогч “Фич” компанийн хамtran ажиллав.

Индонез Улсын Жакарта хотноо болсон Зүүн өмнөд Азийн Төв банкуудын холбооны Ерөнхийлөгчдийн “Мөнгөний тогтвортой байдал, эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжсэн санхүүгийн гүнзгийрэлт” сэдэвт 47 дугаар Бага хуралд Монголбанкны төлөөлөгчид оролцсон ба Бага хурлын талаарх мэдээллийг Монголбанкны Вэб хуудсанд англи, монгол хэл дээр тавьж, өдөр тутмын хэвлэлд нийтлүүллээ.

Зүүн өмнөд Азийн Төв банкуудын холбоотой хамtran “Орон сууцны ипотекийн зах зээлийн тогтвортой байдал, хоёрдогч ипотекийн зах зээлийг хөгжүүлэх” сэдэвт семинарыг, Эдийн засгийн хамтын ажиллагааны олон улсын банкны Зөвлөлийн ээлжит 110 дугаар хуралдаан, Олон улсын хөрөнгө оруулалтын банкны Зөвлөлийн ээлжит 85-р хуралдааныг Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулав. Монголбанкны төлөөлөгчид Олон улсын хөрөнгө оруулалтын банкны болон Эдийн засгийн хамтын ажиллагааны олон улсын банкны Зөвлөлийн ээлжит хуралдаанд оролцож ажиллалаа.

Монгол Улсын шинэ мөнгөн тэмдэгтийг хэвлүүлэх талаар Их Британийн Делару, Германы Гизеке Девриент, алт цэвэршүүлэх ажлыг Германы Коммерц банктай хамtran гүйцэтгэлээ. Мөн дурсгалын алт, мөнгөн зоос үйлдвэрлэх ажлыг Лихтенштейны Коин Инвест компанийн хамтарч зохион байгуулав.

Улсынхаа эдийн засгийн төлөв байдал, банк, санхүүгийн зах зээлийг гадаадын бизнесийн орчинд таниулж сурталчлах, хөрөнгө оруулалтыг татах зорилгоор АНУ-ын “Универсал ньюс” сэтгүүлд Монголбанкны үйл ажиллагааны талаарх мэдээллийг нийтлүүллээ. Банкерс Алманах, Централ банкинг директорийн олон улсын банк санхүүгийн байгууллагуудын талаарх цахим мэдээллийн санд Монголбанкны талаарх мэдээллийг тухай бүр шинэчилж байна. Зүүн өмнөд Азийн Төв банкуудын холбооны дэргэдэх Сургалт, судалгааны төвөөс эрхлэн гаргадаг сэтгүүлд Монголбанкны үйл ажиллагааны талаар мэдээлэл улирал бүр нийтлэгдэж байна.

Банкны сургалтын төвийн үйл ажиллагаа

Банкны сургалтын төв нь 2008 онд өөрийн гол үүрэг болох сургалт семинарыг төлөвлөгөөний дагуу тогтмол явуулж ирсэн ба сургалт семинарыг чанартай, үр өгөөжтэй зохион байгуулахад гол анхаарлаа хандуулан ажиллалаа. Энэ онд төлөвлөгдсөн дотоод, гадаад сургалт семинарт давхардсан тоогоор нийт 969 хүн хамрагдсан нь өнгөрсөн оныхоос 57 хүнээр илүү байна.

Банкны сургалтын төв тайлант онд 34 сэдвээр 61 удаагийн дотоод, гадаад сургалт семинарыг зохион байгууллаа.

Тайлангийн хугацаанд сургалтын семинарын чанар, үр өгөөжийг нэмэгдүүлэхийн тулд сургалтыг ваакум орчинд явуулах, сургалт семинарын үргэлжлэх хугацааг сунгаж, аль болох урт хугацаагаар зохион байгуулахыг хичээн ажилласны дунд нийт 3419 хүн/өдөр сургалт семинарыг зохион байгуулсан нь өмнөх оныхоос (2007 онд 3368 хүн/өдөр) 1.5 хувь буюу 51 хүн/өдрөөр нэмэгдсэн байна.

Банкны сургалтын товоос дотооддо зохион байгуулсан сургалт

Банкны сургалтын төв нь арилжааны банкуудын ажилтнуудын эрэлт, хэрэгцээ шаардлагыг хангахуйц сургалт семинарыг зохион байгуулж явуулахын тулд сүүлийн жилүүдэд тогтоод байгаа уламжлалын дагуу оны эхэнд арилжааны банкуудаас санал авч 2008 оны сургалтын төлөвлөгөөг хамтран боловсруулсан ба уг төлөвлөгөөг зөвлөлдөх зөвлөлөөр хэлэлцүүлж, Хяналтын зөвлөл батласны дагуу сургалт семинарыг зохион байгуулав.

Банкны сургалтын төв тайлант онд 31 сэдэв бүхий 58 удаагийн /2524 хүн/өдөр/ сургалт семинарыг дотооддо зохион байгуулж, нийт 916 хүнийг оролцуулсан бол ГТХАН-ийн төслийн багтай хамтран Баян-Өлгий, Ховд, Өвөрхангай, Өмнөговь, Хөвсгөл (эдгээр алслагдсан аймгуудад анх удаагаа),Хэнтий, Дархан-Уул, Орхон, Дорнод, Сайншанд зэрэг аймгуудад давхардсан тоогоор 17 удаагийн сургалт семинарыг зохион байгуулж, 192 банкны ажилтныг хамруулав.

Тайлант онд 16 хүнийг 3 модуль бүхий 21 хоногийн сургалтанд хамруулан сургагч багшаар бэлтгэсэн ба ирээдүйн хэрэгцээ шаардлага, банкуудын хүсэлтийг харгалзан 2009 онд хөдөө орон нутагт сургагч багш нарыг бэлдэхээр төлөвлөөд байна. Мөн банкны залуу удирдах ажилтны 2 модуль бүхий 14 хоногийн сургалтыг анх удаагаа зохион байгуулав.

Мөн сургалтыг системтэй шаталсан байдлаар явуулах зорилгоор төслийн багтай хамтран банкны теллерүүдэд зориулсан 2 долоо хоногийн сургалтын концепц, моргайжийн хууль гарах болсонтой холбогдуулан орон сууцны санхүүжилт, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ зэрэг сургалтуудын концепцийг шинээр боловсрууллаа.

Тайлант хугацаанд шинээр болон давтан Хөрөнгийн талаарх цогц үйлчилгээ, Моргейж, Зах зээлийн судалгаа, шинээр бизнес эрхлэгчдийн санхүүжилт, Хүний нөөц ба сэтгэл зүйн тест, Дилерүүдэд зориулсан сургалт, Төслийн менежмент сэдэвт сургалтуудыг зохион байгуулав.

Гадаад түнш байгууллагуудын туслалцаа дэмжлэгээр Ирланд, Герман, Люксембург, Бельги, Франц зэрэг орнуудаас банкны мэргэжилтнүүдийг урьж ирүүлэн 34 удаагийн сургалт семинарыг зохион байгуулсан нь арилжааны банкуудын хувьд ажилтнуудаа гадаадад сургах ихээхэн хэмжээний зардал мөнгө хэмнэсэн арга хэмжээ юм.

Банкны сургалтын төв нь 2007 оны 1 дүгээр сараас эхлэн ГТХАН /GTZ/-тэй хамтран “Банкны сургалтын төвийн үйл ажиллагааг дэмжих” нэг сая европийн өртөг бүхий 2 жил хагасын хугацаатай төслийн 2 дугаар үеийг амжилттай хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд Монголбанк дээр уулзалт, сургалт семинарын зориулалтай 40 хүний суудал, орчин үеийн техник тоног төхөөрөмж бүхий танхимыг шинээр тохижуулав.

Банкны сургалтын төв нь 2008 оны 9 дүгээр сарын 14-16-ны өдрүүдэд Ази, Номхон далайн орнуудын банкны институтуудын холбооны 12 дахь удаагийн олон улсын чуулга уулзалтыг Улаанбаатар хотноо “Дэлхийн санхүүгийн хямралыг зогсооход банкны боловсролын байгууллагуудын үүрэг роль” гэсэн уриан дор амжилттай зохион байгууллаа.

Энэхүү олон улсын чуулга уулзалтанд 17 орны Банкны институт болон академуудын 26 ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгчид, ажилтнуудын хамт ирж оролцсон ба Монголын арилжааны зарим банкуудын удирдлага ажиглагчаар оролцжээ.

Гадаад орнуудад зохион байгуулсан сургалт

Банкны сургалтын төв 2008 онд арилжааны банкуудын үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, хүний нөөцийн менежментийг хөгжүүлж олон улсын стандарт түвшинд хүргэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Европын орнуудын банкны салбарын хөгжилтэй танилцуулах, арга туршлагаас нь судлуулж суралцуулах зэргээр банкны салбарын 53 ажилтнуудыг хамруулсан 3 удаагийн сургалтыг Люксембург, ХБНГУ-д зохион байгуулав.

4.1 Монгол Улсын эдийн засгийн тойм

Манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий өсөлт 2008 онд урьдчилсан байдлаар жилийн 8.9 хувьд хүрэв. Үндэсний статистикийн хорооны мэдээгээр нэг хүнд ногдох ДНБ оны үнээр 2305.2 мянган төгрөг болжээ. Эдийн засгийн өсөлт 2007 онд 10.2 хувь байсан бол тайлант онд 1.3 нэгжээр буурч 8.9 хувь болсон байна. Үүнд хөдөө аж ахуйн салбарын өсөлт 10.8 нэгж, уул уурхай, олборлох салбарын өсөлт 2.8 нэгжээр саарсан нь нөлөөлжээ. ДНБ-ий жилийн өсөлтийг улирлаар авч үзвэл тайлант оны 2 дугаар улирлаас эхлэн өсөлт нь буурсан байна.

Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбар (ДНБ-ий 18.8%) өмнөх оныхтой харьцуулснаар 5 хувь, тээвэр, агуулахын аж ахуй, холбоо (ДНБ-ий 9.8%) 19.5 хувь, бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засвар үйлчилгээ (ДНБ-ий 7.8%) 19.5 хувиар тус тус нэмэгдсэн нь эдийн засгийн өсөлтөд голлох нөлөө үзүүлжээ. Харин уул уурхай, олборлох үйлдвэр (ДНБ-ий 27.8%) 0.1 хувиар өссөн тул түүний нөлөө нь багассан байна.

Тайлант онд тээвэр, агуулахын аж ахуй, холбоо, бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засвар үйлчилгээний салбар хамгийн өндөр буюу 19.5 хувиар нэмэгдсэн боловч өмнөх оныхтой харьцуулснаар тээвэр, агуулахын аж ахуй, холбооны салбарын өсөлтийн хурд 7.1 нэгжээр буурчээ. Дэлхийн эдийн засаг, санхүүгийн хямралын нөлөө нь манай эдийн засгийн үйл ажиллагааны ихэнх салбарын өсөлт багассанаар илэрч байна. Тухайлбал боловсруулах үйлдвэрийн салбарын өсөлт 24.2 нэгж, барилгынх 17.2 нэгж, тээвэр, агуулахын аж ахуй, холбооных 7.1 нэгж, санхүүгийн зуучлалын салбарын өсөлт 15.2 нэгж, уул уурхай, олборлох үйлдвэрийнх 2.8 нэгжээр тус тус саарчээ.

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл (2005 оны үнээр) 2.8 хувиар өсч, өмнөх онтой харьцуулснаар өсөлт нь 7.6 нэгжээр буурсан байна. Үүнд металлын хүдэр олборлолт, төмрийн үйлдвэрлэл багассан явдал нөлөөлжээ.

Хөдөө аж ахуйн салбарын өсөлт 5 хувьд хүрсэн нь өмнөх оныхоос 10.8 нэгжээр багассан байна. Энэ нь малын тоо толгой 2007 онд 5.5 сая толгой буюу 15.7 хувиар нэмэгдэж байсан бол 2008 онд 3.0 сая толгой буюу 7.5 хувиар өсч, өсөлт нь саарсантай холбоотой. Харин тайлант онд нэг га талбайгаас 13.8 центнер үр тариа, 109.6 центнер төмс хураасан нь 2007 оныхоос үр тарианых 4.7 центнер, темснийх 9.7 центнэрээр тус тус өссөн байна. Хураасан үр тариа 98.1 мянган тонн буюу 85.5 хувь, төмс 20.3 мянган тонн буюу 17.7 хувь, хүнсний ногоо 2.5 мянган тонн буюу 3.2 хувиар нэмэгдсэн байна. 2008 оны зуншлага сайн, хур бороотой байсан, газар тариаланг хөгжүүлэх талаар Атрын гуравдахь аяныг хэрэгжүүлсэн тул энэ амжилтад хүрчээ.

Хүснэгт 4.1. Дотоодын нийт бүтээгдхүүн (2005 оны зэрэгцүүлэх үнээр, сая төгрөг)

	2005	2006	2007	2008*
ДНБ	2779578.2	3017425.8	3325892.6	3620532.5
өсөлт (%)	7.3%	8.6%	10.2%	8.9%
Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй, загасны аж ахуй	608335.1	654148.2	757493.6	795527.2
өсөлт (%)	11.1%	7.5%	15.8%	5.0%
Үүл уурхай, олборлох үйлдвэр	608208.9	646310.2	665021.2	665848.8
өсөлт (%)	10.9%	6.3%	2.9%	0.1%
Боловсруулах үйлдвэр	101962.9	115585.3	149055.5	156093.4
өсөлт (%)	-19.2%	13.4%	29.0%	4.7%
Цахилгаан, дулааны үйлдвэрлэл, усан хангамж	80021.1	83634.8	89875.6	95839.8
өсөлт (%)	0.9%	4.5%	7.5%	6.6%
Барилга	58835.2	61827.5	67065.5	61216.7
өсөлт (%)	15.9%	5.1%	8.5%	-8.7%
Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ	226961.1	261759.7	279352.9	333865.2
өсөлт (%)	2.9%	15.3%	6.7%	19.5%
Зочид буудал, зоогийн газар	19135	21022.1	24391.9	28062.5
өсөлт (%)	17.1%	9.9%	16.0%	15.0%
Тээвэр, агуулажын аж ахуй, холбоо	309100	346429.2	438597.9	524293.8
өсөлт (%)	22.9%	12.1%	26.6%	19.5%
Санхүүгийн зуучлал	99966.8	96776.1	125955.9	144773.8
өсөлт (%)	14.7%	-3.2%	30.2%	14.9%
Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн бусад үйл ажиллагаа	217120.3	228863.4	224947.9	237064.8
өсөлт (%)	8.8%	5.4%	-1.7%	5.4%
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагаа	66847.2	67154.5	70205.1	74136.6
өсөлт (%)	3.4%	0.5%	4.5%	5.6%
Боловсролын салбарын үйл ажиллагаа	84915.7	88685.5	90527.9	96472.8
өсөлт (%)	-5.0%	4.4%	2.1%	6.6%
Эрүүл мэнд, нийгмийн хalamжийн үйл ажиллагаа	37966.5	41515.4	45953	49780.1
өсөлт (%)	3.0%	9.3%	10.7%	8.3%
Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	28323	30027.1	32336.3	37810.9
өсөлт (%)	4.0%	6.0%	7.7%	16.9%
Санхүүгийн байгууллагын шууд бус үйлчилгээ	-79858.5	-109673.2	-144416.9	-149396.7
өсөлт (%)	15.0%	37.3%	31.7%	3.4%
Бараа, үйлчилгээний цэвэр татвар	311737.9	383359.9	409529.3	469142.8
өсөлт (%)	1.5%	23.0%	6.8%	14.6%

Тухайлбал импортоор оруулсан хөдөө аж ахуйн зориулалттай шинэ трактор, комбайн, машин механизм, гурилын үйлдвэрийн болон усалгааны тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгааллын бодисыг 2011 оны 12 дугаар сарын 31-ийг хүртэл гааль болон нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ)-аас чөлөөлсөн байна. Мөн “Атрын III дахь аян” тариалангийн хөгжлийн Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хэд хэдэн аймгуудад төсвийн зээл хэлбэрээр санхүүжилт олгожээ.

Үндэсний статистикийн хорооны мэдээгээр тайлант онд жилийн инфляци улсын хэмжээнд 22.1 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 23.2 хувьд хүрлээ. Бараа бүтээгдэхүүний ангилал буюу бүлгээр авч үзвэл, 23.2 хувийн өсөлтийн 10.7 нэгж буюу 46.1 хувь нь зөвхөн хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт байсан бөгөөд үүн дотроо талх, гурил, будаа (4.1 нэгж), мах, махан бүтээгдэхүүн (1.7 нэгж) хамгийн их үнийн өсөлттэй байв. Хувцас бөс бараа, гутал (3.0 нэгж), тээвэр (3.0 нэгж), орон сууц, ус, цахилгаан түлш (2.3 нэгж), боловсролын үйлчилгээ (1.7 нэгж)-ний салбарт үнийн өсөлт өндөр гарсан байна. Хүнсний бүтээгдэхүүнийн үнийн өсөлт 2007 онд нийт үнийн өсөлтийн 67.5 хувийг бурдүүлж байсан бол тайлант онд 46.1 хувь, орон сууц, ус, цахилгаан түлш 11.7 хувь байснаа 9.8 хувь болон буурч, харин хувцас бөс бараа, гутал 2.0 хувиас 12.7 хувь, тээвэр 7.3 хувиас 12.9 хувь, боловсрол 7.3 хувиас 7.5 хувь болон өсчээ. Хэрэглээний үнийн ерөнхий индекс өсөхөд нийлүүлэлт болон эрэлтийн төрөл бүрийн хүчин зүйлс нөлөөлсөн байна.

Газрын тосны дэлхийн зах зээлийн үнэ өссөн, ОХУ нефть бүтээгдэхүүнийхээ экспортын татварын хэмжээг нэмсэн (ОХУ 2007 оны эцэст тонн тутмаас 197.8 мянган ам.долларын экспортын татвар авдаг байсан бол 2008 оны 2 дугаар сард 237.2 мянга, 4 дүгээр сард 241.4 мянга, 6 дугаар сард 280.5 мянга, 8 дугаар сард 346.4 мянган ам.доллар болгон өсгөсөн) нь нефть бүтээгдэхүүний дотоодын үнэ өсөхөд хүргэв. Нефть бүтээгдэхүүний үнийн өсөлт нь шууд болон бусад бараа, үйлчилгээний үнээр дамжин хэрэглээний нийт бараа бүтээгдэхүүний үнэ өсөхөд хүргэсэн. Эдийн засгийн, ялангуяа сангийн бодлогын сүүлийн жилүүдийн огцом тэлэлт нь инфляцид нөлөөлсөн эрэлтийн өсөлтийг бий болгов. Харин 2008 оны 8 дугаар сард дээд түвшиндээ буюу жилийн 34 хувьд хүрсэн инфляци оны сүүлийн хэдэн сард буурлаа. Дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал гүнзгийрч, газрын тосны эрэлт багассанаар тус барааны дэлхийн зах зээлийн үнэ нь буурсан, импортын нефть бүтээгдэхүүний үнэ буурсан, мөн дотоодын зах зээлд махны нийлүүлэлт нэмэгдэж, үнэ нь буурсан, ургац хураалт сайжирч, гурил, гурилан бүтээгдэхүүн, хүнсний ногооны үнэ буурсан зэрэг хүчин зүйлс инфляцийн бууралтад нөлөөлсөн.

Хүнсний бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах, үнийг нь тогтвортжуулах зорилгоор Засгийн газраас газар тариаланг хөгжүүлэх шууд арга хэмжээ авахаас гадна татварын бодлогоор дэмжлэг үзүүлсэн байна. 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүртэл импортолсон хүнсний буудайг НӨАТ-аас, 40 мянган тонн буудайн гурилыг гаалийн албан татвараас чөлөөлөв. Мөн импортын улаан буудайн гурил, цагаан будаа, ургамлын тосны гаалийн татварыг 2008 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр хүртэл “0” хувь болгожээ.

Тайлант онд улсын нэгдсэн төсөв урьдчилсан гүйцэтгэлээр 305.7 тэрбум төгрөгийн алдагдалтай, харин урсгал тэнцэл 386.6 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа. Нэгдсэн төсвийн алдагдал ДНБ-ий 5 хувьд хүрэв. Улсын нэгдсэн төсвийн орлого, тусламжийн дун 14.7 хувиар нэмэгдсэн байхад нийт зарлага, эргэж төлөгдөх зээлийн хэмжээний дун 40.9 хувиар өссөн нь төсөв алдагдалтай гарахад хүргэжээ. Татварын орлого, тухайлбал орлогын албан татвар, дотоодын бараа, үйлчилгээний татварын орлого төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй бөгөөд өмнөх оныхоос харьцангуй бага хэмжээгээр өссөн байна. Нөгөө талаас цалин хөлсний зардал 83.3 хувь, халамжийн зардал 90.0 хувь, хөрөнгө оруулалтын зардал 96.9 хувиар тус тус нэмэгджээ.

Үндэсний статистикийн хорооны мэдээгээр манай орны нийт экспорт тайлант онд 2534.5 сая ам.доллар, нийт импорт 3244.5 сая ам.доллар болж, гадаад худалдааны тэнцэл 710.1 сая ам.долларын алдагдалтай гарсан нь 2007 онтой харьцуулахад 595.7 сая ам.доллараар нэмэгджээ. Эрдэс бүтээгдэхүүний экспорт (нийт экспортын 60.3%) 17.5 хувиар нэмэгдсэн нь нийт экспортын өсөлтийг тодорхойлжээ. Түүнчлэн сувд, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоосны экспорт (нийт экспортын 23.7%) 2.6 дахин өсөв. Эрдэс бүтээгдэхүүний импорт (нийт импортын 29.7%) 59.9 хувь, машин, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн импорт (нийт импортын 18.7%) 42.9 хувиар тус тус өсчээ.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2008 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 108000 төгрөг болгон шинэчлэн тогтоожээ. Мөн нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн доод хэмжээг 81000 төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 54000 төгрөгт хүргэж, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийг 20 хувиар нэмэгдүүлсэн байна. Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн хувь хэмжээг 19 хувиас 10 хувь болгож бууруулсан нь аж ахуйн нэгж байгууллагыг дэмжих, ажиллагдын цалин хөлс, шинээр ажлын байрыг нэмэгдүүлэхд тус дөхөм болов.

Аж үйлдвэр

Үндэсний статистикийн хорооны мэдээгээр 2008 онд аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 64.6 хувийг уул уурхай, олборлох аж үйлдвэр, 26.5 хувийг боловсруулах аж үйлдвэр, 8.9 хувийг цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж тус бүр бүрдүүлжээ. Уул уурхай, олборлох аж үйлдвэрт хамгийн өндөр хувь буюу 84.1 хувийг металлын хүдэр олборлолт, боловсруулах аж үйлдвэрт 21.8 хувийг төмрийн үйлдвэрлэл, 37.5 хувийг хүнсний бүтээгдэхүүн, ундааны үйлдвэрлэл, 19.7 хувийг нэхмэлийн үйлдвэрлэл, харин цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжид 89.0 хувийг цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл тус тус эзэлж байв.

2008 онд аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл өмнөх оныхоос 2005 оны зэрэгцүүлэх үнээр 2.8 хувиар өссөнөөс уул уурхай, олборлох аж үйлдвэрийн үйлдвэрлэл 0.2 хувь, боловсруулах аж үйлдвэрийн үйлдвэрлэл 5.9 хувь, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж 6.9 хувиар тус бүр нэмэгджээ. Дэд салбаруудыг авч үзвэл, хүнсний бүтээгдэхүүн, ундааны үйлдвэрлэл 30.0 тэрбум төгрөг буюу 19.2 хувь, нэхмэлийн үйлдвэрлэл 8.5 тэрбум төгрөг буюу 6.7 хувь, цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл 12.6 тэрбум төгрөг буюу 7.3 хувиар тус тус өсчээ.

Харин төмрийн үйлдвэрлэл 23.5 тэрбум төгрөг буюу 13.6 хувь, металлын хүдэр олборлолт 26.1 тэрбум төгрөг буюу 3.2 хувиар буурсан байна.

Тайлант онд 2.9 их наяд төгрөгийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулсан нь өмнөх оныхоос 11.3 хувиар илүү байна. Үүнээс 1.8 их наяд төгрөгийн бүтээгдэхүүнийг гадаадын зах зээлд нийлүүлжээ. Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн борлуулалт нийт борлуулалтын дунд 64.3 хувь, боловсруулах аж үйлдвэрийнх 26.9 хувь, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн борлуулалт 8.8 хувийг тус тус эзэлж байна. Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн борлуулалтын 82.6 хувь, боловсруулах аж үйлдвэрийн 34.2 хувь нь гадаадын зах зээлд ногдож байна. Үүнд металлын хүдэр олборлолтын бүтээгдэхүүний 84.4 хувь, нэхмэлийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний 77.2 хувь, төмрийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний 74.4 хувийг тус бүр гадаадын зах зээлд борлуулжээ.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 48.4 хувийг Улаанбаатар хотод, 38.5 хувийг Орхон аймагт борлуулсан байна.

Хөдөө аж ахуй

2008 онд 43.3 сая мал, үүнд 20.0 сая ямаа, 18.4 сая хонь, 2.5 сая үхэр, 2.2 сая адuu, 266.4 мянган тэмээ тоологдов. Малын тоо 2007 оныхоос 3.0 сая буюу 7.5 хувиар өсөв. Тус өсөлтийг малын төрлөөр нь авч үзвэл ямаа 1.6 сая, хонь 1.4 сая, үхэр 77.6 мянга, тэмээ 5.8 мянган толгойгоор тус тус өсч, харин адuu 52.6 мянган толгойгоор багасчээ. Нийт мал сүрэгт хонь 42.4 хувь, ямаа 46.1 хувийг тус тус эзэлж байна.

Мал тооллогын дунгээр 14 аймаг болон Улаанбаатар хот малаа 2007 оныхоос 19.3-466.7 мянган толгой буюу 0.8-49.9 хувиар өсгөсөн байна. Хөвсгөл (3815.7 мянга), Өвөрхангай (3449.7 мянга), Архангай (3379.2 мянга), Завхан (3136.0 мянга), Төв (3003.0 мянга) зэрэг аймгууд малын тоогоороо тэргүүлж байна.

Малтай нэг өрхөд дунджаар 188 толгой мал, үүнд 1 тэмээ, 10 адuu, 11 үхэр, 79 хонь, 80 ямаа ногдож байна.

2008 онд 14.0 сая эх мал буюу эх малын 83.1 хувь төллөжээ. Төллөлтийн хувь өмнөх оныхоос 5.7 нэгжээр багасчээ. Нийт 12.8 сая төл бойжсон бөгөөд бойжилтын хувь 6.1 нэгжээр буурч, 91.0 хувь болжээ.

Тариалсан нийт талбай 192.5 мянган га болж, өмнөх оноос 10.2 мянган га буюу 5.0 хувиар багассан боловч үр тариа тариалсан талбайн хэмжээ 32.2 мянган га буюу 26.4 хувь, буудайны талбай 33.4 мянган га буюу 28.6 хувь, төмс тариалсан талбай 0.8 мянган га буюу 7.2 хувь, хүнсний ногооны талбайн хэмжээ 0.3 мянган га буюу 4.5 хувь, тэжээлийн ургамлын талбай 0.6 мянган га буюу 12.4 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Тайлант онд 212.9 мянган тонн үр тариа, 209.8 мянган тонн буудай, 78.9 мянган тонн хүнсний ногоо, 134.8 мянган тонн төмс хурааж, 1.0 сая тонн өвс хадлан болон 27.6 мянган тонн гар тэжээл бэлтгэсэн нь 2007 оныхоос үр тариа 98.1 мянган тонн буюу

86.5 хувь, буудай 100.3 мянган тонн буюу 91.5 хувь, өвс хадлан 76.7 мянган тонн буюу 8.2 хувь, хүнсний ногоо 2.5 мянган тонн буюу 3.2 хувь, төмс 20.3 мянган тонн буюу 17.7 хувиар өсч, гар тэжээл 7.8 мянган тонн буюу 21.9 хувиар буурчээ.

Нэг га талбайгаас хураасан үр тариа дунджаар 13.8 центнер болсон нь өмнөх оныхос 4.6 центнер буюу 50.0 хувиар их байна. Нэг га талбайгаас авсан төмс 9.7 центнер буюу 9.7 хувиар өсч, 109.6 центнер болжээ.

Барилга

Урьдчилсан гүйцэтгэлээр барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 2008 онд 440.3 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оныхос 50.9 тэрбум төгрөг буюу 13.1 хувиар их байна. Нийт барилга угсралт, их засварын ажлын 94.5 хувийг дотоодын барилгын байгууллага хийж гүйцэтгэв. Үүнд хувийн байгууллагын хийж гүйцэтгэсэн ажил 68.1 тэрбум төгрөг буюу 23.7 хувиар өсчээ.

Нийт барилга угсралт, их засварын ажлын 29.9 хувийг орон сууцны барилга, 17.4 хувийг орон сууцны бус барилга (үйлдвэрийн, худалдаа үйлчилгээний, эмнэлэг, сургууль, соёлын г.м.), 38.8 хувийг инженерийн барилга байгууламж, 13.9 хувийг их засварын ажил тус бүр эзэлж байна. Мөн дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн нийт барилга угсралт, их засварын ажлын 54.4 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна.

Тээвэр, холбоо

Тайлант онд тээврийн бүх төрлийн хэрэгслээр 23.9 сая тонн ачаа, давхардсан тоогоор 231.6 сая зорчигч тээвэрлэсэн бөгөөд 2007 оныхос ачаа тээвэрлэлт 574.1 мянган тонн буюу 2.5 хувь, зорчигч тээвэрлэлт 21.7 сая хүн буюу 10.3 хувиар тус тус өссөн байна. Тээврийн салбарын нийт орлого 412.1 тэрбум төгрөгт хүрч өмнөх оныхос 69.8 тэрбум төгрөг буюу 20.4 хувиар нэмэгджээ. Тус хугацаанд авто тээврийн орлого 24.0 тэрбум төгрөг буюу 31.5 хувь, агаарын тээврийных 10.5 тэрбум төгрөг буюу 11.3 хувь, төмөр замын тээврийн орлого 35.3 тэрбум төгрөг буюу 20.3 хувь, усан замын тээврийн орлого 47.6 сая төгрөг буюу бараг 3 дахин өссөн байна.

Авто тээврээр тээсэн ачаа өмнөх оныхтой харьцуулснаар 0.5 хувиар өсч 9.3 сая тонн, зорчигч тээвэрлэлт 10.7 хувиар өсч 226.9 сая зорчигч болов.

Төмөр замын тээврээр тээсэн ачаа 14.6 сая тонн болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 3.7 хувиар нэмэгдсэн боловч дамжин өнгөрөх ачаа тээвэрлэлт 32.7 хувиар буурсан байна. Мөн зорчигч тээвэрлэлт 0.1 сая хүн буюу 2.8 хувиар багасчээ.

Агаарын тээврийн ачаа тээвэрлэлт 2.4 хувь, зорчигч тээвэрлэлт 5.9 хувиар тус тус буурчээ.

Авто техникийн улсын үзлэг, тооллогын дүнгээр 2008 онд 190.5 мянган тээврийн хэрэгсэл байгаагаас 127.5 мянган ширхэг буюу 67.0 хувь нь суудлын машин байна. Суудлын машины 61.9 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна.

Шуудан холбооны нийт орлого 343.4 тэрбум төгрөгт хүрч жилийн хугацаанд 96.6 тэрбум төгрөг буюу 39.1 хувиар өсөв. Хүн амаас орсон орлого 46.2 хувиар өсч, нийт орлогын 86.6 хувийг бүрдүүлжээ. Үүрэн телефон холбооны орлого 93.8 тэрбум төгрөг буюу 50.1 хувиар өссөн байхад телефон утас, телеграф, телекоммуникацийн холбооны орлого 6.0 тэрбум төгрөг буюу 13.7 хувиар буурсан байна.


Тайлант онд үүрэн телефон эзэмшигчдийн тоо 570.8 мянган хүн буюу 48.6 хувиар өсч 1.7 саяд хүрсэн байна. Утасгүй телефоны тоо 10.3 мянга буюу 40.9 хувиар өсч 35.4 мянган ширхэг, суурин телефоны цэг 1.4 мянган цэг буюу 1.0 хувиар өсч 151.4 мянга болжээ. 2008 оны эцсийн байдлаар бүх сум үүрэн телефоны сүлжээнд холбогдсон байна.

ШИГТГЭЭ 1. Дэлхийн бараа бүтээгдэхүүн, зах зээлийн тойм

Газрын тос

Тайлант оны эхний хагаст хөгжиж буй орнуудын газрын тосны эрэлт өндөр байсны улмаас тухайн бүтээгдэхүүний үнэ тогтвортой өсч 2008 оны 7 дугаар сард баррель нь түүхэнд хамгийн өндөр түвшин буюу 147 ам.долларт хүрэв. Газрын тосны үнэ ийнхүү өндөр түвшинд хүрсэн нь нефть экспортлогч гол орнуудын нийлүүлэлтийн талаарх мэдээллүүд нөлөөлжээ. Харин 2008 оны хоёрдугаар хагасаас эхлэн үнэ нь буурсаар 12 дугаар сарын байдлаар баррель нь 40 орчим ам.доллар болов. Үүнд, дэлхийн санхүүгийн хямралаас шалтгаалан газрын тосны эрэлт мэдэгдэхүйц буурч байгаа нь нөлөөлжээ. Хэдийгээр тайлант оны эцсээр Газрын тос экспортлогч орнуудын байгууллага (ОPEC)-ын шийдвэрээр газрын тосны олборлолтыг бууруулах арга хэмжээ авч байсан боловч энэ нь түүний үнийг төдийлөн тогтвожуулж чадсангүй.

Зураг 1. Дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ



Дэлхийн хэмжээнд газрын тосны хэрэглээ 1983 оноос хойш тогтвортой байсан бол тайлант онд өдрийн хэрэглээ нь өмнөх онтой харьцуулахад 0.05 сая баррелиар буурсан байна. Үүнд Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын гишүүн (OECD) орнуудын хэрэглээ буурсан нь голлон нөлөөлсөн


бөгөөд зөвхөн АНУ-ын хэрэглээ нь өмнөх онтой харьцуулахад 1.17 сая баррель буюу 4.6 хувиар буурсан байна. Хэрэглээ буурч байгаа гол шалтгаан нь тээвэр, онгоцны шатахууны үнэ тайлант оны эхний хагаст харьцангуй өндөр байсантай холбоотой. Харин OECD-ын бус орнуудын хэрэглээ нь 1.41 сая баррель болон өсчээ.

ОPEC-ын гишүүн бус орнуудын газрын тосны нийлүүлэлт тайлант онд 50.57 сая баррель байсан бөгөөд энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 80 мянган баррелиар нэмэгдсэн байна. Харин ОPEC-ын гишүүн орнуудын үйлдвэрлэлт 2008 онд 31.9 сая баррель байсан нь өмнөх оноос 0.9 сая баррелиар өссөн боловч газрын тосны үнийг тогтвортжуулах зорилгоор тухайн оны сүүлийн гурван сард өдрийн нийлүүлэлтээ 1.6 сая баррелиар бууруулжээ.

Зэс

Дэлхийн зах зээл дээрх зэсийн үнэ 2008 онд өмнөх онуудтай адил их хэлбэлзэлтэй байв. Зэсийн үйлдвэрлэл 2008 оны эхний хагас жилд төдийлөн нэмэгдэж чадаагүй байсны улмаас тухайн түүхийн эдийн үнэ түүхэн дэх хамгийн өндөр түвшинд хүрсэн бол тус оны хоёрдугаар хагас жилд түүний эрэлт буурснаас үнэ нь огцом унасан. Тайлант жилийн 12 дугаар сарын байдлаар зэсийн дундаж үнэ 3136 ам.доллар болсон бөгөөд энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 3420 ам доллар буюу 52 хувиар буурсан байна. Дэлхийн зэсийн нөөц 2008 оны 12 дугаар сарын байдлаар 389.7 мянган тонн болж өмнөх оны мөн үеэс 152 мянган тонн буюу 64.2 хувиар өсч дэлхийн хэмжээнд хэрэглээ нь 7.9 хоногийн нөөцтэй байв.

Зураг 2. Дэлхийн зах зээл дээрх зэсийн үнэ



Зэсийн үнэ тайлант оны эхний хагас жилд тогтвортой өсч 2008 оны 7 дугаар сард түүхэн дэх хамгийн өндөр түвшин буюу тонн нь 8720 ам долларт хүрсэн байна. Үүнд, зэсийн нийлүүлэлт хангалттай бус байгаа тухай мэдээллүүд голлон нөлөөлжээ. Тухайлбал, зэсийн томоохон нийлүүлэгч орон болох Перу, Чили улсын уул уурхайн салбарын ажиллагсдын ажил хаялт, Замби улсын эрчим хүчний асуудал нь зэсийн эрэлт өндөртэй үед зэс олборолт, үйлдвэрлэлтийн хэмжээг бууруулан тухайн түүхий эдийн үнийг өсгөж байв.

Харин 2008 оны гуравдугаар улирлаас эхлэн түүхийн эдийн зах зээл дээрх байдал үүний дотор зэсийн зах зээлийн байдал ч мөн адил эрс өөрчлөгджэх эхлэв. Санхүүгийн зах зээлийн хямрал, дэлхийн эдийн засгийн өсөлтийн цаашдын хандлага нь зэсийн эрэлтийг бууруулж түүний нөөцийг мэдэгдэхүйц өсгөсон байна. Тухайлбал, Лондонгийн барааны бирж (LME) дээрх зэсийн нөөц 72 хувиар өсч 339.7 мянган тонн, Нью-Йоркийн барааны бирж (COMEX) дээрх нөөц 2.3 дахин өсч 31.3 мянган тоннд хүрсэн байна. Иймд зэсийн үнэ тайлант оны хоёрдугаар хагаст унасаар тухайн оны эцсийн байдлаар 3100 ам.долларт хүрэв.

Дэлхийн цэвэршүүлсэн зэсийн үйлдвэрлэл Олон улсын зэсийн судалгааны байгууллага (ICSG) мэдээллийн дагуу 2008 оны эцсийн байдлаар 18.4 сая тоннд хүрэхээр тооцоологджээ. Энэ нь өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад 343 мянган тонн буюу 1.9 хувиар өсөхөөр байна. Харин цэвэршүүлсэн зэсийн хэрэглээ тайлант онд 18.3 сая тоннд хүрч 2007 онтой харьцуулахад 528 мянган тонн буюу 3 хувиар нэмэгдэхээр байна.

Алт

Тайлант онд хамгийн ашигтай хөрөнгө оруулалт нь алт худалдан авах байв. Алтны үнэ сүүлийн 7 жилийн турш нэмэгдэж байгаа бөгөөд 2008 онд ч энэ хандлага үргэлжилсээр байна. АНУ-ын санхүү эдийн засгийн нөхцөл байдал хямралд орж ам.доллар дэлхийн гол валютын эсрэг супарч байсан нь алтны үнийг түүхэндээ хамгийн өндөр түвшин буюу үнци нь 1033 ам.долларт хүргэхэд нөлөөлсөн. Хэдийгээр алтны үнэ 2008 оны 2 дугаар улирлаас бага зэрэг буурсан боловч түүний үнэ өмнөх онуудтай харьцуулахад харьцангуй өндөр хэвээр байв. Тухайн үед түүний үнэ дэлхийн алтны хамгийн том хэрэглэгч болох Энэтхэг улсын үнэт эдлэлд ашиглагдаж буй хэрэглээ буурсантай тодорхой хэмжээгээр холбоотой байв. Тайлант оны 7 дугаар сард дэлхийн зах зээл дээрх бусад түүхий бараа бүтээгдэхүүний үнэтэй адил алтны үнэ өссөн боловч ам.долларын ханш 2008 оны 2 дугаар хагасаас 20 орчим хувиар чангач алтны үнийг мэдэгдэхүйц бууруулсан. Харин тайлант оны 12 дугаар сараас эхлэн дэлхийн санхүүгийн хямрал, эдийн засгийн цаашдын хандлагын талаарх хүлээлт найдвартай хөрөнгө оруулалт хэмээгддэг алтны үнийг өсгөхөд нөлөөлж байна.


Зураг 4. Дэлхийн зах зээл дээрх алтны үнэ



Улаан буудай

Тайлант онд улаан буудайн үйлдвэрлэл өмнөх оноос 12 хувиар өсч 682.1 сая тоннд хүрсэн байна. Цаг агаарын таатай байдал голлон нөлөөлсөн бөгөөд түүхэндээ хамгийн өндөр ургацтай жил болов. Мөн дэлхийн зах зээл дээр улаан буудайн үнэ өссөн нь тариалалтын талбайн хэмжээг нэмэгдүүлэхэд хүргэж үйлдвэрлэлийн өсөлтөд нөлөөлжээ. Улаан буудайн үнэ буурч, тайлант оны 12 дугаар сарын байдлаар тонн нь 235.3 ам.доллар байв.

Зураг 5. Дэлхийн зах зээл дээрх улаан буудайн үнэ




Улаан буудайн гол экспортлогч орнуудад ургацын хэмжээ тайлант онд мэдэгдхүйц нэмэгджээ. Тухайлбал, АНУ-ын улаан буудайн ургацын хэмжээ 12.2 сая тонн буюу 21.9 хувь, ОХУ-ынх 13.6 сая тонн буюу 27.5 хувь, Украинах 11.6 сая тонн буюу 83.5 хувь, Канадынх 8.6 сая тонн буюу 42.7 хувиар тус тус өссөн байна. Хэдийгээр улаан буудайн нийт нийлүүлэлт нэмэгдсэн боловч хүнсний хэрэглээний шаардлага хангасан буудайн хувь буурчээ. ОХУ болон Украинан улсын хүнсний зориулалттай улаан буудайн хэмжээ нийт үйлдвэрлэлийнх нь 70-75 болон 60 хувьтай тус тус тэнцэж байсан бол тайлант онд уг харьцаа нь 62 болон 30 хувь хүртлээ буурсан байна. Иймд үр тарианы зах зээл дээр чанар муутай буудайн нийлүүлэлт өсч түүний үнийг бууруулахад хүргэв.

Хүснэгт 1. Дэлхийн улаан буудайн үйлдвэрлэл (сая тонн)

	2007 он	2008 он	Жилийн өсөлт	Жилийн өсөлт, %
АНУ	55.8	68	12.2	21.9%
БНХАУ	109.3	113	3.7	3.4%
Зүүн ази	102.5	101.4	-1.1	-1.0%
ОХУ	49.4	63	13.6	27.5%
Украин	13.9	25.5	11.6	83.5%
Европын Холбооны 27	102.5	130.2	27.7	27.0%
Канада	20.1	28.6	8.6	42.7%
Австрали	13	20	7	53.4%
Орхи дорнод	34.5	28.8	-5.7	-16.5%
Бусад	109.2	104.4	-4.9	-4.5%
Бүгд	610.2	682.9	72.7	11.9%

Тайлант онд харьцангуй өндөр ургац хурааж авсан боловч дэлхийн хэмжээнд улаан буудайн нөөц сүүлийн 5 жил буурсан байна. Улаан буудайн хэрэглээ нь 2000 оноос хойш ихэвчлэн үйлдвэрлэсэн хэмжээнээсээ давж байсан тул түүний нөөц жил бүр хорогдож байв. Харин 2008 онд улаан буудайн нөөц 35.7 сая тонн буюу 29.2 хувиар өссөн боловч түүний нөөц өмнөх онуудтай харьцуулахад харьцангуй бага хэмжээтэй үлдэж байна.


Зураг 6. Дэлхийн улаан буудайн үйлдвэрлэл, хэрэглээ болон нөөц



4.2. Үнэ

ХҮИ-ээр тооцсон үнийн түвшин тайлант онд 22.1 хувиар өссөн байна. Тайлант оны 8 дугаар сард хамгийн дээд түвшин 34.2 хувьд хүрч байсан жилийн инфляци оны эцсээр буурч 22.1 хувь болсон байна. Инфляцийг бууруулах зорилгоор Монголбанк оны эхнээс мөнгөний бодлогын арга хэмжээ шат дараатай авсны үр дүнд бараа, үйлчилгээний үнэ 2008 оны сүүлийн саруудад буурч өсөлтийн хурд саарсан. Хүнсний гол нэрийн бараа болох мах, гурилын үнэ болон бензиний үнэ тодорхой хувиар буурсан нь үүнд тодорхой нөлөө үзүүллээ. Шатахаан импортлогч компаниуд 2008 онд бензин, дизель түлшний үнийг 3 удаа нэмж, 4 удаа бууруулснаар 2008 оны сүүлийн саруудад түлшний үнэ буурсан үзүүллэлтэй гарсан ч 2008 оны жилийн дундаж үнийг 2007 оны жилийн дундажтай харьцуулахад 45.1 хувиар өссөн байна. 2008 оны 2-7 дугаар сар хүргэл махны үнэ байнга өссөн байна. Махны нийлүүлэлт нэмэгдсэнтэй холбоотойгоор 2008 оны 8 дугаар сараас аажмаар махны үнэ буурав. Дэлхийн зах зээл дээрх улаан буудайн үнэ буурсан болон дотооддоо улаанбуудайн ургац ахиу хурааж авсантай холбогдуулан 2008 оны 10 дугаар сараас эхлэн гурилын үнэ хямдарсан байна.

Зураг 4.1. Инфляци (сарын өөрчлөлт)



Хэрэглээний үнийн улсын индексийн жилийн дундаж түвшин 2008 онд 28.0 хувь байгаа нь сүүлийн 10 жилд гараагүй өндөр үзүүлэлт юм. Хэрэглээний үнийн индекс 9 сар хүртэл байнга өсч байснаа 10 дугаар сараас оны эцэс хүргэл буурлаа. Инфляцийн түвшинд нөлөөлсөн бас нэг хүчин зүйл нь 2008 оны эхнээс төсөвт байгууллагад ажиллагсдын цалинг нэмсэн явдал байв. Ажиллагчдын сарын дундаж цалин 2007 оны жилийн эцсийнхээс 32.9 хувь, төсөвт байгууллагынх 32.7 хувь өссөн байна. Түүнчлэн хэрэглээний сагсан дахь нийт 287 бараа, үйлчилгээний 54.4 хувь, түүний дотор хүнсний барааны 48 хувийг импортын бараа, бүтээгдхүүн эзэлж байгаа учир 2008 оны 4 дүгээр улирлын валютын ханшийн өсөлт инфляцийн түвшинд тодорхой хэмжээгээр нөлөөлжээ.

Хүснэгт 4.2. Хэрэглээний үнийн улсын индекс (бүлгээр, хувиар)

	Хувийн жин	2008-12 2007-12	Өсөлтөд эзлэх хувь
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	39.7	24	43.1
Согтууруулах ундаа, тамхи	2.8	12.4	1.6
Хувцас, бөс бараа, гутал	15.3	16.5	11.4
Орон сууц, ус, цахилгаан, түлш	10.8	22.6	11
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	5.6	15.4	3.9
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	1.8	27	2.2
Тээвэр	9	25.8	10.5
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	2.9	-3	-0.4
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	3.1	9.7	1.4
Боловсролын үйлчилгээ	5.4	39.9	9.7
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	1	31.4	1.4
Бусад бараа үйлчилгээ	2.7	14.6	1.8
Ерөнхий индекс	100	22.1	100

Хэрэглээний үнийн индексийг бараа бүтээгдхүүний ангилал буюу бүлгээр нь авч үзвэл, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлгээс бусад бүх бүлгүүдийн үнэ өссөн

байна. Тайлант онд хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн дүн 24.0 хувь (нийт өсөлтийн 43.1 хувь), хувцас, бөс бараа, гутал 16.5 хувь (нийт өсөлтийн 11.4 хувь), орон сууц, ус, цахилгаан, түлш 22.6 хувь (нийт өсөлтийн 11 хувь), тээвэр 25.8 хувь (нийт өсөлтийн 10.5 хувь), боловсрол 39.9 хувиар (нийт өсөлтийн 9.7 хувь) тус тус өссөн нь хэрэглээний үнийн улсын индекс 22.1 хувиар өсөхөд голлон нөлөөлсөн байна. Түүнчлэн, худалдааны түнш орнуудын инфляци өссөн, импортын гурил, гурилан бүтээгдэхүүн, элсэн чихэр, цагаан будаа, ургамлын тос зэрэг хүнсний бараануудын үнэ өссөн, хөрш орнуудын валютын ханш чангартсан, шатахуун, түлшний дэлхийн зах зээлийн үнэ өссөн зэрэг нь 2008 оны инфляци өндөр гарахад гол нөлөө үзүүлсэн байна.

ШИГТГЭЭ 2. Дэлхийн инфляцийн тойм

Дэлхийн инфляцийн хандлага

Евро бүсийн инфляци 2008 оны сүүлийн саруудад огцом буурч инфляцийн дарамт суларсан байна. Евро бүсийн инфляци 2008 оны 1 дүгээр сард 3.2 хувьтай байсан бол 6, 7 дугаар сард 4.0 хувь хүртэл өсч харин 2008 оны эцэст бараа бүтээгдэхүүний үнэ буурснаар жилийн 1.6 хувьтай гарсан байна. Инфляци огцом буурсан нь нефть болон хүнсний бүтээгдэхүүний үнэ буурснаас шалтгаалжээ. Нэг баррель нефть 2008 оны 6 дугаар сард 150 ам.доллар байсан бол 2008 оны 12 дугаар сард огцом буурч 40 ам.доллар болсон байна.

АНУ-ын Холбооны нөөцийн банкны мэдээлснээр тус улсын хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдсэн инфляци 2008 онд жилийн 0.1 хувьтай гарсан байна. Энэ нь шатахууны үнийн индекс 17.2 хувиар буурсан нь нийт үнийн индексийн бууралтын 90 хувийг эзэлж байна. Хүнсний бараа, бүтээгдэхүүний үнийн индекс (голлон мах, сүү, жимс, ногооны үнийн индекс) 2006 оны 4 дүгээр сараас хойш анх удаа 2008 оны 12 дугаар сард буурчээ.

Манай улсын гадаад худалдааны түнш орнуудын инфляци


Худалдааны түнш орнуудын инфляци манай эдийн засгийн өрсөлдөх чадварыг өөрчилдөг. Гол худалдааны түнш орнуудын валюттай харьцах төгрөгийн ханш суларсан, 2008 онд манайд импортоор бараа нийлүүлдэг орны хэрэглээний бараа үйлчилгээний үнэ өссөн зэрэг нь манай улсын инфляцийг өсгөх дарамт бий болголоо. Харин манай экспортлогч орны инфляци экспортын орлого нэмэгдэх боломж бий болгодог. Гэхдээ манай гол экспортлогч БНХАУ-ын эдийн засгийн өсөлт өөрөө саарч байсан тул манай экспортын эрэлт буурч экспортын орлогыг бууруулж байлаа. 2008 онд манай экспортын бараа бүтээгдэхүүний эрэлт БНХАУ-д илүү хүчтэй буурсан учраас манай зарим экспортын үнэ буурсан юм. Манай хэрэглээний үнийн барааны сагс дахь импортын барааны эзлэх хувийн жин харьцангуй өндөр буюу 34 орчим хувь байдаг учраас импортын үнэ өсөх нь илүү анхаарал татсан хүндрэл байсан болно.

Экспортын 70 орчим хувь нь ноогдог БНХАУ-ын Засгийн газар үнийн өсөлтийг зогсоохын тулд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, тариаланчдад хөнгөлөлттэй үнээр бордоо, үр олгох арга хэмжээ авсны үр дунд хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт буурснаар 2008 оны эцэст тус орны инфляци жилийн

1.2 хувь гарсан нь сүүлийн 14 сард гарсан хамгийн бага үзүүлэлт юм. Тайлант оны эхээр инфляци нэмэгдэх хүчтэй дарамт ийнхүү оны сүүл рүү зөвлөрсөн билээ.

БНХАУ-ын удирдлага дан ганц инфляцийг бууруулах бодлого хэрэгжүүлснээр эдийн засгийн өсөлт саарах, экспортын хэмжээ буурах аюултай гэж үзэж байгаа тул тус улсын бодлого боловсруулагчид үнийн өсөлтийг бууруулахын хамт тогтвортой бөгөөд хурдацтай эдийн засгийн өсөлтийг дэмжих бодлого явуулах болсноо 2008 оны сүүлээр зарлав.


Зураг 1. БНХАУ-ын инфляци, жилийн өөрчлөлт (2008)



Монгол Улсын импортын хэрэгцээний 37 хувийг нийлүүлдэг ОХУ-ын инфляци 12 дугаар сарын байдлаар жилийн 13.3 хувьтай гарсан байна. Намрын ургац хураалтаар инфляцийг бууруулах боломжтой гэж үзэж байгаа бол хүнсний бус бараа, бүтээгдэхүүн болон үйлчилгээний үнийн өсөлтөөс шалтгаалж инфляцийн өсөлт саарсангүй. Мөн 2008 онд рублейн ханш суларсан нь инфляцийн өсөлтөд нөлөөлсөн байна.

Энэ оны 7 дугаар сарын 28-ны өдөр Оросын Эдийн засаг хөгжлийн яамнаас оны инфляцийн зорилтот түвшинг 10.5 хувь байсныг 11.8 хувь болгон нэмэгдүүлж өөрчилсөн. Гэсэн хэдий ч 12 дугаар сарын инфляцийн дүн өндөр гарснаар энэхүү шинэчилсэн зорилтот түвшин ч биелэгдэх боломжгүй болсон байна.

Зураг 2. ОХУ-ын инфляци, жилийн өсөлтөөр (2008)



4.3. Хөдөлмөрийн бүтээмж, ажил эрхлэлт, цалин

Хөдөлмөрийн бүтээмж

Тайлант оны эцэст аж үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн бүтээмж өмнөх оныхоос 1.7 сая төгрөгөөр нэмэгдэж 34.7 сая төгрөгт хүрсэн байна. Хөдөлмөрийн бүтээмжийг тооцоходоо нэмэгдсэн өргтийн хэмжээг жилийн ажиллагчдын дундаж тоонд хувааж тодорхойлдог. Аж үйлдвэрийн салбаруудаас хамгийн өндөр хөдөлмөрийн бүтээмжтэй уул уурхайн салбарын хөдөлмөрийн бүтээмж 65.6 сая төгрөгт бөгөөд энэ дотроо газрын тос, хий олборлох үйлдвэрийн хөдөлмөрийн бүтээмж өмнөх оныхоос 252.1 сая төгрөгт буюу 40.9 хувиар нэмэгдэж, 868.2 сая төгрөг болсон байна. Боловсруулах аж үйлдвэрийн хөдөлмөрийн бүтээмж өмнөх оныхоос 13.8 хувиар нэмэгдэж, 26.4 сая төгрөгт хүрчээ. Мөн, цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамжийн хөдөлмөрийн бүтээмж 2007 оны жилийн эцсийнхээс 5.5 хувиар нэмэгдэж 14.7 сая төгрөг болсон байна.

Хүснэгт 4.3. Аж үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн бүтээмж (мянган төгрөгөөр)

Аж үйлдвэрийн салбар	2007	2008	2008/2007
Аж үйлдвэрийн салбар	33,009	34,765	105.3
Үүл уурхай, олборлох аж үйлдвэр	66,532	65,661	98.7
Нүүрс олборлолт	34,859	37,242	106.8
Газрын тос, шатдаг хий олборлолт	616,083	868,176	140.9
Металлын хүдэр олборлолт	82,813	79,645	96.2
Бусад ашигт малтмал олборлолт	11,646	11,277	96.8
Боловсруулах аж үйлдвэр	23,201	26,402	113.8
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэлт	21,901	25,204	115.1
Мах, загас, жимс, ноггоо, өөх, тос, боловсруулалт	14,635	21,731	148.5
Сүү, сүүн бүтээгдэхүүн	15,197	23,372	153.8
Үр тарианы гурил, цардуул, малын тэжээл үйлдвэрлэл	59,534	61,386	103.1
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	8,914	10,842	121.6
Ундаа үйлдвэрлэл /согтууруулах ундаа ороод/	32,605	35,175	107.9
Тамхи үйлдвэрлэл	462,676	712,249	153.9
Нэхмэлийн үйлдвэрлэл	26,131	28,921	110.7
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	4,470	6,152	137.6
Арьс, шир боловсруулах, шилэн эдлэл, гутал үйлдвэрлэл	20,715	12,630	61
Мод, модон эдлэл үйлдвэрлэл	2,939	3,820	133.4
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	5,928	4,808	81.1
Нийтлэх, хэвлэх, дуу бичлэг хийх ажиллагаа	10,737	14,324	133.4
Кокс, шингэн болон цацраг идэвхит түлш	7,387	3,468	47
Химиийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	6,268	13,400	213.8
Резин болон хуванцар бүтээгдэхүүн	4,723	2,714	57.5
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл	12,903	18,214	141.2
Төмрийн үйлдвэрлэл	138,123	106,010	76.8
Машин, тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл	272	210	77.2
Машин, тоног төхөөрөмж	215	43	20
Бичиг хэргийн болон тооцоолох техник үйлдвэрлэл	62,111	200,409	322.7
Цахилгаан машин, хэрэгсэл үйлдвэрлэл	33,645	58,544	174
Эмнэлгийн багаж хэрэгсэл, нарийн хэмжүүр хараа зүйн хэрэгсэл, цаг үйлдвэрлэл	6,476	6,878	106.2
Тээврийн бусад хэрэгсэл үйлдвэрлэл	439	3,838	873.5
Мебель тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад	7,390	8,931	120.8
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж	13,932	14,692	105.5
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл	16,906	18,093	107
Үс ариутгал, усан хангамж	4,457	4,302	96.5

Ажил эрхлэлт

Монгол Улсын хүн амын тоо 2008 онд урьдчилсан гүйцэтгэлээр 2683.4 мянга болж 2007 оныхоос 48.2 мянган хүн буюу 1.8 хувиар өсчээ. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 2008 оны эцэст 29.8 мянга болж, 2007 оны жилийн эцсийнхээс 0.4 хувиар буюу 0.1 мянган хүнээр буурсан байна. Улсын хэмжээгээр 17.6 мянган эмэгтэй ажилгүй гэж бүртгүүлсэн нь нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 59.1 хувийг эзэлж байна.

Хүснэгт 4.4. Бүртгүүлсэн ажилгүйчүүдийн тоо

Боловсролын түвшин	2006	2007	2008	2008/2007
Бүгд	32,928	29,945	29,813	99.6%
Үүнээс: Эмэгтэй	18,756	16,981	17,611	103.7%
Дээд боловсролтой	4,198	4,047	4,734	117.0%
Тусгай дунд боловсролтой	2,419	1,979	1,917	96.9%
Мэргэжлийн анхан шатны	2,776	2,174	2,043	94.0%
Бүрэн дунд	12,413	12,262	12,553	102.4%
Бүрэн бус дунд	9,431	8,140	7,352	90.3%
Бага	1,459	1,136	1,043	91.8%
Боловсролгүй	232	207	171	82.6%


Тайлант онд 52.7 мянган хүн ажилд зуучлуулж орсон нь 2007 онтой харьцуулахад 4.9 хувь буюу 2.7 мянган хүнээр бага байна. Ажилд орсон хүмүүсийн 13.3 хувь буюу 7.0 мянган хүн төрийн өмчит үйлдвэрийн газар, төсөвт байгууллагад, 86.7 хувь буюу 45.7 мянган хүн компани, хоршоо, бусад байгууллагад оржээ.

Манай улсын хэмжээнд хөдөлмөрийн насны хүн амын тоо 2004 онд 1.5 сая хүн байснаа өсч 2008 онд 1.6 сая хүн болсон байна. Ажиллах хүчиний оролцооны түвшин 2007 онд 64.2 хувьтай байсан бол 2008 оны эцэст 63.4 хувь болж буурчээ. Сүүлийн нэг жилийн дотор ажил эрхлэлтийн түвшин 62.4 хувиас 61.8 хувь хүртэл буурсан хэдий ч ажилгүйдлийн түвшин 2.8 хувьтай хэвээр байна.

Хүснэгт 4.5. Хүн амын ажил эрхлэлт (мянга)


	2004	2005	2006	2007	2008
Хөдөлмөрийн насны хүн амын тоо	1,531.1	1,577.0	1,619.6	1,642.2	1,682.5
Эдийн засгийн идэвхитэй хүн ам	986.1	1,001.2	1,042.8	1,054.0	1,067.5
Үүнээс:					
Ажиллагчид	950.5	968.3	1,009.9	1,024.1	1,040.4
Ажиллах хүчиний оролцооны түвшин (%)	64.4	63.5	64.4	64.2	63.4
Ажил эрхлэлтийн түвшин (%)	62.1	61.4	62.4	62.4	61.8
Ажилгүйдлийн түвшин (%)	3.6	3.3	3.2	2.8	2.8

ҮСХ-ны мэдээнээс үзэхэд 2008 оны жилийн эцсийн байдлаар нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн дунд 25-34 насны хүмүүс хамгийн их жинг буюу 33.7 хувийг эзэлж байна.



Зураг 4.2.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо /насны бүлэг, хүйсээр, 2008 оны эцэст/



Зураг 4.3.

Сарын дундаж цалин, жил бүрийн 4-р улирлын байдлаар

Цалин


ҮСХ-ны мэдээлж байгаагаар аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын 2008 оны 4-р улирлын сарын дундаж цалин 291.1 мянган төгрөгт хүрч, 2007 оныхоос 85.2 мянган төгрөг буюу 41.4 хувиар, төсөвт байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин 84.1 мянган төгрөг буюу 37.2 хувиар нэмэгдсэн байна.

Эрэгтэйчүүдийн сарын дундаж цалин 2008 оны эцсийн байдлаар 310.5 мянган төгрөг байгаа нь эмэгтэйчүүдийнхээс 37.4 мянган төгрөг буюу 13.7 хувиар илүү байна. Харин дундаж цалинг ажил мэргэжлийн ангиллаар авч үзэхэд хууль тогтоогч, төрийн ба төрийн бус байгууллагын удирдах ажилтан, менежер, машин тоног төхөөрөмжийн операторч, угсралч болон мэргэжилтний цалин улсын дунджаас 6.4-168.0 мянган төгрөгөөр илүү, харин бусад ажил мэргэжлийн ажиллагчдын сарын дундаж цалин улсын дунджаас 29.2-71.4 мянган төгрөгөөр бага байна. Ажил мэргэжлийн хувьд эрэгтэй ажиллагчдын цалин эмэгтэйчүүдийнхээс өндөр байна.

Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалинг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд ажиллагчдын дундаж цалин санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагааны салбарт 579.8 мянган төгрөг, уул уурхайн олборлох аж үйлдвэрт 351.8 мянган төгрөг, төрийн удирдлага, батлан хамгаалах, нийгмийн даатгалын салбарт 346.5 мянган төгрөг, эрүүл мэнд, нийгмийн хalamжийн салбарт 303.4 мянган төгрөг, боловсруулах аж үйлдвэрийн салбарт 294.4 мянган төгрөг байгаа нь улсын дунджаас дээгүүр, харин бусад салбарт ажиллагчдын дундаж цалин улсын дунджаас доогуур байна.

Ажиллагчдын сарын дундаж цалинг аж ахуйн нэгж, байгууллагын хариуцлагын хэлбэрээр авч үзэхэд улсын дунджаас төсөвт байгууллагын ажиллагчдын цалин 18.8 мянган төгрөг буюу 6.5 хувиар, хязгаарлагдмал хариуцлагатай компанийд ажиллагчдын цалин 4.5 мянган төгрөг буюу 1.5 хувиар илүү байна.


Зураг 4.4.



Зураг 4.5.

Сарын дундаж цалин /хүйсээр, ажил мэргэжлийн ангиллаар, 2008 оны эцэст/

Зураг 4.5.



Зураг 4.5.


Сарын дундаж цалин /байгууллагын хариуцлагын хэлбэрээр, 2008 оны эцэст/

4.4. Засгийн газрын санхүү

Монгол улсын нэгдсэн төсвийн орлого 2156.4 тэрбум төгрөг (ДНБ-ий 35.2 хувь), зарлага 2462.1 тэрбум төгрөг (ДНБ-ий 40.2 хувь) болж, нийт тэнцэл 305.7 тэрбум төгрөгийн (ДНБ-ий 5.0 хувь) алдагдалтай гарчээ. Ургал тэнцэл 0.4 тэрбум төгрөгийн (ДНБ-ий 6.3 хувь) ашигтай гарсан байна.


Хүснэгт 4.6. 2008 оны улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл (тэрбум төгрөгөөр)

	2007 он	2008			Хувь		
		Гүйцэтгэл	Хувийн жин	Төлөвлөлт	Гүйцэтгэл	Хувийн жин	2008/2007 (гүйц)
Нийт орлого ба тусlamж	1851.19	100	2507.87	2156.38	100.00	116.5	86.0
Ургал орлого	1843.67	99.59	2488.55	2136.09	99.06	115.9	85.8
Татварын орлого	1500.72	81.40	2137.09	1888.93	87.60	125.9	88.4
Орлогын албан татвар	647.84	43.17	887.85	758.23	35.16	117.0	85.4
Нийгмийн даатгалын шимтэгл, хураамж	158.44	10.56	240.46	223.27	10.35	140.9	92.9
Өмчийн татвар	8.13	0.54	8.68	8.99	0.42	110.5	103.6
Дотоодын бараа, үйлчилгээний татвар	409.96	27.32	616.81	550.98	25.55	134.4	89.3
Гадаад худалдааны орлого	102.48	6.83	159.50	150.84	6.99	147.2	94.6
Бусад татвар	173.86	11.58	223.79	196.62	9.12	113.1	87.9
Татварын бус орлого	342.95	18.60	351.46	247.17	11.46	72.1	70.3
Хөрөнгийн орлого	2.51	0.14	3.51	4.44	0.21	176.7	126.5
Тусlamжийн орлого	5.01	0.27	0.02	0.02	0.74	316.5	100.2
Нийт зарлага ба цэвэр зээл	1747.31	100	2529.15	2462.05	100.00	140.9	97.3
Ургал зардал	1367.67	78.27	1823.33	1749.52	71.06	127.9	96.0
Бараа ба үйлчилгээний зардал	672.73	49.19	1062.00	1030.66	41.86	153.2	97.0
Зээлийн үйлчилгээний төлбөр	18.58	1.36	20.45	19.84	0.81	106.8	97.0
Татаас ба ургал шилжүүлэг	676.36	49.45	740.88	699.02	28.39	103.3	94.3
Хөрөнгийн зардал	299.50	17.14	631.62	624.90	25.38	208.6	98.9
Эргэж төлөгдөх цэвэр зээл	80.14	4.59	74.21	87.63	3.56	109.3	118.1
Ургал тэнцэл	488.30		0.7	0.4		79.2	58.1
Нийт тэнцэл	103.88		-21.28	-305.66		-294.3	1436.6
Алдагдлыгсанхүүжүүлсэн эх үүсвэр	-133.18		21.28	305.66		-229.5	1436.6
Гадаад, цэвэр	45.25		92.32	43.04		95.1	46.6
Дотоод, цэвэр	-178.42		-71.04	262.62		-147.2	-369.7



Зураг 4.6.

Төсвийн ашиг
алдагдал (ДНБ-д
эзлэх хувиар)



Зураг 4.7.

Нийт орлого ба
тусламж

Төсвийн орлого

Төсвийн нийт орлого ба тусlamжийн дүн төлөвлөсөн хэмжээнээс 351.5 тэрбум төгрөг буюу 14.0 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 275.9 тэрбум төгрөг буюу 14.7 хувиар өсч 2156.4 тэрбум төгрөгт хүрчээ.

Төсвийн нийт орлогын 99.1 хувийг бүрдүүлсэн урсгал орлого 2007 оныхоос 280.1 тэрбум төгрөг буюу 15.1 хувиар өсч, нийт орлого ба тусlamжийн дүнгийн өсөлтийг тодорхойлжээ. Урсгал орлогын 88.4 хувийг бүрдүүлсэн татварын орлого 386.6 тэрбум төгрөг буюу 25.7 хувиар нэмэгджээ. Орлогын албан татвар (татварын орлогын 40.1 хувийг бүрдүүлсэн) жилийн хугацаанд 109.7 тэрбум төгрөг буюу 16.9 хувь, дотоодын бараа, үйлчилгээний татварын орлого (татварын орлогын 29.2 хувийг бүрдүүлсэн) 139.2 тэрбум төгрөг буюу 33.8 хувь, нийгмийн даатгалын шимтгэл ба хураамжийн орлого (татварын орлогын 11.8 хувийг бүрдүүлсэн) 139.2 тэрбум төгрөг буюу 39.1 хувиар өссөн байна.


Орлогын албан татвараар төсөвт орсон орлого 16.9 хувь буюу 109.7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвараар 35.0 тэрбум төгрөг, хүн амын орлогын албан татвараар 41.2 тэрбум төгрөг төсөвт төвлөрсөнтэй холбоотой байна. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамжийн орлого 62.7 төгрөгөөр өссөн нь ажиллагчдын цалин хөлс нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Дотоодын бараа, үйлчилгээний татварын орлогын 64.4 хувийг бүрдүүлсэн нэмэгдсэн өртөгийн албан татварын орлого 33.9 хувь буюу 89.9 тэрбум төгрөг, онцгой албан татварын орлого (дотоодын бараа үйлчилгээний татварын орлогын 32.4 хувь) 33.4 хувь буюу 44.7 тэрбум төгрөгөөр өсчээ. Тайлант онд импортын бараанд ногдуулсан нэмэгдсэн өртгийн албан татвар 39.0 хувь буюу 77.6 тэрбум төгрөгөөр өссөн нь нэмэгдсэн өртгийн албан татварын орлого нэмэгдэхэд хүргэв. Мөн онцгой албан татварын дийлэнх хувийг бүрдүүлдэг дотоодын архины онцгой албан татвар 15.6 тэрбум төгрөг, суудлын автомашины онцгой албан татвар 31.8 тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь онцгой албан татварын орлогыг нэмэгдүүлэхэд голлон нөлөөлжээ.

Гадаад худалдааны орлого 47.2 хувь буюу 48.4 тэрбум төгрөгөөр өсч 150.8 тэрбум төгрөгт хүрчээ. Гадаад худалдааны орлогын 94.2 хувийг бүрдүүлдэг импортын барааны гаалийн албан татвар 47.6 хувь буюу 45.8 тэрбум төгрөг, экспортын гаалийн татвар (гадаад худалдааны орлогын 5.8 хувийг бүрдүүлсэн) 41.2 хувь буюу 2.6 тэрбум төгрөгөөр өссөн нь гадаад худалдааны орлогыг өсгөжээ. Бусад татварын орлого 15.1 хувь буюу 25.9 тэрбум төгрөгөөр өсч 196.6 тэрбум төгрөгт хүрсэн нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (бусад татварын орлогын 56.2 хувийг бүрдүүлсэн) 41.6 тэрбум төгрөг буюу 60.4 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.


Төсвийн зарлага

Тайлант онд төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн өмнөх оны мөн үеийнхээс 40.9 хувь буюу 714.7 тэрбум төгрөг, төлөвлөсөн хэмжээнээс 67.1 тэрбум төгрөг буюу 2.7 хувиар бага байна.



Зураг 4.8.

Нийт зардал
ба цэвэр
зээл



Зураг 4.9.

2008 оны ТОП 20
индекс

Урсгал зардал жилийн хугацаанд 381.9 тэрбум төгрөг буюу 27.9 хувь, хөрөнгийн зардал 325.4 тэрбум төгрөг буюу 108.6 хувь, эргэж төлөгдөх цэвэр зээл 7.5 тэрбум буюу 9.3 хувиар тус тус нэмэгджээ.

Урсгал зардлыг бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр нь авч үзвэл, бараа үйлчилгээний зардал (58.9 %) 2007 оны гүйцэтгэлтэй харьцуулахад 357.9 тэрбум төгрөг буюу 53.2 хувь, татаас ба шилжүүлэг(40.0 %) 22.7 тэрбум төгрөг буюу 3.3 хувь, зээлийн үйлчилгээний төлбөр (1.1 %) 1.3 тэрбум төгрөг буюу 6.8 хувиар өсчээ. Урсгал зардлын 58.9 хувийг эзэлдэг бараа үйлчилгээний зардлын өсөлтөд цалин хөлс өмнөх оныхоос 83.3 хувь буюу 246.8 тэрбум төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 111.2 тэрбум төгрөг буюу 29.5 хувиар тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.


Орон нутгийн төсөв

2008 онд орон нутгийн төсвийн нийт орлого 203.7 тэрбум төгрөг, нийт зардал 203.1 тэрбум төгрөг болж, төсвийн ашиг 561.3 сая төгрөгт хүрчээ.

4.5. Хөрөнгийн зах зээл


Тайлант онд Монголын Хөрөнгийн Биржид үнэт цаасны 258 удаагийн арилжаа явагдаж 201 компанийн 170.1 сая ширхэг хувьцаа, 66.3 мянган ширхэг бонд арилжигдаж, нийт 62.3 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна. Нийт гүйлгээний үнийн дунгийн 96.8 хувь буюу 60.3 тэрбум төгрөгийг хувьцааны арилжааны гүйлгээ, 2.4 хувь буюу 1.5 тэрбум төгрөгийг Засгийн газрын бонд, 0.8 хувь буюу 0.5 тэрбум төгрөгийг компанийн бондын арилжаа тус тус эзэлж байна. Арилжааны хэмжээг өмнөх онтой харьцуулахад хувьцааны арилжааны үнийн дун 1.8 тэрбум төгрөг буюу 2.9 хувь, Засгийн газрын бондын арилжааны дун 38.1 тэрбум төгрөг буюу 96.2 хувь, компанийн бондын арилжааний дун 0.3 тэрбум төгрөг буюу 40.9 хувиар тус тус буурчээ. Нийт зах зээлийн үнэлгээ 515.9 тэрбум төгрөгт хүрсэн нь ДНБ-ий 11.4 хувь байна. Таван толгой, Багануур, Шивээ овоо, МЦХ, АПУ, БиДиСек, Туул сонгино усны нөөц, Зоос банк, Говь, Шарын гол, НИК зэрэг нь хамгийн өндөр зах зээлийн үнэлгээтэй компаниуд юм.

Энэ онд нээлттэй хувьцаат компани болохоор Гермес центр, Анод банк, Ремикон, Хөх ган, Монфреш жүүс, Женко түр бюро зэрэг компаниуд шинээр бүртгүүлж хувьцаа гаргасан бол Хай Би Ойл, Би Ди Сек компаниуд үнэт цаасны анхдагч зах зээлд хувьцаа нэмж гарган нь арилжаалсан байна. Хөрөнгийн зах зээлд шинээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулахаар Ди Си Эф, Эм Ай Си Си, Арта-Инвест, Санхүүгийн хөгжил инвест, Эф Си Икс, ТТСек, Зюс капитал, Нортосек, Эм Ай Би Жи, Гаули, Лайфтайм инвест, Евроазия капитал монголиа, Финанс линк групп гэсэн 13 компани эрх авснаар, МХБ-ийн гишүүн, брокер дилериийн компанийн тоо 41-д хүрэв. Тайлант онд 37 ХК хувьцаа эзэмшигчиддээ 17.4 тэрбум төгрөгийн ногдол ашиг хуваарилсан нь 2007 оноос 3.5 дахин нэмэгджээ. Тайлант онд 134 компани хувь нийлүүлэгчдийн хурлаа зарласан байна.



Зураг 4.10.

Үргсгал дансны
бүтэц



Зураг 4.11.

Үргсгал данс (сая
ам.доллараар)

Хүснэгт 4.7. Арилжааны гүйлгээ (сая төгрөг)

	Арилжааны үнийн дүн		Өөрчлөлт	
	2006	2007	Үнийн дүн	Хувиар
ЗГ-ын бонд	39,599.3	1,494.7	-38,104.6	-96.2
Компанийн бонд	849.9	502.0	-347.7	-40.9
Хувьцаа	62,126.8	60,349.3	-1,777.5	-2.9

ТОП-20 үнийн индексийн үзүүлэлт өмнөх оны сүүлийн өдөр 10256.13 байсан бол энэ оны сүүлээр 5583.22, тайлант хугацааны дээд үзүүлэлт 13074.88 байна. ТОП-20 үнийн индескийн 2008 оны дундаж 9722.96 байв. ТОП-20 үнийн индекс 2008 оны 2-4 саруудад хамгийн өндөр буюу тухайн саруудын дундаж 12085.4-12668.9 байсан бол оны эцэст 5777.7 болж буурчээ.

Засгийн газрын бондын 4 удаагийн арилжаа явагдаж 16.1 мянган ширхэг бонд арилжигдсан байна. Харин компанийн бондын арилжаа 2008 оны 4 дүгээр сард 1 удаа явагдаж, 50.2 мянган ширхэг бонд арилжигдан 502.0 сая төгрөгийн гүйлгээ хийгджээ.

Хувьцааны арилжааны өдрийн дундаж нь хувьцааны тоо ширхгээр 659.5 мянга, үнийн дүнгээр 233.9 сая төгрөг болж байна. Тайлант хугацаанд тоо ширхгээр идэвхтэй арилжигдсан үнэт цаасанд Хөх ган /38.4 сая ширхэг/, Ремикон /34.8 сая ширхэг/, Гермес центр /33.0 сая ширхэг/, Анод банк /21.9 сая ширхэг/, Женко тур бюро /16.0 сая ширхэг/ ХК-уудын үнэт цааснууд орж байна. Харин арилжигдсан үнийн дүнгээр Анод банк /24.1 тэрбум төгрөг/, Хөх ган /4.2 тэрбум төгрөг/, Ремикон /3.5 тэрбум төгрөг/, Женко тур бюро /3.3 тэрбум төгрөг/ Гермес центр /3.2 тэрбум төгрөг/ ХК-уудын үнэт цаас идэвхтэй арилжигдажээ. Тайлант хугацаанд бүртгэлтэй 376 ХК-аас 201 компанийн үнэт цаас арилжигдаж 175 компанийн үнэт цаас арилжигдаагүй байна.


4.6. Төлбөрийн тэнцэл

Төлбөрийн тэнцлийн урсгал данс 2008 онд урьдчилсан байдлаар 677.0 сая ам.долларын алдагдалтай, хөрөнгө ба санхүүгийн данс 918.0 сая ам.долларын ашигтай гарч, алдаа ба орхигдуулга¹ 579.1 сая ам.доллар гарснаар нийт төлбөрийн тэнцэл 338.1 сая ам.долларын алдагдалтай гарлаа.

4.6.1 Урсгал дансны хөдөлгөөн

Тайлант онд барааны гадаад худалдаа 596.5 сая ам.долларын, үйлчилгээ 110.3 сая ам.долларын, цэвэр орлого 115.7 сая ам.долларын тус тус алдагдалтай, урсгал шилжүүлэг 208.1 сая ам.долларын ашигтай гарснаар урсгал данс 614.4 сая ам.долларын алдагдалтай гарлаа.

¹ Гадаадад зорчсон Монгол жуулчдын тоог Хил хамгаалах ерөнхий газраас авсан болно.



Гадаад худалдаа

Төлбөрийн тэнцэл дэх гадаад худалдааны эргэлт 2008 онд өмнөх оныхоос 43.2 хувиар нэмэгдэж, 5660.6 сая ам.долларт хүрлээ. Эрдэсийн бус барааны гадаад худалдааны эргэлт 2008 онд өмнөх оныхоос 34 хувиар нэмэгдэж 5297.3 сая ам.долларт хүрсэн байна.

Хүснэгт 4.8. Худалдааны тэнцэл (сая ам.доллар)

Үзүүлэлт	2007 он	2008 он	Жилийн өөрчлөлт	
			мөнгөн дүн	хувиар
Экспорт	1,950.7	2,530.4	579.7	29.7
Импорт	2,003.1	3,130.2	1,127.1	56.3
Худалдааны эргэлт	3,953.8	5,660.6	1,706.8	43.2
Худалдааны тэнцэл	-52.4	-599.9	-547.5	1,044.9

Төлбөрийн тэнцлийн аргачлалаар² тооцсон манай улсын нийт импорт³ 2007 онтой харьцуулахад 56.3 хувиар нэмэгдэн 3130.2 сая ам.доллар, экспортын хэмжээ⁴ 29.7 хувиар нэмэгдэн 2530.4 сая ам.долларт тус тус хүрч, гадаад худалдааны тэнцэл 599.9 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Гадаад худалдааны тэнцэл ийнхүү алдагдалтай гарсан нь импортын хурдацтай өсөлттэй холбоотой байв.

Гаалийн ерөнхий газрын статистикийн мэдээгээр валютын төлбөртэй гадаад худалдааны эргэлт 2008 онд 5472.9 сая ам.долларт хүрч 2007 оныхоос 51.4 хувь буюу 1859.1 сая ам.доллараар өсчээ. Үүнд нийт экспорт 2008 онтой харьцуулахад 31.7 хувиар өсч 2456.9 сая ам.доллар, нийт импорт 72.5 хувиар өсч 3016.0 сая ам.долларт хүрчээ. Валютын төлбөртэй гадаад худалдааны тэнцэл өмнөх онд 116.4 сая ам.долларын ашигтай байсан бол 2008 онд 559.2 сая ам.долларын алдагдалтай гарсан.

Хүснэгт 4.9. Валютын төлбөртэй гадаад худалдаа (сая ам.доллараар)

	2004	2005	2006	2007	2008	Өөрчлөлт	
						мөнгөн дүн	хувиар
Экспорт	734.0	962.6	1,447.1	1,865.1	2,456.9	591.8	31.7
Импорт	721.3	882.1	1,219.6	1,748.7	3,016.0	1,267.3	72.5
Худалдааны эргэлт	1,455.3	1,844.7	2,666.7	3,613.8	5,472.9	1,859.1	51.4
Худалдааны тэнцэл	12.7	80.5	227.5	116.4	-559.2	-675.6	-580.4

Манай улсын экспортолсон алтны хэмжээ тайлант онд 2007 оныхоос 91.2 хувиар өсч 22.1 тонн болжээ. Алтны экспортоос олох валютын орлого өмнөх оныхоос 365.0 сая ам.доллараар нэмэгдэж 599.9 сая ам.доллар болжээ. Алтны экспорт мөнгөн дүнгээр нийт валютын төлбөртэй экспортын орлогын 23.6 хувийг бүрдүүлсэн байна.

² Төлбөрийн тэнцлийн бусад үйлчилгээний хэсэгт санхүүгийн үйлчилгээ, компьютер, мэдээллийн үйлчилгээ, патент тэмдэгт, лицензийн хураамж, бусад бизнесийн үйлчилгээ, боловсрол соёлын үйлчилгээ болон засгийн газрын үйлчилгээ зэрэг орно.

³ Монгол Улсын Засгийн газрын ашигласан техник туслацааны хөрөнгийн дүнг Сангийн яамнаас хүлээн авсан бөгөөд урьдчилсан байдлаар тооцсон болно.

⁴ Гаалийн ерөнхий газрын экспортын үнийн дүн дээр татваргүй барааны орлого нэмэгдсэн болно.

Манай улсын нэг тонн зэсийн баяжмалын экспортын үнэ 2007 онтой харьцуулахад 7.4 хувиар өсч дунджаар 1433.6 ам.долларт хүрчээ. 2008 онд манай улсын экспортолсон зэсийн баяжмалын хэмжээ өмнөх оныхоос 4.1 хувиар буурч 582.9 мянган тонн, экспортын орлого нь өмнөх оныхоос 3.0 хувиар өсч 835.6 сая ам.доллар болжээ. Зэсийн экспорт валютын төлбөртэй экспортын орлогын 32.9 хувийг бүрдүүлсэн байна.

Хүснэгт 4.10. Алт, зэсийн баяжмалын экспорт, нефтийн бүтээгдэхүүний импорт

	2004	2005	2006	2007	2008	Өөрчлөлт	
							дүнгээр хувиар
Үнийн дүнгээр (сая ам.доллараар)							
Алтны экспорт	243.2	331.4	270.1	234.9	599.88	364.98	155.38
Зэсийн баяжмалын экспорт	284.3	326.2	635.4	811.5	835.63	24.13	2.97
Нефтийн бүтээгдэхүүний импорт	206.1	292.4	410.1	559.5	892.03	332.53	59.43
Биет хэмжээгээр (тонноор)							
Алтны экспорт (тонноор)	19.3	23.8	15.4	11.6	22.13	10.53	90.77
Зэсийн баяжмалын экспорт (мянган тонн)	562.6	587.1	599.5	607.8	582.89	-24.91	-4.1
Нефтийн бүтээгдэхүүний импорт (мянган тонн)	562.2	549.5	637.3	793.6	892.03	98.43	12.4

Монгол Улс 2008 онд нийтдээ 4728.4 тонн ноолуур, 63.3 мянган ширхэг ноолууран бүтээгдэхүүн экспортолж 180.7 сая ам.долларын орлого олжээ. Ноолуур, ноолууран бүтээгдэхүүний экспортын орлого 2007 оныхоос 7.8 хувиар буурч тайлант оны валютын төлбөртэй экспортын орлогын 7.1 хувийг бүрдүүлжээ.

Тайлант онд алт, зэсийн баяжмал, ноолуур, ноолууран бүтээгдэхүүний экспорт нийт валютын төлбөртэй экспортын 63.6 хувийг эзэлж байна.

Нефтийн бүтээгдэхүүний импортын хэмжээ 2008 онд өмнөх оныхоос 12.4 хувь буюу 98.4 мянган тонноор өсч 892.03 мянган тоннд хүрчээ. Нефтийн бүтээгдэхүүний импорт валютын төлбөртэй импортын 24.7 хувийг бүрдүүлэв.

Үйлчилгээ

Үйлчилгээний нийт орлого 2008 онд 468.2 сая ам.доллар, зарлага 620.8 сая ам.доллар болж үйлчилгээний тэнцэл 152.6 сая ам.долларын алдагдалтай гарав.

Аялал жуулчлалын салбар 35.8 сая ам.долларын орлоготой гарсан боловч импортын өсөлтөөс шалтгаалан⁵ тээврийн үйлчилгээ 104.9 сая ам.долларын, даатгалын үйлчилгээ 13.5 сая ам.долларын тус тус алдагдалтай гарсны зэрэгцээ барилгын үйлчилгээ болон суурилуулалтын ажлын зардалд 4.4 сая ам.доллар төлсөн нь үйлчилгээний тэнцэл алдагдалтай гарахад нөлөөлжээ.

⁵ Импортыг сиф нөхцөл рүү 11 хувиар шилжүүлэхэд 10 хувь нь тээврийн зардалд, улдсэн 1 хувь нь даатгалын зардал

Монгол улсад 2008 онд нийт 342.3 мянган гадаадын жуулчин⁶ ирж жуулчны орлого 229.5 сая ам.долларт хүрэв. Харин 315.1 мянган дотоодын жуулчид⁷ гадаадад аялж, гадаадад 169.0 сая ам.доллар зарцуулсан байна.

Хүснэгт 4.11. Жуулчлалын салбарын нийт орлого, зарлага (сая ам.доллар)

	2007	2008	Жилийн өөрчлөлт	
	тоон	дүн	хувиар	
Жуулчлалын салбарын нийт орлого	287.0	229.5	-57.5	-20.0
Гадаадын жуулчдын тоо	432,746.0	342,281.0	-90,465.0	-20.9
Жуулчлалын салбарын нийт зардал	166.6	169.0	2.4	1.4
Гадаадад жуулчилсан Монгол иргэдийн тоо	321,457.0	315,127.0	-6,330.0	1.9
Жуулчлалын цэвэр орлого	120.4	60.5	-59.9	-49.7

Бусад үйлчилгээний тэнцэл⁸ 2008 онд 52.5 сая ам.долларын алдагдалтай гарав.

Цэвэр орлого

Хамтарсан үйлдвэрүүдээс гадаадын хөрөнгө оруулагчдад шилжүүлсэн ногдол ашгийн хэмжээ 108.8 сая ам.доллар болсон, Засгийн газар болон хувийн хэвшил нийтдээ гадаадын зээл болон хадгаламж, харилцахын хүд 28.9 сая ам.долларыг төлж 18.1 сая ам.долларын хүүний орлого олсон болон гадаадын ажиллагсадад олгосон цалин хөлс 9.7 сая ам.доллар болж нэмэгдсэн зэрэг нь цэвэр орлогын данс 129.3 сая ам.долларын алдагдалтай гарахад голлон нөлөөлсөн байна.

Ургал шилжүүлэг

Монгол Улсын Засгийн газар 2008 онд урьдчилсан байдлаар нийт 109.9 сая ам.доллартай тэнцэх техник туслалцааны хөрөнгийг⁹ ашигласан байна. Монгол иргэдийн эх орон руугаа гүйвуулсан мөнгөний хэмжээ 214.8 сая ам.долларт хүрч, гадагш шилжүүлсэн гүйвуулгын хэмжээ 114.8 сая ам.доллар, цэвэр ургал шилжүүлэг 100.0 сая ам.долларын ашигтай гарав.

Хүснэгт 4.10. Ажиллагсдын гүйвуулга (сая ам.доллар)

	2007	2008	Жилийн өөрчлөлт	
	мөнгөн дүн	хувиар		
Ажилчдын гүйвуулга (цэвэр)	83.9	100	16.1	19.1
Гаднаас орж ирсэн	174.3	214.8	40.5	23.2
Гадагш шилжүүлсэн	90.3	114.8	24.5	27.1

⁶ Монгол улсад ирсэн гадаадын жуулчдын тоог Хил хамгаалах ерөнхий газраас авсан.

⁷ Гадаадад зорчсон Монгол жуулчдын тоог Хил хамгаалах ерөнхий газраас авсан болно.

⁸ Төлбөрийн тэнцийн бусад үйлчилгээний хэсэгт санхүүгийн үйлчилгээ, компьютер, мэдээллийн үйлчилгээ, патент тэмдэгт, лицензийн хураамж, бусад бизнесийн үйлчилгээ, боловсрол соёлын үйлчилгээ болон засгийн газрын үйлчилгээ зэрэг орно.

⁹ Монгол Улсын Засгийн газрын ашигласан техник туслалцааны хөрөнгийн дунг Сангийн яамнаас хүлээн авсан бөгөөд урьдчилсан байдлаар тооцсон болно.

4.6.2 Хөрөнгө ба санхүүгийн данс

Хөрөнгө ба санхүүгийн данс 2008 онд 918.0 сая ам.долларын ашигтай гарсан нь өмнөх онтой харьцуулахад 2.8 дахин нэмэгдсэн байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 2007 оноос 1.9 дахин нэмэгдэж цэвэр дүнгээр 682.5 сая ам.долларт хүрчээ. Манай улсаас бусад хөрөнгө оруулалтын хэлбэрээр 2008 онд 270.5 сая ам.доллар оржээ.

Монгол Улсын Засгийн газар олон улсын банк, санхүүгийн байгууллага, хандивлагч орнуудаас 2008 онд нийт 60.6 сая ам.долларын урт болон дунд хугацааны зээл авснаас Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк болон Японы Засгийн газраас авсан зээл нийт зээлийн 84.6 хувийг эзэлж байна.

Монгол Улсын Засгийн газар 2008 онд 41.2 сая ам.долларын үндсэн өр, 16.4 сая ам.долларын хүүний төлбөр, нийт 57.6 сая ам.долларын гадаад зээлийн үндсэн өр, хүүний төлбөр барагдуулсан байна.

Монгол Улсын эдийн засгийн харьят банк санхүүгийн байгууллага, аж ахуйн нэгж 2008 онд 224.4 сая ам.долларын урт хугацааны зээл авч 119.6 сая ам.долларын үндсэн өрийг барагдуулжээ. Худалдааны зээлийн хувьд цэвэр дүнгээр 72.4 сая долларын барааны төлбөрийг урьдчилж авсан байна.

МОНГОЛБАНКНААС 2008 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГЫН БА ТЕХНИКИЙН ШИНЖ ЧАНАРТАЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУРААНГУЙ

Д/д	сар, едөр	дугаар	нэр	Агуулга	
01. 17	28	Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай		Монголбанкны Ерөнхийлөгчийн 2006 оны 19 дүгээр тушаалаар баталсан "Банк хоорондын их дүнтэй гүйлгээний төлбөр тооцооны түр журам"-ын 5.4 дэх заалтыг "Банк нь Монголбанкин дахь валютын харилцах дансаас "өнөөдрөөр гүйцэтгэх" (today value) шилжүүлэг хийх тохиолдолр энэ талаар төлбөрийн даалгавар дээр тодорхой заасан байна" гэж, тушаалын 3 дугаар хавсралт "банк хооронд их дүнтэй гүйлгээний төлбөр тооцоог гүйцэтгэх ажлын гэрээ"-ний 1.5.3 дахь заалтад "ажлын өдрийн 16:00 цаг хүртэл" гэж өөрчлөн, 1.5.5 дахь заалтад "банкууд Монголбанкин дахь валютын харилцах дансаа today value-аар зуваатгаар хийгдэх байгаа нэг ширхэг шилжүүлгийг үнэлгээ 100 ам.доллар" гэснийг хасах, 2.12 дахь заалт буюу "Банк нь банк хоорондын их дүнтэй гүйлгээг дамжуулахдаа "Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх булэг (Financial Action Task Force)-ээс гаргасан 40 зөвлөмж"-ийн 5 дахь зөвлөмжийг дагаж мөрдсөн байна" гэж нэмжээ.	
01.28	50	Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай		Монголбанкны Ерөнхийлөгчийн 2006 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 19 дүгээр тушаалаар батлагдсан "Банк хоорондын бага дүнтэй гүйлгээний төлбөр тооцоог гүйцэтгэх ажлын гэрээ"-ний 1.5.2 дахь заалтыг "ISO 8583 стандартын дагуу багцалж явуулсан гүйлгээ болгоныг 150 төгрөгөөр тооцож авна." гэж, 1.6 дахь заалтад "Банк нь банк хоорондын бага дүнтэй гүйлгээг дамжуулахдаа "Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх булэг (Financial Action Task Force)-ээс гаргасан 40 зөвлөмж"-ийг үйл ажиллагаанд даагож мөрднө." гэж нэмэх, гэрээний 1.5.3, 1.5.4 дэх заалтыг тус тус хасав.	
03.05	99	Зарим заалтыг хүчингүй болгох тухай		Монголбанкны Ерөнхийлөгчийн 2004 оны 9 дүгээр сарын 6-ны өдрийн 446 дугаар тушаалаар батлагдсан "Монголбанкны орон нутаг дахь салбарын дүрэм"-ийн 1.3, 2.4.4, 3.1, 3.4, 3.25, 3.26 дахь заалтад заасан "банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо" гэснийг тус тус хасав.	
03.05	100	Тушаал хүчингүй болгох тухай		Монголбанкны Ерөнхийлөгчийн 2004 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 167 дугаар тушаалаар батлагдсан "Банк бус санхүүгийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн улгэрчилсэн багц журам", 2004 оны 11 дүгээр сарын 5-ны өдрийн 579 дүгээр тушаалаар батлагдсан "Банк бус санхүүгийн байгууллагын хувийн хэрэг хөтлөх заавар"-ыг хүчингүй болгов.	
03.27	1 2 9 / 133	Сангийн яам, Монголбанк хооронд мэдээлэл солилцох журам		Монгол Улсын төсөв, Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл зэрэг баримт бичгийг боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулахад мөнгөний болон сангийн бодлогын харилцан уялдааг хангах зорилгоор "Сангийн яам, Монголбанкны хооронд мэдээлэл солилцох журам"- болон "Сангийн яам, Монголбанкны хооронд мэдээлэл солилцох журам"-ын биелэлтийг хангах, түүнд байнгын ханалт тавьж, мөнгөний болон сангийн бодлогын харилцан уялдааг хангах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг тус тус баталжээ.	
05.05	197	Монголбанк наас арилжааны банкуудтай хийх своп хэлцлийн нөхцөл		Монголбанкны мөнгөний бодлогын хэрэгслийг боловсронгуй болгох, мөнгөний зах дахь хөрвөх болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг уян хатан, үр ашигтай удирдах, нөхцөлийг сайжруулах зорилгоор Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 4 дэх заалт, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг тус тус үндэслэн "Монголбанкнаас арилжааны банкуудтай хийх своп хэлцлийн нөхцөл"-ийг баталлаа.	

05.19	26 / 237	Сонгуулийн зардлын данс нээх, хаах, бүртгэл тайланг хөтлөх журам	Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо, Монголбанкнаас хамтран "Сонгуулийн зардлын данс нээх, хаах, бүртгэл тайланг хөтлөх журам"-ыг батлав.
06.02	239	Хөрвөх чадварын эрсдэлийг удирдах зөвлөмж батлах тухай	Монголбанкнаас тогтоосон журмын дагуу арилжааны банк нь төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангах, хадгаламж эзэмшигч, харилцагчийн мөнгөн хөрөнгийг анхны шаардлагаар гаргаж өгөх, шилжүүлж байх зорилгоор "Хөрвөх чадварыг эрсдэлийг удирдах зөвлөмж"-ийг баталлаа.
08.06	345	Журам батлах тухай	Терроризм болон терроризмыг санхүүжүүлэхүйлажиллагаанаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэхтэй холбогдуулж Монгол Улсын нэгдэн орсон Нэгдсэн Үндэсний Байгууллагын конвенц, тогтооюур террорист гэж зарлагдсан байгууллага, этгээдийн нэrsийн жагсаалтыг банкны байгууллагад мэдэгдэх, тэдгээрийн гүйлгээг түдгэлзүүлж холбогдох эрх бүхий төрийн байгууллагад шалгуулахаар мэдэгдэхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор "НҮБ-ын тогтооюур террорист гэж зарлагдсан байгууллага, этгээдийн нэrsийн жагсаалтыг гаргах, мэдээлэх, тэдгээрийн гүйлгээг түдгэлзүүлэх тухай журам"-ыг баталжээ.
10.17	446	Журам батлах тухай	Монгол Улсад үл хөдлөх хөрөнгө барьцаалан ипотекийн зээл олгох, эргэн төлүүлэх, хяналт тавих үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн нэгдсэн аргачлал, стандартаар ханган зохицуулах зорилгоор "Ипотекийн зээлийн үйл ажиллагааны журам"-ыг баталлаа.
10.20	453	Банкнаас батлан даалт гаргахад мөрдөх түр журамд ёөрчлөлт оруулах тухай	Монголбанкны Ерөнхийлөгчийн 2000 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 452 дугаар тушаалаар батлагдсан "Банкнаас батлан даалт гаргахад мөрдөх түр журам"-ын 5 дугаар бүлэгт дор дурдсан заалтыг нэмэв: 5.8 Батлан даалт гаргасан банк нь батлан даалтын гэрээний хугацаа дуусгавар болох өдрөөр төлбөрийн баримт (төлбөрийн даалтгар, энгийн болон шилжих вексель) үйлдэж, батлан даалтгар, гэрээг бүртгүүлэхдээ гэрээний хамт ирүүлнэ. 5.9 Батлан даалт гаргасан банк нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэгүй тохиолдолд Монголбанкны Төлбөр тооцоо, бүртгэлийн газрын холбогдох нягтлан бодогч төлбөрийн баримтыг үндэслэн данснаас хасалт хийнэ. 5.10 Батлан даалт гаргасан банк нь батлан даалтны дансны үлдэгдлийн баталгааг хавсралтын дагуу дараа сарын 5-ны өдрийн дотор Монголбанкны Төлбөр тооцоо, бүртгэлийн газарт ирүүлнэ. 5.11 Монголбанкны Төлбөр тооцоо, бүртгэлийн газар нь батлан даалтын үлдэгдлийн баталгааг авч, нийлж тохирч байгаа эсэхэд хяналт тавьж ажиллана.
11.14	501	Гадаад валютын хадгаламжийн тухай	Дэлхийн санхүүгийн зах зээлийн хямрал гүнэгийрч байгаатай холбогдуулан банкуудын гадаад активын эрсдэлийг бууруулах замаар банкны салбарын тогтвортой, найдвартай, аюулгүй байдлыг хангах зорилгоор банкнаас гадаад валютын хадгаламж татан төвлөрүүлэхийг Валют, эдийн засгийн газарт зөвшөөрсүгэй.

Захирлуудын Зөвлөлийн хүрэх үүрэг

Санхүүгийн тайланг бэлтгэх нь Захирлуудын Зөвлөлийн үүрэг байна.

Монголбанкны санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бэлтгэсэн болно. Захирлуудын Зөвлөл нь 2008 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны үйл ажиллагаа, тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үр дүн ба мөнгөн гүйлгээг энэхүү санхүүгийн тайланд үнэн зөвөөр илэрхийлэхийг баталгаажуулах үүрэгтэй.

Захирлуудын Зөвлөл нь Банкны санхүүгийн байдлыг үнэн зөв илэрхийлэх, нягтлан бодох бүртгэлийг зөв зохистой хөтөлж явуулдаг бөгөөд санхүүгийн тайлан нь Тодруулга 2-т тусгагдсан шаардлагуудад нийцэж байгаа гэдгийг баталгаажуулах үүрэгтэй.

Мөн Банкны хөрөнгийг хамгаалах, залилан, бусад зөрчил, дутагдлаас сэргийлэх, илрүүлэх арга хэмжээг авах нь Захирлуудын Зөвлөлийн үүрэг байdag.

Санхүүгийн тайланг (4-54 дүгээр хуудсанд үзүүлсэн) бэлтгэхдээ зохих бодлогыг баримталж, үндэслэлтэй бөгөөд зохистой шийдэл, тооцооллыг ашиглаж, нягтлан бодох бүртгэлийн бүхий л холбогдох стандартуудыг дагаж мөрдсөн гэж Захирлуудын Зөвлөл үзэж байна.

Захирлуудын Зөвлөлийн шийдвэрийн дагуу гарын үсэг зурсан:

Л.ПУРЭВДОРЖ
Ерөнхийлөгч, Монголбанк

Улаанбаатар



ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Монголбанкны гишүүдэд

Бид Монголбанкны 2008 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх тайлан тэнцэл, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн орлого, үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн дараахь санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгээлээ.

Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор Банкны удирдлагын хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх ба үнэн зөв толилуулах нь Банкны удирдлагын хариуцлага байдаг. Энэхүү хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх мөн нөхцөл байдалд уялдсан нягтлан бодох бүртгэлийн тооцоолуудыг хийх замаар залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэж байх хариуцлага орно.

Аудиторын хариуцлага

Хийж гүйцэтгэсэн аудит дээрээ үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт гарган, өөр аливаа нэг этгээдэд биш зөвхөн та бүхэнд тайлагнах нь бидний хариуцлага юм. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Дор дурьдснаас бусад тохиолдолд бид аудитаа Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Тэдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудад нийцэж ажиллах мөн санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар зохистой баталгаажуулалтыг олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана. Сонгон авах горимууд нь залилан болон алдааны улмаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдсэнээс үүсэх эрделийн үнэлгээ зэргийг багтаасан аудиторын мэргэжлийн үнэлэмжкээс хамаарна. Тэдгээр эредлийн үнэлгээнүүдийг хийхдээ аудитор нь байгууллагын дотоод хяналтын үр нөлөөтэй эсэх талаар дүгнэлт гаргах зорилгоор биш зөвхөн тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг зохиох үүднээс байгууллагын санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, тэдгээрийг үнэн зөв толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг харгалзаж үздэг. Мөн аудитын ажилд хэрэгжүүлж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын таарамж, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой тооцоолуудын бодитой эсэхийг үнэлж үзэх ажил орно.



Ernst & Young Mongolia Audit LLC

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ (үргэлжлэл)

Хязгаарлалттай дүгнэлт гаргах болсон үндэслэл

2008 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар, касс дахь бэлэн мөнгө 39.6 тэрбум (2007 онд 23.2 тэрбум) төгрөгийн, мөнгөжөөгүй алт, мөнгө 13.1 тэрбум (129.9 тэрбум) төгрөг, гүйлгээнд байгаа бэлэн мөнгө 407.2 тэрбум (364.1 тэрбум) төгрөг тус тус байсан. Монгол Улсын “Нууцын тухай хууль”-ийн заалтын улмаас бид Монголбанк өөрийн касс дахь бэлэн мөнгө ба мөнгөжөөгүй алт, мөнгийг тоолсон тооллогын үйл ажиллагааг ажиглах боломжгүй болсон. Үүнээс гадна, бид касс дахь бэлэн мөнгө ба мөнгөжөөгүй алт, мөнгөний биет too хэмжээг баталгаажуулах өөр сонголтод аудитын горимуудыг гүйцэтгэх боломжгүй байсан ба үүний улмаас касс дахь бэлэн мөнгө, мөнгөжөөгүй алт, мөнгө, гүйлгээн дэх бэлэн мөнгөний дүнг бид баталгаажуулж чадсангүй.

Санхүүгийн тайлангийн Тодруулга 15-ын (iii)-т дотоодын банкуудад олгосон зээлийн 2008 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх үлдэгдлийн дүнд дотоодын арилжааны банкны төлөх 84.7 тэрбум төгрөгийн зээл багтсан байгаа ба үүний 18.7 тэрбум төгрөгт нь үнэ цэнэ бууралтын алдагдлын сан байгуулсан болно. Одоогийн байдлаар энэхүү арилжааны банкинд онцгой дэглэм тогтоосон байгаа ба 2009 оны 5 дугаар сарын 20-ны өдөр Сангийн Яамтай гарын үсэг зурсан ойлголцлын санамж бичиг дээр үндэслэн, Монголбанкны захирлууд зээлийн үлдэгдэл болох 66.0 тэрбум төгрөгийг Монгол Улсын Засгийн газраас авна гэсэн дүгнэлттэй байна. Гэсэн хэдий ч, өөр бусад холбогдох нэмэлт мэдэлэл байхгүй байгаа учраас, бид энэхүү 66.0 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдлийн эргэн төлөлт ба 18.7 тэрбум төгрөгийн дүнтэй үнэ цэнийн бууралтыг баталгаажуулах өөр сонголтод аудитын горимуудыг гүйцэтгэх боломжгүй байсан.

Хязгаарлалттай дүгнэлт

Бидний дүгнэлтээр, хэрэв “Хязгаарлалттай дүгнэлт гаргах болсон үндэслэл”-д тодорхойлсон асуудлууд шаардлага хангахуйцаар шийдвэгдсэн бол хийх шаардлагатай гэж тодорхойлогдож болох байсан тэдгээр залруулгууд (хэрэв байгаа бол)-ын нөлөөллийг эс тооцвол, эдгээр санхүүгийн тайлангууд нь 2008 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлрагналын олон улсын стандартуудын дагуу үнэн зөв, бодитой үзүүлсэн байна.

Ernst & Young Mongolia Audit LLC

ЭРНСТ ЭНД ЯНГ МОНГОЛИЯ АУДИТ ХХК

Мэргэшсэн нягтлан бодогчид

ЧУНГ СИНГ ПЕТР ЁНГ

Захирал

Улаанбаатар хот, Монгол Улс

2009 оны 8 дугаар сарын 27

МОНГОЛБАНК

2008 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН ОРЛОГО, ҮР ДУНГИЙН ТАЙЛАН

	Тодруулга	2008 сая төгрөг	2007 сая төгрөг
Хүүний орлого	3	29,559	48,414
Хүүний зардал	4	(11,864)	(18,895)
Хүүний цэвэр орлого		17,695	29,519
Алт, үнэт металлын арилжааны цэвэр ашиг	5	41,221	29,831
Валютын ханшийн зөрүүний цэвэр ашиг	6	7,875	26,959
Үйл ажиллагааны бусад орлого		2,169	1,879
Үйл ажиллагааны нийт орлого		68,960	88,188
Болзошгүй алдагдлын зардал	7	(21,868)	(39,451)
Үйл ажиллагааны цэвэр орлого		47,092	48,737
Үйл ажиллагааны зардал	8	(6,995)	(4,890)
Үйл ажиллагааны бусад зардал	10	(10,683)	(36,719)
Тайлант жилийн ашиг		29,414	7,128

Хавсрласан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

МОНГОЛБАНК

2008 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ ТАЙЛАН ТЭНЦЭЛ

	Тодруулга	2008 сая тогrog	2007 сая тогrog
АКТИВ			
Бэлэн мөнгө		39,589	23,197
Алт ба үнэт металл	11	137,432	365,295
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө, хадгаламж	12	212,898	831,192
Санхүүгийн хөрөнгө оруулалт - Борлуулахад бэлэн	13	324,635	115,748
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	14	237,278	64,582
Дотоодын банкуудад олгосон зээл	15	224,354	19,292
Сангийн яаманд олгосон зээл	16	25,564	29,604
Үндсэн хөрөнгө	17	23,514	18,093
Бусад актив	18	316	2,416
НИЙТ АКТИВ		1,225,580	1,469,419
ПАССИВ			
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө		407,210	364,074
Гаргасан үнэт цаас	19	119,786	103,425
Гадаад өр толбөр	20	145,272	149,502
Засгийн газрын байгуулагуудын харилцах, хадгаламж	21	210,696	603,332
Дотоодын банкуудын харилцах, хадгаламж	22	226,526	171,027
Бусад пассив	23	42,705	38,346
НИЙТ ПАССИВ		1,152,195	1,429,706
ДҮРМИЙН САН БА НӨӨЦ			
Дүрмийн сан	24	5,000	5,000
Хуримтлагдсан ашиг		25,914	5,130
Ерөнхий нөөцийн сан	25	20,834	15,704
Бусад нөөц	26	21,637	13,879
НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		73,385	39,713
НИЙТ ПАССИВ БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		1,225,580	1,469,419

Хавсрласан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

МОНГОЛБАНК

2008 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

	2008 сая төгрөг	2007 сая төгрөг
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Тайлант жилийн ашиг	29,414	7,128
<i>Öiððeððöðð : -</i>		
Алтны дахин үнэлгээний бодит бус ашиг	(11,693)	(27,757)
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	(5,093)	(19,198)
Үндсэн хөрөнгийн элэгдэл	944	857
Данснаас хассан үндсэн хөрөнгө	4	17
Гаргасан аккредитивт байгуулсан сан	-	27,889
Дотоодын арилжааны банкуудад олгосон зээлийн үнэ цэнийн бууралтын сан	18,723	-
Бусад активын болзошгүй алдагдлын сан	3,145	39,329
Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх		
Үйл ажиллагааны ашиг	35,444	28,265
<i>— ёё ñæëëëððð ðð%äééí ðð÷ëëðð ðð: -</i>		
Мөнгөжсон алт ба үнэт металл	239,556	(169,668)
Санхүүгийн хөрөнгө оруулалт - Борлуулахад бэлэн	(206,449)	(53,578)
Урвуу буцаан худалдан авах хэлцүүд	(172,696)	51,385
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө, хадгаламж	624,360	(200,054)
Дотоодын банкуудад олгосон зээл	(223,785)	(919)
Сангийн яаманд олгосон зээл	4,040	6,218
Бусад актив	(1,045)	(22,281)
<i>— ёё ñæëëëððð ðð%äééí ðð÷ëëðð ðð: -</i>		
Гүйлгээнд гаргасан мөнгө	43,136	118,975
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүд	-	(77)
Гаргасан үнэт цаас	16,361	32,580
Гадаад өр төлбөр	(4,230)	(1,131)
Засгийн газрын байгууллагуудын харилцах, хадгаламж	(392,636)	198,203
Дотоодын банкуудын харилцах, хадгаламж	55,499	22,485
Бусад пассив	(114)	(8,226)
Үйл ажиллагаанаас орсон бэлэн мөнгөний цэвэр гүйлгээ	17,441	2,177
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	512	11
Үндсэн хөрөнгийн худалдан авалт	(1,561)	(702)
Хөрөнгө оруулалтад ашигласан цэвэр мөнгөн гүйлгээ	(1,049)	(691)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр осолт	16,392	1,486
Валютын ханшийн зорууний нолоо		919
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	23,197	20,792
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	39,589	23,197

Хавсрласан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

МОНГОЛБАНК

2008 ОНЫ 12 ДУТААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН ӨМЧИЙН ЕОРЧЛӨЛТҮҮДИЙН ТАЙЛАН

Хувьцасны нийтийн төгрөгийн хувь		Хувьцасны нийтийн төгрөгийн хувь		Хувьцасны нийтийн төгрөгийн хувь		Хувьцасны нийтийн төгрөгийн хувь	
Дүрмийн сан сая төгрөг		Ерөнхий нийц (Тодоруулга 25)		Бусад инон (Тодоруулга 26)		Хуримтлагдсан ашин- сая төгрөг	
Хувьцасын төгрөгийн хувь		Хувьцасын төгрөгийн хувь		Хувьцасын төгрөгийн хувь		Хувьцасын төгрөгийн хувь	
2007 оны 1 дүгээр сарын 1-нээр	5,000	11,145	12,410	4,561	33,116	4,561	33,116
Өөрийн хөрөнгөй шууд хүлээн зөвшөөрсөн нийт орлогыг бүрдүүлэх борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтуудын цэвэр ашиг Тайлант жилийн алдагдал	-	-	1,469	-	1,469	-	1,469
Тайлант жилийн нийт орлоготоо ба зарлага Нийгмийн хөгжлийн сандшилжүүлэснээгийн неөдөд шилжүүлсэн хуримтлагдсан ашиг	-	-	-	1,469	7,128	7,128	7,128
Ерөнхий неөдөд шилжүүлсэн хуримтлагдсан ашиг Тайлант жилийн нийт орлоготоо ба зардал	-	-	-	-	(2,000)	(2,000)	8,597
2007 оны 12 дугаар сарын 31-нээр	5,000	15,704	13,879	5,130	(4,559)	(4,559)	-
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтын цэвэр алдагдал буюу өөрийн хөрөнгөй шууд хүлээн зөвшөөрсөн нийт зардал Тайлант жилийн алдагдал	-	-	-	2,438	-	2,438	2,438
Тайлант жилийн нийт орлоготоо ба зардал Барилын дахин үнэлгээ Нийгмийн хөгжлийн сандшилжүүлэснээгийн неөдөд шилжүүлсэн хуримтлагдсан ашиг Тайлант жилийн нийт орлоготоо ба зардал	-	-	-	2,438	29,414	29,414	29,414
Барилын дахин үнэлгээ Нийгмийн хөгжлийн сандшилжүүлэснээгийн неөдөд шилжүүлсэн хуримтлагдсан ашиг Тайлант жилийн нийт орлоготоо ба зардал	-	-	-	5,320	-	-	5,320
Барилын дахин үнэлгээ Нийгмийн хөгжлийн сандшилжүүлэснээгийн неөдөд шилжүүлсэн хуримтлагдсан ашиг Тайлант жилийн нийт орлоготоо ба зардал	-	-	-	5,130	(3,500)	(3,500)	(5,130)
Барилын дахин үнэлгээ Нийгмийн хөгжлийн сандшилжүүлэснээгийн неөдөд шилжүүлсэн хуримтлагдсан ашиг Тайлант жилийн нийт орлоготоо ба зардал	-	-	-	20,834	21,657	21,657	21,657

Хавсрласан тодруулга нь ЭНЭХҮҮ САНХУУГИЙН ТАЙЛАНГИЙН САЛШГҮЙ ХЭСГ БОЛНО.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2008 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

1. БАНКНЫ ТУХАЙ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монголбанк нь Монгол Улсын Засгийн газрын 1924 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн тогтоолоор Монгол Улсын Төв Банк (цаашид Банк гэх) болон байгуулагдсан ба байршил нь: Монгол Улс, Улаанбаатар 46, Бага тойруу 9.

Банк нь бүхий л үйл ажиллагаагаа Монгол Улсад явуулдаг бөгөөд Англи Улсын Лондон хот дахь төлөөлөгчийн газраас өөр хилийн чанадад үйл ажиллагаа явуулдаг салбаргүй болно.

Банк нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн байгууллага. Банкны үндсэн зорилго нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгийн тогтвортой байдлыг баталгаажуулах ба санхүүгийн зах зээл, банкны системийн тогтвортой байдлыг хангах замаар тэнцвэртэй, тогтвортой үндэсний эдийн засгийн хөгжлийг дэмжих явдал юм.

Монголбанк нь эдгээр зорилгоо биелүүлэхийн тулд дараахь үйл ажиллагаануудыг явуулдаг. Үүнд:

- Төрийн мөнгөний бодлогыг боловсруулж, хэрэгжүүлнэ
- Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэх
- Банкны үйл ажиллагаанд хяналт тавих
- Банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулах
- Гадаад валютын улсын нөөцийг эзэмших, зохицуулах
- Гүйлгээнд мөнгөн тэмдэгт гаргах

Банкны 2008 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайлангуудыг гаргахыг Захирлуудын Зөвлөлийн 2009 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн шийдвэрээр зөвшөөрсөн.

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД

2.1 ТАЙЛАН БЭЛТГЭХ ҮНДЭСЛЭЛ

Банк нь өөрийн санхүүгийн тайлангуудыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл (НББОУСЗ)-өөс гаргасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (СТОУС)-ын дагуу бэлтгэдэг болно.

Бодит үнэ цэнээрээ хэмжигдэх барилгууд, “Борлуулахад бэлэн” санхүүгийн хөрөнгө оруулалтуудыг эс тооцвол санхүүгийн тайлангуудыг түүхэн өргтийн зарчмаар бэлтгэсэн болно. Санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг тодруулгад өөрөөр зааснаас бусад тохиолдолд саяын орноор, Монгол төгрөгөөр тайлагнасан.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2008 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО

(а) Хүүний болон түүнтэй адилтгах орлого ба зардал

“Арилжаалах зорилгоор эзэмшиж байгаа” эсвэл “Бодит үнийн өсөлт бууралт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх” гэж ангилагдсан санхүүгийн хэрэглүүрүүдээс бусад бүх хүүнтэй санхүүгийн хэрэгслүүдийн хүүний орлого, зардлыг холбогдох санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөрийн үр ашигт хүүний хувийг хэрэглэн орлогын тайланд “Хүү болон түүнтэй адилтгах орлого” ба “Хүү болон түүнтэй адилтгах зардал” гэж хүлээн зөвшөөрнө. Үнэ цэнийн бууралтад орсон зээл, урьдчилгааны хүүний орлогоос бусад хүүний орлогыг аккруэл сууриар орлого, үр дүngийн тайланд хүлээн зөвшөөрнө. Үнэ цэнийн бууралтад орсон санхүүгийн хөрөнгийн хүүний орлогыг үнэ цэнийн бууралтад орсон бүртгэлийн дунд хэрэглэсэн анхны үр ашигт хүүний хувь хэмжээгээр тооцож хүлээн зөвшөөрнө.

(б) Шимтгэлийн орлого

Банкны шимтгэлийн орлого нь ихэвчлэн банк хоорондын төлбөр тооцоо, гадаад банкуудын төлбөр тооцооны шимтгэлээс бүрддэг. Хураамж ба шимтгэлийн орлогыг ихэвчлэн үйлчилгээ үзүүлсэн хугацаанд нь аккруэл сууриар хүлээн зөвшөөрдөг.

(в) Гадаад валютын хөрвүүлэг

Банк нь санхүүгийн тайлангаа өөрийн үйл ажиллагааны болон тайлагналын мөнгөн нэгж болох Монгол төгрөгөөр гаргадаг. Гадаад валютын гүйлгээг анх бүртгэхдээ гүйлгээ хийгдсэн өдрийн ханшаар үйл ажиллагааны мөнгөн нэгж рүү хөрвүүлж бүртгэнэ. Гадаад валютаар бүртгэгдсэн мөнгөн хөрөнгө ба өр төлбөрүүдийг тайлан тэнцлийн өдрийн ханшаар хөрвүүлдэг. Банк нь гадаад валютаар илэрхийлэгдсэн өөрийн мөнгөн хөрөнгө ба өр төлбөрийг өдөр бүр дахин үнэлж байх бодлого барьдаг. Ханшийн бүх зөрүүг ашиг, алдагдлаар бүртгэнэ.

Түүхэн өртөг нь гадаад валютаар хэмжигдэх мөнгөн бус зүйлүүдийг анхны гүйлгээний өдрийн ханшаар хөрвүүлнэ. Бодит үнэ цэнэ нь гадаад валютаар хэмжигдэх мөнгөн бус зүйлүүдийг бодит үнэ цэнэ тодорхойлогдсон өдрийн ханшаар хөрвүүлнэ.

(г) Алт ба үнэт металл

Алтыг бодит үнэлгээгээр нь тайлан тэнцэлд тусгадаг бөгөөд дахин үнэлгээг сар бүр хийдэг. Алтны бодит үнийг тогтооходо алтны зах зээлийн үнийг харгалзан үздэг. Дахин үнэлгээний олз, гарзыг орлого, үр дүngийн тайланд хүлээн зөвшөөрнө.

Алт, мөнгө, зоос болон түүх соёлын үнэт зүйлсийг өртөг, цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар нь бүртгэдэг.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2008 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

(д) Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн гүйлгээний тайлангийн зорилгоор мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд касс дахь төгрөг, гадаад валют орно.

(е) Санхүүгийн хэрэглүүр - анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт

(i) Хүлээн зөвшөөрөх өдөр

Санхүүгийн хөрөнгө худалдан авах, худалдахад холбогдох хөрөнгийг нь зах зээлийн журам, хэлцлээр тогтоосон хугацаанд зайлшгүй шилжүүлэхийг шаарддаг эдгээр худалдан авалт, борлуулалтыг арилжаа хийгдсэн өдөр нь хүлээн зөвшөөрдөг. Өөрөөр хэлбэл банк хөрөнгийг худалдах, худалдан авахыг амласан өдөр хүлээн зөвшөөрнө. Үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүдийг арилжааны өдрөөр хүлээн зөвшөөрнө.

(ii) Санхүүгийн хэрэглүүрийн анхны хүлээн зөвшөөрөлт

Анх хүлээн зөвшөөрч буй санхүүгийн хэрэглүүрүүдийн ангилал нь тэдгээрийн зориулалт, шинж чанараас шалтгаална. Санхүүгийн хэрэглүүрүүдийг анхлан бодит үнээр нь хэмжих ба харин бодит үнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэхгүй санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн хувьд бодит үнэ дээр тэдгээртэй шууд холбоотой худалдан авалтын эсвэл гаргалтын ахиу зардлуудыг нэмсэн дунгээр бүртгэнэ.

(iii) Бодит үнийн өөрчлөлтийг нь орлого, зардлын дансанд бүртгэдэг үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүд

Үүсмэл санхүүгийн хэрэглүүрт алтны опционы, валютын ханшны форвард гэрээ хэлцлүүд, гадаад валютын опционы зэрэг багтана. Үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүдийг бодит үнэ цэнээр нь бүртгэдэг ба бодит үнэ цэнэ нь эерэг байгаа үед хөрөнгө, харин сөрөг байгаа үед өр төлбөр гэж бүртгэнэ. Арилжаалах зорилгоор эзэмшиж буй үүсмэл санхүүгийн хэрэгслүүдийн бодит үнийн өөрчлөлтийг “Үйл ажиллагааны бусад орлого” -оор бүртгэдэг.

Хөрвөх бондод агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүд гэх мэт өөр бусад санхүүгийн хэрэглүүрт агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүдийг салгаж авч үзэх ёстой ба агуулагдсан болон агуулагч гэрээнүүдийн эдийн засгийн үзүүлэлтүүд болон эрсдлүүд нь нягт хамааралгүй, мөн агуулагч гэрээг нь арилжаалах зорилгоор эзэмшээгүй ба анхны хүлээн зөвшөөрөлтөөр “Бодит үнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх”-д ангилаагүй байвал тэдгээрийг бодит үнээр нь бүртгэнэ. Агуулагч гэрээнээс нь салгасан үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүдийг арилжааны багц дахь бодит үнэ цэнийн өөрчлөлтөөр нь бүртгэх ба уг өөрчлөлтийг нь орлого, зарлагын дансанд бүртгэнэ.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2008 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

- (e) Санхүүгийн хэрэглүүр - анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт (үргэлжлэл)
- (iv) *Арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөр*

“Арилжаалах зорилгоор эзэмшиж буй” санхүүгийн хэрэгслүүдийг (үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүд үнд орохгүй) багтаасан “Арилжаалах зорилгоор эзэмшиж буй” санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөрүүдийг тайлан тэнцэлд бодит үнээр нь бүртгэнэ. “Үйл ажиллагааны бусад орлого”-д бодит үнийн өөрчлөлтийг тусгана. Хүүний болон ногдол ашгийн орлого эсвэл зардлыг гэрээний нөхцлийн дагуу эсвэл төлбөрийн эрх үүссэн үед нь “Үйл ажиллагааны бусад орлого”-д бүртгэнэ.

Энэ бүлэгт ойрын хугацаанд борлуулах эсвэл эргүүлэн худалдан авах зорилгоор олж авсан өрийн бичгүүд, энгийн хувьцаа, үнэт цаасууд орсон.

- (v) *Бодит үнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгддэг санхүүгийн хөрөнгө болон өр төлбөр*

Дараах нөхцлүүд хангагдсан үед санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг анхлан хүлээн зөвшөөрөхдөө энэ ангилалд оруулахаар шийдвэрлэж болно. Үүнд:

- энэхүү шийдвэр нь активыг хэмжих эсвэл активаас үүсэх олз гарзыг ялгаатай сууриар орлого, зардалд хүлээн зөвшөөрсөнөөс бий болох тууштай бус байдлыг арилгах эсвэл дорвitoйгоор бууруулах; эсвэл
- эдгээр санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр нь санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн бүлгийн нэг хэсэг эсвэл аль аль нь бөгөөд тэдгээрийг хүчин төгөлдөр эрсдэлийн удирдлагын бодлого эсвэл хөрөнгө оруулалтын стратегийн дагуу удирдаж, гүйцэтгэлийг нь бодит үнэ дээр нь суурилан хэмждэг; эсвэл
- санхүүгийн хэрэглүүрт агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэгсэл багтаж байгаа бол (гэхдээ агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэглүүр нь мөнгөн урсгалыг нь ихээхэн хэмжээгээр өөрчлөхгүй нь, эсвэл бага хэмжээний судалгааны үндсэн дээр эсвэл огт судалгаагүйгээр уг хэрэглүүр тусдаа бүртгэгдэхгүй нь тодорхой байгаагаас бусад тохиолдолд).

Бодит үнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг тайлан тэнцэлд бодит үнээр нь тусгана. Бодит үнийн өөрчлөлтийг “Бодит үнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн цэвэр олз эсвэл гарз” дансанд бүртгэнэ. Орж ирэх эсвэл төлөх хүүг гэрээний нөхцлийн дагуу хүүний орлого, зардалд хуримтлуулж, ногдол ашгийн орлогыг тус ногдол ашгийг хүртэх эрх үүссэн үед нь “Үйл ажиллагааны бусад орлого”-д бүртгэнэ.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2008 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

- (e) Санхүүгийн хэрэглүүр - анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт (үргэлжлэл)

(vi) *'Анхны өдөр'-ийн ашиг*

Идэвхигүй зах зээл дээрх арилжааны үнэ нь ижил хэрэглүүрийн хувьд зах зээл дээр ажиглаж болохуйц одоогийн зах зээлийн бодит үнээс зөрүүтэй эсвэл зөвхөн зах зээл дээр ажиглаж болохуйц өгөгдлийг багтаасан хувьсагчтай үнэлгээний загварт үндэслэн тогтоосон бодит үнээс зөрүүтэй байвал уг зөрүүг (энэ нь бодит үнэ ба арилжааны үнийн зөрүү буюу анхны өдрийн ашиг юм) Банк орлого, үр дүнгийн тайлангийн “Арилжааны цэвэр орлого”-д шууд хүлээн зөвшөөрөнө. Ажиглах боломжгүй өгөгдлийг ашигласан тохиолдолд арилжааны үнийн зөрүү ба загварын үнийн зөрүүг орлого үр дүнгийн тайланд өгөгдлүүд нь ажиглах үед эсвэл тухайн хэрэгслийг үл хүлээн зөвшөөрөх үед л хүлээн зөвшөөрнө.

(vii) *Дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалт*

Банк нь дуусгавар хугацаа хүртэл эзэмших зорилго, чадвартай, тогтмол эсвэл тодорхойлж болохуйц төлбөртэй ба тогтоосон хугацаатай санхүүгийн хэрэглүүрүүдийг дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалт гэнэ. Эхний хэмжилтийн дараа дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалтыг үр ашигт хүүний арга ашиглаж тооцсон хорогдуулсан өртгөөс үнэ цэнийн бууралтын санг хассан дүнгээр хэмжинэ. Хорогдуулсан өртгийг үр ашигт хүүний салшгүй хэсэг болох худалдан авалтын урамшуулал, хөнгөлөлт болон шимтгэлийг оролцуулан тооцдог. Хорогдуулалт нь орлого, үр дүнгийн тайлангийн “Хүү болон түүнтэй адилтгах орлого”-д багтана. Уг хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтаас үссэн алдагдлыг орлого, үр дүнгийн тайлангийн “Санхүүгийн хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтын алдагдал” хэсэгт хүлээн зөвшөөрнө.

(viii) *Банкуудад байршуулсан харилцах, хадгаламж ба зээл, урьдчилгаа*

Бусад банкуудад байршуулсан харилцах, хадгаламж ба зээл, урьдчилгааг үр ашигт хүүгийн аргыг хэрэглэн хорогдуулсан өртгөөс үнэ цэнэ бууралтын санг хассан дүнгээр бүртгэнэ. Хорогдуулсан өртгийг үр ашигт хүүгийн салшгүй хэсэг болох худалдан авалтын урамшуулал, хөнгөлөлт болон шимтгэлийг оролцуулан тооцно. Хорогдуулалт нь орлого, үр дүнгийн тайлангийн “Хүү болон түүнтэй адилтгах орлого”-д багтана. Уг хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтаас үссэн алдагдлыг орлого, үр дүнгийн тайлангийн “Зээлийн алдагдлын зардал” хэсэгт хүлээн зөвшөөрнө.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2008 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

- (e) Санхүүгийн хэрэглүүр - анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт (үргэлжлэл)

(ix) Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт

Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт гэж анхны хүлээн зөвшөөрөлтөөр ийнхүү ангилагдсан эсвэл бодит үнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгддэг, дуусгавар хугацаа хүртэл эзэмших эсвэл зээл ба урьдчилгаа гэсэн ангилалд багтаагүй санхүүгийн хөрөнгийг хэлнэ. Эдгээрт өөрийн хөрөнгийн хэрэгсэл, хамтын санд оруулсан хөрөнгө оруулалтууд, мөнгөний зах зээлийн болон өрийн хэрэглүүрүүд багтдаг.

Анх хүлээн зөвшөөрсний дараа борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтыг бодит үнээр нь хэмждэг. Хэрэгжээгүй ашиг алдагдлыг өөрийн хөрөнгийн “Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын нөөц”-д бүртгэдэг. Хөрөнгө оруулалтыг борлуулахад, өмнө хүлээн зөвшөөрсөн хуримтлагдсан ашиг эсвэл алдагдлыг орлого, үр дүнгийн тайланд “Бусад үйл ажиллагааны орлого” эсвэл “Бусад үйл ажиллагааны зардал”-аар хүлээн зөвшөөрнө. Банк нь нэг төрлийн үнэт цаасанд нэгээс илүү удаа хөрөнгө оруулсан бол тэдгээрийг “эхэлж авснаа эхэлж зарлагадах” зарчмыг баримтлан борлуулсан гэж үзнэ. Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтыг эзэмшиж байх хугацаанд олсон хүүг үр ашигт хүүний аргаар тооцон, хүүгийн орлого гэж тайлagnадаг. Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтыг эзэмшиж байх хугацаанд олсон ногдол ашгийг төлбөрийн эрх нь тогтоогдсон үед орлого, үр дүнгийн тайлангийн “Үйл ажиллагааны бусад орлого”-д хүлээн зөвшөөрдөг. Ийнхүү хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтаас үссэн алдагдлыг орлого, үр дүнгийн тайлангийн “Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдал”-д хүлээн зөвшөөрч, борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын нөөцөөс хасч өгнө.

(x) Төв Банкны үнэт цаас ба гадаад өр төлбөр

Гэрээт зохицуулалтын агуулга нь өөрийн тодорхой тооны хувьцааны оронд бэлэн мөнгө эсвэл өөр ямар нэг санхүүгийн хөрөнгийг өгөх үүргийг Банкинд үссгэж байгаа үед, Банкнаас гаргасан бөгөөд “Бодит үнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгдэх” гэж ангилагдаагүй санхүүгийн хэрэглүүрүүд эсвэл тэдгээрийн бүрдэл хэсгүүдийг “Төв банкны үнэт цаас ба гадаад өр төлбөр” гэсэн нэрээр өр төлбөрийн хэсэгт ангилна. Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн аль алиных нь элементийг агуулсан нийлмэл санхүүгийн хэрэглүүрүүдийн бүрэлдэхүүн хэсгүүдийг салгаж тус тусад нь бүртгэх бөгөөд өөрийн хөрөнгийн бүрэлдэхүүн хэсгийн дүн нь нийт дүнгээс өр төлбөрийн хэсгийн бодит үнэ (уг өр төлбөр үссэн өдрийн бодит үнэ)-ийг хассан дүн байна.

Анх хүлээн зөвшөөрсний дараа, Төв Банкны үнэт цаас ба гадаад өр төлбөрийг дараагийн тайлант хугацаанд үр ашигт хүүний аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ. Хорогдуулсан өргтийг тооцоходоо эдгээрийг гаргах эсвэл үссгэх үеийн хөнгөлөлт эсвэл урамшуулал, үр ашигт хүүг бүрдүүлж буй зардлуудыг авч үзнэ.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2008 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

(e) Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт

(i) Санхүүгийн хөрөнгө

Дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгийг (хэрэглэх боломжтой бол, санхүүгийн хөрөнгийн нэг хэсгийг эсвэл хоорондоо төсөөтэй нэг бүлэг санхүүгийн хөрөнгүүдийг) үл хүлээн зөвшөөрнө:

- Тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрх нь дууссан; эсвэл
- Банк тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал авах эрхээ шилжүүлсэн эсвэл “дамжуулан өнгөрөөх” хэлцлийн дагуу хүлээн авсан мөнгөө нийт дүнгээр нь удаан хугацаагаар саатуулалгүйгээр гуравдагч талд төлөх үүрэг хүлээсэн бол
- Банк хөрөнгийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлсэн эсвэл Банк тухайн хөрөнгөтэй холбоотой эрсдэл ба өгөөжийг их хэмжээгээр шилжүүлээгүй мөн авч үлдээгүй боловч хөрөнгийн хяналтыг шилжүүлсэн

Банк хөрөнгөөс мөнгө хүлээн авах эрхээ шилжүүлсэн эсвэл “дамжуулан өнгөрөөх” хэлцэл хийсэн боловч хөрөнгөтэй холбоотой ихэнх эрсдэл ба өгөөжийг болон хяналтыг шилжүүлээгүй мөн авч үлдээгүй тохиолдолд хөрөнгийг Банкны уг хөрөнгөд үргэлжлүүлэн оролцсоор байх хэмжээгээр нь хүлээн зөвшөөрнө. Энэхүү үргэлжилсэн оролцоо нь шилжүүлсэн хөрөнгийн баталгаа хэлбэртэй байвал оролцоог тус хөрөнгийн анхны бүртгэлийн дүн ба Банкны төлөх шаардлагатай болох хамгийн их дүнгийн аль багаар хэмжинэ.

Шилжүүлсэн хөрөнгөтэй холбоотой үргэлжилсэн оролцоо нь борлуулсан ба/эсвэл худалдан авсан опцион (үүнд бэлэн мөнгөөр төлбөр хийгддэг опцион эсвэл ижил төрлийн хэлэлцээр багтсан) хэлбэртэй байвал тус оролцооны дүн нь Банкны буцаан худалдан авч болзошгүй шилжүүлсэн хөрөнгийн дүн юм. Гэсэн хэдий ч, бодит үнэ цэнээр хэмжигддэг хөрөнгийг худалдах опционтой үед Банкны үргэлжлүүлэн оролцсоор байх хэмжээ нь шилжүүлсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ болон опцион хэрэгжих үнийн аль багаар нь хязгаарлагдана.

(ii) Санхүүгийн өр төлбөр

Санхүүгийн өр төлбөрийг төлөхөөс чөлөөлөгдсөн, өр төлбөр цуцлагдсан эсвэл хугацаа нь дууссан бол үл хүлээн зөвшөөрдөг. Хэрэв одоо оршин байгаа санхүүгийн өр төлбөрийн зээлдүүлэгч нь хэвээрээ боловч ялгаатай нөхцөлтэй зээлийн гэрээгээр орлуулсан эсвэл одоо байгаа зээлийн нөхцөл эрс өөрчлөгдсөн бол эдгээр өөрчлөлт шинэчлэлтийн дагуу өмнөх санхүүгийн өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрөх ба шинэ өр төлбөрийг хүлээн зөвшөөрч, тус тусынх нь дансны үнийн зөрүүг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2008 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

(ж) Бодит үнэ цэнийн тодорхойлолт

Идэвхтэй зах зээл дээр арилжаалагдаж буй санхүүгийн хэрэглүүрүүдийн тайлан тэнцлийн өдрийн бодит үнэ нь аливаа гүйлгээний зардлыг хасаагүй биржийн ханш болон диллерийн үнэ (урт позицийн хувьд авах үнэ, богино позицийн хувьд зарах үнэ) дээр үндэслэнэ. Идэвхтэй зах зээл дээр бүртгэлгүй санхүүгийн хэрэглүүрүүдийн хувьд бодит үнийг нь тохиromжтой үнэлгээний аргуудыг ашиглан тодорхойлно. Эдгээр аргуудад цэвэр өнөөгийн үнэ цэнийн арга, ажиглаж болохуйц зах зээлийн үнэтэй, төсөөтэй өөр бусад санхүүгийн хэрэглүүрүүдтэй харьцуулах арга, опционы үнэлгээний загвар, холбогдох бусад үнэлгээний загварууд багтана.

(з) Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Банк нь санхүүгийн хөрөнгө эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгүүд нь үнэ цэнийн бууралтад орсныг нотлох бодит нотолгоо байгаа эсэхийг тайлан тэнцлийн өдөр бүр үнэлж үзнэ. Хэрэв хөрөнгийг анхлан хүлээн зөвшөөрсний дараа нэг буюу түүнээс олон тооны “Алдагдлын тохиолдол”-ын улмаас үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо бий болсон ба уг “Алдагдлын тохиолдол” нь санхүүгийн хөрөнгө эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийн бодитойгоор тооцоолох боломжтой ирээдүйн мөнгөн урсгалд нөлөөлж байгаа үед санхүүгийн хөрөнгийг эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийг үнэ цэнийн бууралтад орсон гэж үзнэ. Үнэ цэнийн бууралтын нотолгоонд зээлдэгч эсвэл бүлэг зээлдэгчид нь санхүүгийн томоохон хүндрэлд орсон, зээлийн хүү болон үндсэн төлбөр зөрчилд орсон, дампуурал эсвэл санхүүгийн өөр бусад дахин зохион байгуулалтанд орох магадлалтай болсон, зөрчилтэй холбоотой эдийн засгийн нөхцөл байдалд гарсан өөрчлөлт гэх мэт тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалд хэмжиж болохуйц бууралт байгааг харуулсан бодит өгөгдөл бий болох зэрэг орно.

(i) Бусад банкуудад байршуулсан харилцах, хадгаламж ба олгосон зээл, урьдчилгаа

Хорогдуулсан өртгөөр бүртгэгддэг, бусад банкуудад байршуулсан харилцах, хадгаламж ба олгосон зээл, урьдчилгааны дүнгүүдийн хувьд Банк нь эхлээд дангаараа чухал ач холбогдолтой санхүүгийн хөрөнгө тус бүрийн хувьд үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байгаа эсэхийг нэг бүрчлэн (тусгайлан), дараа нь чухал ач холбогдолгүй санхүүгийн хөрөнгүүдийг нийлүүлэн (бүлгээр нь) үнэлнэ. Хэрэв Банк нь нэг бүрчлэн үнэлэгдсэн санхүүгийн хөрөнгийн үнэлгээний хувьд (чухал ач холбогдолтой, холбогдолгүй эсэхийг үл харгалzan) үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байхгүй гэж үзвэл ойролцоо зээлийн эрсдлийн шинж чанар бүхий санхүүгийн хөрөнгийн бүлэгт оруулан үнэ цэнийн бууралтыг нь нэгдсэн байдлаар үнэлдэг. Үнэ цэнийн бууралтын нэг бүрчилсэн үнэлгээ хийгдсэн, үнэ цэнийн бууралтын алдагдал нь хүлээн зөвшөөрөгдсөн, эсвэл үргэлжиж буй хөрөнгийг бүлгийн үнэ цэнийн бууралтын үнэлгээнд оруулахгүй.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2008 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

(3) Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)

- (i) *Бусад банкуудад байршиулсан харилцах, хадгаламж ба олгосон зээл, урьдчиллага (үргэлжлэл)*

Үнэ цэнийн бууралтын алдагдал гарсан талаар бодит нотолгоо байгаа бол алдагдлыг тухайн хөрөнгийн бүртгэлийн дүн ба ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн (бодитоор тохиолдоогүй ирээдүйд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг оруулахгүй) зөрүүгээр хэмжинэ. Хөрөнгийн бүртгэлийн дүнг эрсдлийн сангийн дансаар бууруулах ба алдагдлын дүнг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө. Хүүний орлогыг хөрөнгийн анхны, үр ашигт хүүний хувиар бууруулсан хөрөнгийн дүнгээс үргэлжлүүлэн тооцно. Цашид эргэн төлөгдхөм ямар нэг бодит чиг хандлага байхгүй ба барьцаа хөрөнгө нь бүрэн ашиглагдсан эсвэл банкинд бүрэн шилжсэн үед зээлийг холбогдох зээлийн эрсдлийн сангийн хамт данснаас хасна. Хэрэв дараагийн жил нь үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрсний дараах үйл явдлын улмаас тооцоолсон үнэ цэнийн бууралтын алдагдал өсөх эсвэл буурвал эрсдэлийн санг тохишуулах замаар үнэ цэнийн бууралтын алдагдлыг өсгөж эсвэл бууруулж болно. Хэрэв өмнө данснаас хассан байсан зээл эргэн төлөгдвэл тус төлөлтийг “Зээлийн алдагдлын зардал” дансны кредит талд бичнэ.

Орж ирнэ гэж тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг санхүүгийн хөрөнгийн анхны, үр ашигт хүүний хувиар бууруулан тооцдог. Зээлийн хүүний хувь нь хөвөгч байх нөхцөл үнэ цэнийн бууралтын алдагдлыг хэмжих хөнгөлөлтийн хувь нь өнөөгийн үр ашигт хүүний хувьтай тэнцүү байна. Барьцаатай санхүүгийн хөрөнгийн ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн тооцоо нь барьцааг хураан авах нь боломжтой эсэхээс үл хамааран тус барьцааг хураан авч, албадан борлуулахад гарах зардлыг хассаны дараах мөнгөн урсгалыг харуулдаг.

Үнэ цэнийн бууралтыг нэгдсэн байдлаар үнэлэхийн тулд санхүүгийн хөрөнгийн төрөл, хамаарах салбар, газарзүйн байрлал, барьцаа хөрөнгийн төрөл, хугацаа хэтрэлтийн байдал болон бусад гол хүчин зүйлс зэрэг зээлийн эрсдлийн шинж чанарыг агуулсан банкны дотоод зээллэгийн ангиллын системд үндэслэн тэдгээрийг бүлэглэнэ.

Үнэ цэнийн бууралтын бүлгийн үнэлгээнд хамрагдсан бүлэг санхүүгийн хөрөнгийн ирээдүйн мөнгөн урсгалыг ойролцоолон тооцоходо бүлэгт багтаж буй хөрөнгүүдийн зээлийн эрсдэлийн шинж чанартай холбоотойгоор гарч байсан түүхэн алдагдалын хувь хэмжээг ашиглана. Өнөө үед үгүй болсон түүхэн нөхцөл байдалын нөлөөг арилгах, түүхэн алдагдлын суурилж буй жилүүдэд хамааралгүй өнөөгийн нөхцөл байдалын нөлөөг харуулах үүднээс түүхэн алдагдлын мэдээнд өнөө үед ажиглагдахайц өгөгдлүүдэд үндэслэн тохиргоо хийнэ. Ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалын өөрчлөлтийн тооцоолол нь жил жилийн ажиглаж болохуйц холбогдох өгөгдлүүдийн өөрчлөлтүүдийг тусгасан. (Үүнд: ажилгүйдлийн түвшин, эд хөрөнгийн үнэ, өргөн хэрэглээний барааны үнэ, төлбөрийн чадавхи, алдагдлыг илэрхийлэх хүчин зүйлс бүлгээр болон ач холбогдоор нь). Ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалыг тооцоолоход ашигласан аргачлал, таамаглалуудыг тооцоолсон алдагдал, бодитоор хүлээсэн алдагдлын хоорондын зөрүүг багасгах зорилгоор тогтмол хянана.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2008 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

(з) Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)

(ii) Дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалт

Банк нь дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт нэг бүр дээр үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байгаа эсэхийг үнэлж үзнэ. Үнэ цэнэ бууралтын алдагдал гарсан талаар бодит нотолгоо байгаа бол алдагдлыг тухайн хөрөнгийн бүртгэлийн дүн ба тооцоолсон ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ хоёрын зөрүүгээр хэмжинэ. Хөрөнгийн бүртгэлийн дүнг бууруулж, алдагдалын дүнг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө.

Хэрэв дараагийн тайлант жилд тооцоолж байсан үнэ цэнийн бууралтын алдагдлын хэмжээ нь уг үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрсний дараа тохиолдсон үйл явдлын улмаас буурвал өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын алдагдлыг “Санхүүгийн хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтын алдагдал” дансны кредитэд бүртгэнэ.

(iii) Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт

Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтын хувьд, Банк нь хөрөнгө оруулалт эсвэл бүлэг хөрөнгө оруулалт нь үнэ цэнийн бууралтад орсныг нотлох бодит нотолгоо байгаа эсэхийг тайлан тэнцлийн өдөр бүр үнэлж үзнэ.

“Борлуулахад бэлэн” гэж ангилагдсан өөрийн хөрөнгийн хөрөнгө оруулалтын хувьд үнэ цэнийн бууралтын бодит нотолгоонд бодит үнэ цэнэ нь тус хэрэглүүрийн өртгөөс их хэмжээгээр эсвэл тогтмол буурч байх явдал ордог. Үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байгаа тохиолдолд хуримтлагдсан алдагдал (худалдан авалт ба өнөөгийн бодит үнэ цэнэ хоёрын зөрүүнээс орлогын тайланд өмнө нь хүлээн зөвшөөрсөн байсан тухайн хөрөнгө оруулалттай холбоотой үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр хэмжигдэх)-ыг өөрийн хөрөнгөөс хасч орлогын тайланд хүлээн зөвшөөрнө. Өөрийн хөрөнгийн хөрөнгө оруулалтын үнэ цэнэ бууралтын алдагдлын буцаалтыг орлогын тайлангаар дамжуулдаггүй, үнэ цэнийн бууралтын дараах бодит үнийн өсөлтийг өөрийн хөрөнгөд тусгана.

“Борлуулахад бэлэн” гэж ангилагдсан өрийн хөрөнгийн хэрэгслийн хувьд түүний үнэ цэнийн бууралтыг хорогдуулсан өртгөөр бүртгэгдэх санхүүгийн хөрөнгүүдтэй адил шалгур үзүүлэлтүүд дээр суурилан үнэлнэ. Зээлийн бууруулсан бүртгэлийн дүнгээс анхны үр ашигт хүүний хувь хэмжээгээр тооцон, хүүг үргэлжлүүлэн хуримтлуулах ба “Хүүний ба түүнтэй адилтгах орлого”-ын нэг хэсэг болгон бүртгэнэ. Хэрэв дараагийн тайлант жилд өрийн хэрэгслийн бодит үнэ цэнэ нь өссөн ба уг өсөлт нь үнэ цэнэ бууралтын алдагдлыг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрсний дараа тохиолдсон үйл явдалтай уялдаатай болох нь тогтоогдсон бол, үнэ цэнэ бууралтын алдагдлыг орлогын тайлангаар дамжуулан буцаана.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2008 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

(3) Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)

(iv) Зээлийн шинэчилсэн гэрээ

Банк нь барьцаа хөрөнгийг хурааж өөрийн болгохоос илүүтэйгээр аль болох гэрээг шинэчлэн байгуулах боломжийг хайж байдаг. Үүнд зээлийн эргэн төлөлтийн хуваарийг сунгах, зээлийн шинэ нөхцлийг санал болгох зэрэг ойлголтыг хамруулж болох юм. Зээлийн гэрээг нэгэнт шинэчлэн байгуулсан бол зээлийг хугацаа хэтгэрсэн гэж үзэхгүй. Гэрээнд заасан зээлийн шалгуур нөхцөлүүд биелж буй эсэх, ирээдүйн зээл төлөлт хийгдэх баталгаа байгаа эсэхийг баталгаажуулах үүднээс зээлийн шинэчилсэн гэрээнд удирдлагын зүгээс байнгын хяналт тавин ажилладаг. Эдгээр зээл нь зээлийн анхны үр ашигт хүүний хувиар тооцоологдог нэг бүрчилсэн болон нийлмэл үнэ цэнийн бууралтын үнэлгээнд хамрагдсаар байх юм.

(ii) Санхүүгийн хэрэглүүрүүдийг цэвэршүүлэх

Хэрэв байгууллага нь хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг цэвэршүүлэх хуулиар олгогдсон эрхтэй, тооцоог цэвэр дүнгээр нь барагдуулах, эсвэл хөрөнгийг борлуулж өр төлбөрийг нь барагдуулах ажлыг нэгэн зэрэг хийхээр зэхж байгаа л бол санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрүүдийг хооронд нь цэвэршүүлэн, цэвэр дүнгээр тайлан тэнцэлд толилуулах эрхтэй. Мастер цэвэршүүлэлт гэрээнүүдийн хувьд энэ нь хэрэгждэггүй ба холбогдох хөрөнгө болон өр төлбөрийг нийт дүнгээр нь тайлан тэнцэлд тусад нь толилуулдаг.

(й) Үндсэн хөрөнгө

Бүх үндсэн хөрөнгийг өргөөр нь анх бүртгэдэг. Дараагийн тайлант хугацаанд гарсан зардлыг тухайн зардалтай холбогдсон ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийг Банк хүртэх магадлалтай ба өргтийг нь найдвартайгаар хэмжих боломжтой тохиолдолд л хөрөнгийн бүртгэлийн дүнд нэмж эсвэл тусдаа хөрөнгө болгох хоёрын аль таарамжтай гэж үзсэнээр нь хүлээн зөвшөөрдөг. Аливаа сольсон хэсгийн бүртгэлийн дүнг үл хүлээн зөвшөөрнө. Бүх урсгал засварыг тэдгээрийн гарсан тайлангийн хугацаанд орлого, үр дүнгийн тайланда хүлээн зөвшөөрдөг.

Хүлээн зөвшөөрсний дараах үед барилга байшинг дахин үнэлсэн дүн (дахин үнэлгээний өдрийн бодит үнээс хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүн)-гээр илэрхийлдэг. Бодит үнийг мэргэжлийн үнэлгээчийн хийсэн үнэлгээгээр гаргаж ирсэн зах зээлд суурилсан нотолгоогоор тодорхойлно. Дахин үнэлэгдсэн хөрөнгүүдийн бодит үнэ цэнийг тэдгээр хөрөнгүүдийн бүртгэлийн дүнгээс их зөрүүтэй байлгахгүй байх үүднээс таван жил тутамд нэг удаа үндсэн хөрөнгүүдийг дахин үнэлнэ. Дахин үнэлгээний аливаа нэмэгдлийг өөрийн хөрөнгө доторх дахин үнэлгээний санд бүртгэнэ. Дахин үнэлгээний аливаа нэг нэмэгдлээс эхлээд тухайн хөрөнгө дээр өмнө нь үүсч, орлого, үр дүнгийн тайланда хүлээн зөвшөөрсөн дахин үнэлгээний бууралтыг буцааж (энэ тохиолдолд өсөлтийг өмнө хүлээн зөвшөөрсөн бууралтын хэмжээгээр орлого, үр дүнгийн тайланда орлогоор хүлээн зөвшөөрнө), үлдэх дүнг өөрийн хөрөнгийн дахин үнэлгээний санд нэмж бүртгэнэ. Дахин үнэлгээний бууралтыг эхлээд тухайн хөрөнгө дээр өмнө нь хүлээн зөвшөөрсөн, хэрэглэгдээгүй дахин үнэлгээний нэмэгдлээс сүүтгах бөгөөд үүний дараа үлдэх дүнг орлого үр дүнгийн тайланда зардлаар хүлээн зөвшөөрнө. Хөрөнгийг борлуулах эсвэл данснаас хасах үед тодорхой нэг хөрөнгтэй холбоотой аливаа нэг дахин үнэлгээний санг хуримтлагдсан ашигт шууд шилжүүлнэ.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2008 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

(й) Үндсэн хөрөнгө (үргэлжлэл)

Хүлээн зөвшөөрсний дараах үед барилга байшингаас бусад үндсэн хөрөнгийг хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан өртгөөр илэрхийлдэг.

Дуусаагүй барилгад элэгдэл байгуулдаггүй. Үндсэн хөрөнгийн элэгдлийг үндсэн хөрөнгийн төрөл бүрээр, дараах ашиглалтын жилийг үндэслэн шулуун шугамын аргаар байгуулдаг. Үүнд:

Áàðèëäà, áàéøèí	25 - 60 æèë
Öàâèëäà, öïïä ð°ð°öïä	8 - 10 æèë
Êïïüþðåð	5 - 8 æèë
Öýúâðèéí öýðýâñýé	6 - 8 æèë

Үндсэн хөрөнгийн дүн, элэгдүүлэх хугацаа, арга нь өмнө хийгдсэн тооцоолол ба үндсэн хөрөнгөд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн өгөөжийн хүлээгдэж буй хэрэглээний хэв загварт нийцэж байгаа гэдгийг баталгаажуулах үүднээс үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн аргыг санхүүгийн жилийн эцэс бүрт хянаж үздэг.

Үндсэн хөрөнгийг худалдан борлуулах үед эсвэл тэдгээрийн ашиглалтаас ирээдүйд эдийн засгийн үр өгөөж орж ирэхгүй гэж үзсэн үед бүртгэлээс хасна. Үндсэн хөрөнгийн борлуулалтын цэвэр орлого (хэрэв байгаа бол), дансны цэвэр дүн хоёрын зөрүүг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрдөг ба тухайн хөрөнгийн дахин үнэлгээний хэрэглэгдээгүй хэсгийг хуримтлагдсан ашиг руу шууд хуваарилна.

(к) Орлогын албан татвар

Монгол Улсын “Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын тухай хууль”-д заасны дагуу Банк нь орлогын албан татвараас чөлөөлөгддөг.

(л) Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Хөрөнгө нь үнэ цэнийн бууралтад орсон байж болох шинж тэмдэг байгаа эсэхийг Банк тайлант хугацаа тутамд шалгаж үздэг. Хэрэв тийм шинж тэмдэг илэрсэн эсвэл жилд нэг удаа хийдэг хөрөнгийн үнэ цэнийн бууралтын тестийг хийж гүйцэтгэх шаардлагатай үед Банк нь хөрөнгөөс цуглуулан авах боломжтой дүнг тооцож үздэг. Цуглуулан авах дүн нь хөрөнгийн эсвэл бэлэн мөнгө бий болгогч нэгжийн бодит үнэ цэнэ (борлуулалтын зардлыг хасаж тооцсон) ба ашиглалтын өртөг хоёрын аль өндөр нь байна. Хөрөнгийн дансны дүн нь цуглуулан авах дүнгээс илүү байгаа үед хөрөнгийг үнэ цэнийн бууралтад орсон гэж үзэн цуглуулан авах дүнгээр нь бууруулан бүртгэнэ. Ашиглалтын үнийг үнэлэхдээ, тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалыг мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ ба хөрөнгөд харгалзах эрсдлүүдийн талаарх өнөөгийн зах зээлийн үнэлгээнүүдийг тусгасан татварын өмнөх хөнгөлөлтийн хувь хэмжээгээр бууруулан өнөөгийн үнэ цэнийг олно.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2008 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

(л) Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)

Тайлан тэнцлийн өдөр бүр өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын алдагдал арилсан эсвэл буурсан эсэх талаар ямар нэгэн шинж тэмдэг байгаа эсэх талаар үнэлгээг хийдэг. Хэрэв тийм шинж тэмдэг илэрвэл нөхөн төлөгдөх дүнг ойролцоолон тооцож үзнэ. Хамгийн сүүлд үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрснөөс хойш хөрөнгийн цуглуулан авах дүнг тодорхойлоход ашигласан тооцооллуудад өөрчлөлт гарсан тохиолдолд л өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтыг буцаана. Хэрэв тийм бол хөрөнгийн бүртгэлийн дүнг цуглуулан авах дүн хүртэл нь өсгөж бүртгэнэ. Энэ өссөн дүн нь хэрэв өмнөх жилүүдэд хөрөнгөд үнэ цэнийн алдагдлыг хүлээн зөвшөөрөггүй байсан бол байх ёстой байсан бүртгэлийн цэвэр дүнгээс (элэгдлийг хассан цэвэр дүнгээс) хэтрэхгүй байна. Ийм буцаалтуудыг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө. Ийм буцаалтыг хийсний дараа, хөрөнгийн шинэ бүртгэлийн дүн (үлдэгдэл өртгийг хассан дүн)-г түүний ашиглалтын хугацаанд системтэйгээр хуваарилах үүднээс элэгдлийн зардалд залруулга хийнэ.

(м) Буцаан худалдан авах, урвуу буцаан худалдан авах хэлцлүүд

Ирээдүйд тодорхой заасан хугацаанд буцаан худалдан авах нөхцөлтэй хэлцэл ('repo')-ийн дор худалдсан үнэт цааснуудыг тайлан тэнцлээс үл хүлээн зөвшөөрдөггүй. Хүлээн авсан холбогдох бэлэн мөнгөө хуримтлуулсан хүүний хамт тайлан тэнцэлд 'Зээлдүүлсэн үнэт цаас ба буцаан худалдан авах хэлцлүүдийн бэлэн мөнгөөрх барьцаа' гэж тусгагдах ба энэ нь Банкинд олгосон зээл гэсэн эдийн засгийн утга агуулгыг илэрхийлдэг байна. Борлуулсан ба ирээдүйд буцаан худалдан авах үнийн зөрүүг хүүний зардал гэж үзэж үр ашигт хүүний аргыг ашиглан гэрээний хугацааны турш хуримтлуулна. Харин хөрөнгө хүлээн авагч нь тус хөрөнгийг борлуулах эсвэл барьцаанд тавих эрхтэй үед тус хөрөнгийг 'Барьцаанд тавьсан арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө' гэж тайлан тэнцэлд бүртгэнэ.

Харин буцаан худалдах хэлцэл ('урвуу repo')-ийн дор худалдан авсан үнэт цааснуудыг тайлан тэнцэлд хүлээн зөвшөөрдөггүй. Төлсөн мөнгө хуримтлуулсан хүүгийн хамт тайлан тэнцэлд 'Зээлсэн үнэт цаас ба урвуу буцаан худалдан авах хэлцлүүдийн бэлэн мөнгөөрх барьцаа' гэж тусгагдана. Худалдан авсан ба буцаан худалдах үнийн зөрүүг хүүгийн орлого гэж үзэж үр ашигт хүүгийн аргыг ашиглан гэрээний хугацааны турш хуримтлуулна.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2008 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

(н) Санхүүгийн баталгаа

Банк бизнесийн хэвийн нөхцөлд голдуу тендерийн баталгаа болон аккредитивээс бүрдэх санхүүгийн баталгаануудыг гаргадаг. Санхүүгийн баталгааг санхүүгийн тайланд анхлан бүртгэхдээ бодит үнээр нь буюу хүлээн авсан урамшууллын дүнгээр “Бусад өр төлбөр”-т хүлээн зөвшөөрдөг. Ийнхүү анхлан хүлээн зөвшөөрсний дараа, баталгаа бүрт Банкны хүлээх хариуцлагыг хорогдуулсан урамшуулал ба уг баталгааны улмаас үүсэх аливаа нэг санхүүгийн үүргийг биелүүлэхэд шаардлагатай зардлын хамгийн сайн тооцоолсон дүн хоёрын аль ихээр нь хэмжинэ.

Санхүүгийн баталгааны холбогдох өр төлбөрийн аливаа өсөлтийг орлого, үр дүнгийн тайлангийн “Үнэ цэнийн бууралтын алдагдал” дансанд бүртгэнэ. Хүлээн авсан урамшууллыг санхүүгийн баталгааны хүчинтэй байх хугацааны туршид нь шулуун шугамын аргаар тооцож орлого, үр дүнгийн тайлангийн “Үйл ажиллагааны бусад орлого” дансанд хүлээн зөвшөөрнө.

(о) Ажиллагсдын тэтгэмж

(i) Богино хугацаат тэтгэмж

Цалин ба түүнтэй холбогдох бусад зардлуудыг Банкны ажилчдаас холбогдох үйлчилгээг үзүүлсэн тухайн жилд нь зардалд тусгана.

(ii) Заавал төлөх даатгалын шимтгэлүүд

Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд нь Монгол Улсын эрүүл мэнд, нийгмийн даатгалын санд шимтгэл төлнө. Эдгээр шимтгэлийг гарсан хугацаанд нь орлого, үр дүнгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрнө.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2008 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУДАД ОРСОН ӨӨРЧЛӨЛТҮҮД

Банк нь дараах шинэ болон нэмэлт өөрчлөлт хийгдсэн НББОУС, СТОУС-үүд ба Санхүүгийн тайллагналын олон улсын тайлбарын хороо (“СТОУТХ”)-ноос гаргасан тайлбаруудыг тайлант хугацаанд дагаж мөрдсөн.

- | | |
|-------------|--|
| * НББОУС 39 | Санхүүгийн хэрэглүүрүүд: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт
СТОУС 7: Санхүүгийн хэрэглүүрүүд:
Тодруулгууд - Санхүүгийн хөрөнгийн дахин ангилал
(Шинэчилсэн) |
| * СТОУТХ 11 | СТОУС 2 - Бүлэг аж ахуйн нэгж ба халаасны хувьцааны
ажил гүйлгээнүүд |
| * СТОУТХ 12 | Үйлчилгээний эрхийн хэлэлцээ |
| * СТОУТХ 14 | НББОУС 19- Тогтсон дүнтэй тэтгэмжийн хөрөнгө, хамгийн
бага санхүүжилтийн шаардлагууд, тэдгээрийн хоорондын
ажиллагаанд тавигдах хязгаарлалтууд |

Дээр дурьдсан шинэ болон нэмэлт өөрчлөлт хийгдсэн стандартууд, тайлбаруудыг дагаж мөрдсөнөөр Банкны нягтлан бодох бүртгэлийн бодлогод томоохон өөрчлөлт оруулахад хүргээгүй ба санхүүгийн гүйцэтгэл эсвэл байдалд ямар нэг нөлөө үзүүлээгүй болно.

Эдгээр санхүүгийн тайлангуудыг батлах өдрийн байдлаар дараах стандарт, нэмэлт өөрчлөлт, тайлбарууд нь батлагдах шатандаа байсан ба хэрэгжиж эхлээгүй байсан болно. Үүнд:

- | | |
|-------------|---|
| * НББОУС 1 | Санхүүгийн тайлангийн толилуулга (Шинэчилсэн) |
| * НББОУС 23 | Зээлийн зардал (Шинэчилсэн) |
| * НББОУС 27 | Нэгтгэсэн ба салангид санхүүгийн тайлангууд - Охин
компани, хамтын хяналттай компани, хараат компани
оруулсан хөрөнгө оруулалтын өртөг ((Нэмэлт өөрчлөлт)
Нэгтгэсэн санхүүгийн тайлан ба салангид санхүүгийн
тайлан (Нэмэлт өөрчлөлт) |
| * НББОУС 27 | Санхүүгийн хэрэглүүрүүд: Толилуулга - Буцаан өгөх
эрхтэй санхүүгийн хэрэглүүрүүд ба түүнээс үүсэх
үүргүүд |
| * НББОУС 32 | Санхүүгийн хэрэглүүрүүд: Хүлээн зөвшөөрөлт ба
хэмжилт - Шаардлага хангасан хэджинг хийгдсэн
зүйлс (Нэмэлт өөрчлөлт) |
| * НББОУС 39 | Санхүүгийн хэрэглүүрүүд: Хүлээн зөвшөөрөлт ба
Хэмжилт - Санхүүгийн хэрэглүүрүүдийг дахин
ангилах үед агуулагдсан үүсмэл санхүүгийн
хэрэглүүрүүдэд хийх нэмэлт өөрчлөлт |
| * НББОУС 39 | Санхүүгийн хэрэглүүрүүд: Хүлээн зөвшөөрөлт ба
Хэмжилт - Санхүүгийн хэрэглүүрүүдийг дахин
ангилах үед агуулагдсан үүсмэл санхүүгийн
хэрэглүүрүүдэд хийх нэмэлт өөрчлөлт |
| * СТОУС 1 | СТОУС-ийг анхлан нэвтрүүлэх - Охин компани,
хамтын хяналттай компани, хараат компанийд
оруулсан хөрөнгө оруулалтын өртөг (Нэмэлт
өөрчлөлт) |
| * СТОУС 2 | Хувьцаанд суурилсан төлбөрүүд - Хэрэгжүүлэх
нөхцөл ба цуцлалт (Нэмэлт өөрчлөлт) |
| * СТОУС 3 | Бизнесийн нэгдэл (Шинэчилсэн найруулсан) |

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2008 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУДАД ОРСОН ӨӨРЧЛӨЛТҮҮД (ҮРГЭЛЖЛЭЛ)

- * СТОУС 7 Санхүүгийн хэрэглүүрүүд: Тодруулга - Бодит үнэ цэнэ, хөрвөх чадварын эрсдэлийн тодруулгуудыг сайжруулахтай холбоотой нэмэлт өөрчлөлтүүд
- * СТОУС 8 Үйл ажиллагааны сегментүүд
- * СТОУТХ 13 Харилцагчдад чиглэсэн хөтөлбөр
- * СТОУТХ 15 Үл хөдлөх хөрөнгийн барилгын ажлын гэрээ
- * СТОУТХ 16 Гадаад үйл ажиллагааны цэвэр хөрөнгө оруулалтын хэджи
- * СТОУТХ 17 Мөнгөн бус хөрөнгийг эздэд хуваарилах
- * СТОУТХ 18 Харилцагчаас хөрөнгө шилжүүлэх

СТОУС-д орсон нэмэлт өөрчлөлтүүд :

- * СТОУС 5 Борлуулахаар эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ба зогсоосон үйл үйл ажиллагаа
- * НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга
- * НББОУС 16 Үндсэн хөрөнгө
- * НББОУС 19 Ажилчдын тэтгэмж
- * НББОУС 20 Засгийн газрын буцалтгүй тусlamжийн НББ ба Засгийн газрын туслалцааны тодруулга
- * НББОУС 23 Зээллэгийн зардал
- * НББОУС 27 Нэгтгэсэн ба салангид санхүүгийн тайлангууд
- * НББОУС 28 Хараат компанийд оруулсан хөрөнгө оруулалт
- * НББОУС 29 Хэт инфляцитай эдийн засаг дахь санхүүгийн тайлагнал
- * НББОУС 31 Хамтарсан компани дахь хувь оролцоо
- * НББОУС 36 Хөрөнгийн үнэ цэнийн бууралт
- * НББОУС 38 Биет бус хөрөнгө
- * НББОУС 39 Санхүүгийн хэрэглүүрүүд - Хүлээн зөвшөөрөлт ба Хэмжилт
- * НББОУС 40 Хөрөнгө оруулалтын хөрөнгө
- * НББОУС 41 Хөдөө аж ахуй

Банкны захирлууд нь эдгээр стандарт, нэмэлт өөрчлөлт, тайлбаруудын НББОУС1, СТОУС 7, СТОУС 8-ын нэмэлт тодруулгуудаас бусад нь ирээдүйд дагаж мөрдөхөд банкны санхүүгийн тайланд материаллаг нөлөөлөл үзүүлэхгүй гэсэн хүлээлттэй байна.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2008 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.4 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТОМООХОН ҮНЭЛЭЛТ БА ТООЦООЛЛУУД

Дараагийн санхүүгийн тайлант жилд хөрөнгө, өр төлбөрийн бүртгэлийн дүнд материаллаг залруулга хийхэд хүргэж болзошгүй, тайлан тэнцлийн өдөр хийгдсэн ирээдүйн талаарх гол таамаглалууд ба ойролцоолсон тооцооллын тодорхойгүй байдлын талаарх бусад гол эх үүсвэрүүдийг дор тодруулсан болно. Үүнд:

Зээл ба урьдчилгааны болзошгүй алдагдлын сан

Банк нь үнэ цэнийн бууралтын алдагдлын санг орлого, үр дүнгийн тайландаа бүртгэх шаардлагатай эсэхийг үнэлэх үүднээс тайлагналын өдөр бүр асуудалтай зээл, урьдчилгаануудыг хянаж үздэг. Тухайлбал, шаардлагатай сангийн түвшинг тодорхойлох үед ирээдүйн мөнгөн урсгалын дүн, хугацааг ойролцоолон тооцоолоход удирдлагын үнэлэмж шаардагддаг. Ийм тооцоолол нь олон тооны хүчин зүйлүүдийн талаарх таамаглалууд дээр үндэслэдэг ба бодит үр дүнгээс өөр байж болох бөгөөд энэ нь ирээдүйд сангийн хэмжээнд өөрчлөлт оруулахад хүргэж болно.

3. ХҮҮНИЙ ОРЛОГО

	2008 сая төгрөг	2007 сая төгрөг
Санхүүгийн хөрөнгө оруулалт -Борлуулахад бэлэн	10,006	6,485
Урвуу буцаан худалдан авах хэлцлүүд	4,208	9,361
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө, хадгаламж	10,415	31,995
Сангийн яам, дотоодын банкуудад олгосон зээл	4,930	573
	29,559	48,414

4. ХҮҮНИЙ ЗАРДАЛ

	2008 сая төгрөг	2007 сая төгрөг
Гаргасан үнэт цаас	7,827	7,900
Гадаад өр төлбөр	340	565
Засгийн газрын байгууллагуудын хадгаламж	3,004	7,990
Дотоодын санхүүгийн байгууллагуудын хадгаламж	350	2,057
Буцаан худалдан авах гэрээнүүд	343	383
	11,864	18,895

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2008 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

5. АЛТ, ҮНЭТ МЕТАЛЛЫН АРИЛЖААНЫ ЦЭВЭР АШИГ

	2008 сая төгрөг	2007 сая төгрөг
Алтны арилжааны ашиг	12,091	726
Үнэт металлын дахин үнэлгээний бодит бус ашиг	11,693	27,757
Алтны дахин үнэлгээний бодит бус ашиг/(алдагдал)	6,227	1,485
Алтны дахин үнэлгээний бодит ашиг	11,581	6,572
Үнэт металл цэвэршүүлэлтээс олсон валютын ханшийн бодит ашиг	73	8
Бусад үнэт металлын арилжааны цэвэр ашиг	(444)	(145)
Тээвэрлэлт ба цэвэршүүлэлтийн зардал	41,221	29,831

6. ВАЛЮТЫН ХАНШИЙН ЗӨРҮҮНИЙ ЦЭВЭР АШИГ/ (АЛДАГДАЛ)

	2008 сая төгрөг	2007 сая төгрөг
Валютын арилжааны цэвэр бодит ашиг	2,782	7,761
Валютын ханшийн тэгшигтгэлийн бодит бус ашиг	5,093	19,198
	7,875	26,959

7. ҮНЭ ЦЭНЭ БУУРАЛТЫН АЛДАГДЛЫН ЗАРДАЛ

	2008 сая төгрөг	2007 сая төгрөг
Бусад хөрөнгө (Тодруулга 18)	3,145	39,329
Зээл (Тодруулга 15)	18,723	-
Бусад	-	122
	21,868	39,451

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2008 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

8. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

	2008 сая төгрөг	2007 сая төгрөг
Зар сурталчилгаа	95	45
Үндсэн хөрөнгийн элэгдэл (Тодруулга 17)	944	857
Боловсон хүчний зардал (Тодруулга 9)	2,002	1,469
Хуулийн ба мэргэжлийн үйлчилгээний хөлс	1,447	550
Данснаас хассан үндсэн хөрөнгө	4	17
Гадаад улсууд дахь төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны зардал	21	92
Харуул хамгаалалт	392	252
Харилцаа холбоо	608	540
Тээвэр, албан томилолт	298	286
Сургалт	137	86
Ашиглалтын зардал	255	229
Гишүүнчлэлийн ба мэргэжлийн үйлчилгээний хөлс	313	150
Үйл ажиллагааны бусад зардал	479	317
	6,995	4,890

9. БОЛОВСОН ХҮЧНИЙ ЗАРДАЛ

	2008 сая төгрөг	2007 сая төгрөг
Цалин, хөлс	1,676	1,145
Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл	326	324
	2,002	1,469

10. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУСАД ЗАРДЛУУД

	2008 сая төгрөг	2007 сая төгрөг
Мөнгөн тэмдэгтийн зардал	9,372	6,590
Гаргасан, баримтуудтай аккредитивийн оглөгийн сангийн зардал	-	27,889
Азийн Хөгжлийн Банкны МОН-1510 дугаарт зээлийн гэрээний үүргийн зардал	-	1,439
Бусад зардлууд	1,311	359
	10,683	36,719

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2008 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

11. АЛТ, ҮНЭТ МЕТАЛЛ

	2008 сая төгрөг	2007 сая төгрөг
Үнэлгээгээр		
Мөнгөжсөн алт	121,570	232,665
Өртөөр		
Мөнгөжөөгүй алт, мөнгө	13,126	129,900
Зоос, түүх соёлын үнэт зүйлс	2,736	2,730
	137,432	365,295

12. ГАДААДЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДАД БАЙРШУУЛСАН ХӨРӨНГӨ, ХАДГАЛАМЖ

	2008 сая төгрөг	2007 сая төгрөг
Богино хугацаат хадгаламж	13,268	698,335
Зээлжих тусгай эрх	96,736	90,764
Харилцах данс	102,138	41,225
Дэлхийн банкинд оруулсан хувь, хөрөнгө	752	865
Бусад хувь, хөрөнгө	4	3
	212,898	831,192

Богино хугацаат хадгаламж

Гадаадын төв банкууд болон бусад санхүүгийн байгууллагуудад байршуулсан богино хугацаат хадгаламжууд нь ам.доллар, еврогоор илэрхийлэгдсэн ба 33 хүртэлх хоног (2007 онд 60 хоног)-ийн хугацаатай.

Олон улсын валютын сангийн гишүүний хураамж

Энэ үлдэгдэл нь Банкнаас Олон улсын валютын санд төлсөн гишүүний хураамжийг илэрхийлнэ. Энэ дүн нь харгалзах өр төлбөрийн дүнтэй (Тодруулга 20) таарч байгаа ба энэ дүнд хүү тооцдоггүй.

Харилцах данс

Энэ үлдэгдэл нь гадаадын төв банкууд болон бусад санхүүгийн байгууллагуудад байршуулсан харилцах дансыг илэрхийлж байгаа бөгөөд хүү тооцдоггүй. Энэ дүнд гуравдагч талын хүсэлтээр Швейцар Улсын Цюрих хотын дүүргийн шүүхийн шийдвэрээр байршуулсан 427 сая төгрөг (2007 онд тэг төгрөг байсан) багтсан болно.

Дэлхийн банкинд оруулсан хувь хөрөнгө

Энэ үлдэгдэл нь Дэлхийн банкинд байршуулсан хадгаламж болон хувь хөрөнгө бөгөөд Дэлхийн банкны группын гишүүн болох нөхцлийн нэг хэсэг болдог. Энэ дүнг нь холбогдох өр төлбөрийн дүнтэй таарч байгаа (Тодруулга 20-ийг үзнэ үү) ба түүнд хүү тооцдоггүй.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2008 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

13. ҮҮСМЭЛ САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮРҮҮД

	2008 сая төгрөг	2007 сая төгрөг
Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй хөрөнгө оруулалтууд		
Гадаад бондын бодит үнэ	321,840	112,953
Хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй хөрөнгө оруулалтууд		
Энгийн хувьцааны өртөг	2,795	2,795
	324,635	115,748

Хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй энгийн хувьцаа нь Монголын ипотекийн корпораци, Олон улсын хөрөнгө оруулалтын банк, Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны банкинд оруулсан хөрөнгө оруулалтыг илэрхийлнэ. Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй зах зээлийн үнэ байхгүй ба үнэлгээний аргуудыг ашиглан бодит үнэ цэнийг нь найдвартайгаар хэмжиж чадахгүй зэргийн улмаас эдгээр хөрөнгө оруулалтуудыг өртгөөр нь бүртгэдэг. Эдгээр хөрөнгө оруулалтуудад зах зээл байхгүй ба Банк эдгээрийг урт хугацаагаар эзэмших бодлого барьж байна.

14. УРВУУ БУЦААН ХУДАЛДАН АВАХ ХЭЛЦЛҮҮД

	2008 сая төгрөг	2007 сая төгрөг
Урвуу буцаан авах хэлцлүүд	237,278	64,582

Банк нь ирээдүйн тодорхой нэг өдөр, тогтсон үнээр эдгээр хөрөнгө оруулалтуудыг буцаан худалдах гэрээ хийж тодорхой нэг хөрөнгө оруулалтуудыг худалдан авдаг.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2008 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

15. ДОТООДЫН БАНКУУДАД ОЛГОСОН ЗЭЭЛ

	2008 сая төгрөг	2007 сая төгрөг
Гадаад валютын зээл	12,189	14,531
Төгрөгийн зээл	1,968	4,761
Барьцаат зээл	155,177	-
Урвуу репо хэлцэл	17,331	-
Дахин санхүүжилтийн зээл	56,542	130
Нийт зээл, урьдчилгаа	243,207	19,422
Хасах нь: Үнэ цэнийн бууралтын алдагдлын сан	(18,853)	(130)
	224,354	19,292

15. ДОТООДЫН БАНКУУДАД ОЛГОСОН ЗЭЭЛ (УРГЭЛЖЛЭЛ)

(i) Валютын зээл

Валютаар олгосон зээлийн дийлэнх хувийг жижиг, дунд хэмжээний аж ахуйн нэгжүүдийг дэмжих зорилгоор дотоодын арилжааны банкуудад олгосон зээл ба арилжааны банкуудын системийг сайжруулах, банкны мэргэжилтнүүдийн чадварыг дээшлүүлэх зорилгоор олгосон зээл бүрдүүлж байна.

Герман Улсын Засгийн газраас жижиг, дунд хэмжээний аж ахуйн нэгжүүдийг дэмжих зорилгоор арилжааны банкуудаар дамжуулан олгосон зээл (Тодруулга 20-ыг харна уу) нь хоёр тусдаа хөтөлбөрийн хүрээнд олгогдсон билээ. Энэ хоёр хөтөлбөрийн хүрээнд олгогдсон зээлүүд нь жилийн 1.25% - 1.75% (2007 онд 1.25% - 1.75%) хүйтэй ба аливаа нэг үнэ цаасаар баталгаажаагүй болно. Энэ хоёр хөтөлбөрийн хүрээнд зээлийг арилжааны 3 банкинд тэдгээрийн харилцагчдын хэрэгцээнээс хамааран өөр өөр хэмжээтэйгээр олгосон. Үүний дагуу олгосон зээл нэг бүрийн эргэн төлөлтийн хугацаа нь зээл олгосон өдрөөсөө хамааран өөр өөр байгаа.

Арилжааны банкнуудын системийг сайжруулах ба банкны мэргэжилтнүүдийн чадварыг дээшлүүлэх зорилгоор олгосон зээлийг, Монгол Улс ба Азийн хөгжлийн банкны хооронд байгуулсан гэрээний дагуу Ди-Эй-Ай (Тайланд) лимитед компанийн “Банкны сургалтын төв” дээр банкны ажилтнуудад явуулсан сургалтыг санхүүжүүлэх зорилгоор Монголбанк ба бусад арилжааны банкуудад олгосон. Эргэн төлөлтийн хугацаа нь 14 жил.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2008 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

15. ДОТООДЫН БАНКУУДАД ОЛГОСОН ЗЭЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

(ii) Төгрөгийн зээл

Төгрөгийн зээлийг дотоодын арилжааны банкуудаар дамжуулан Монгол Улсын аж ахуйн нэгжүүдэд олгосон байна. Санхүүжилт нь хоёр тусдаа хөтөлбөрийн хүрээнд Азийн хөгжлийн банкнаас ажлын байр нэмэгдүүлэх, хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэхэд зориулан олгогдсон зээл юм. Нэг дэх хөтөлбөрийн хүрээнд олгогдож байгаа зээл нь жилийн 10% (2007 онд 10%)-ийн хүйтэй бөгөөд зээлүүдийн эргэн төлөгдөх хугацаа нь анх олгогдсон өдрөөс хамааран янз бүр байна. Хоёр дахь хөтөлбөрийн хүрээнд олгогдож байгаа зээл нь жилийн 5.5% (2007 онд 5.5%)-ийн хүйтэй, олгогдсон зээл тус бүр нэг жил хүртэл хугацаатай.

(iii) Барьцаат зээл

Барьцаат зээлийг арилжааны долоон банкинд, тэдгээрийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангах зорилгоор олгосон. Эдгээр зээл нь жилийн 13.86%-ийн хүйтэй, 180 хоногийн эргэн төлөлтийн хугацаатай олгогдсон. Энэ дүнд Монголбанк онцгой байдал тогтоогоод байгаа дотоодын арилжааны банкны төлөх 87,723 сая төгрөгийн дүн багтаж байгаа. Энэ зээлтэй холбогдуулан 18,723 сая төгрөгөөр үнэ цэнийн бууралтын алдагдлын санг байгуулсан. Сангийн Яамтай гарын үсэг зурсан ойлголцлын санамж бичиг дээр үндэслэн, Монголбанкны захирлууд зээлийг Монгол Улсын Засгийн газраас авна гэсэн дүгнэлттэй байна.

(iv) Урвуу репо хэлцэл

Урвуу репо хэлцлийн гэрээ нь арилжааны хоёр банкинд олгосон, ирээдүйн тогтсон нэг өдөр, тогтсон үнээр буцаан худалдах нөхцөлтэй Төв банкны үнэт цаасаар баталгаажсан зээлийг илэрхийлнэ.

(v) Дахин санхүүжилтийн зээл

Дахин санхүүжилтийн зээлийг арилжааны хоёр банкинд, тэдгээрийн барилгын салбарт олгосон зээлийг дахин санхүүжүүлэх зорилгоор олгосон. Эдгээр зээлүүд нь 180 хоногийн хугацаатай, жилийн 12%-ийн хүйтэй.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2008 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

15. ДОТООДЫН БАНКУУДАД ОЛГОСОН ЗЭЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

(v) *Дахин санхүүжилтийн зээл (үргэлжлэл)*

Дотоодын банкуудад олгосон зээлүүдийн үнэ цэнийн бууралтын алдагдлын сан

Дотоодын банкуудад олгосон зээлүүдийн үнэ цэнийн бууралтын алдагдлын сангийн тохируулгыг дор үзүүлэв. Үүнд:

	2008 сая төгрөг	2007 сая төгрөг
1 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар	130	3,198
Тайлант жилд нэмж байгуулсан	18,723	-
Данснаас хассан	-	(3,068)
2008 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар	18,853	130
Тусгай үнэ цэнийн бууралт	18,853	130
Тусгай үнэлгээгээр үнэ цэнийн бууралттай гарсан зээлийн тусгай үнэ цэнийн бууралтын дүнг хасахаас өмнөх нийт дун	84,853	130

16. САНГИЙН ЯМАНД ОЛГОСОН УРЬДЧИЛГАА

	2008 сая төгрөг	2007 сая төгрөг
Ядуурлыг бууруулах, өсөлтийг дэмжих хөтөлбөрийн зээл	25,564	29,604

Ядуурлыг бууруулах, өсөлтийг хангах хөтөлбөр (ЯБӨХХ)-ийн хүрээнд нийт олгосон зээлээс Сангийн яамны хариуцах хэсгийг оны эцсийн байдлаар Тодруулга 20-д харуулсан болно. Зээлүүд нь 10 жилийн хугацаатай, жилийн 0.5% (2007 онд 0.5%)-ийн хүйтэй.

МОНГОЛБАНК

САНХУҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2008 ОНЫ 12 ДУТААР САРЫН 31

17. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

	Барилга байшин	Тавилга, тоног төхөрөмж	Компьютер	Тээврийн хэргиси	Дүусаагүй барилга	Нийт
	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг
2008 оны 12 сарын 31						
Өртөг ба үнэлгээгэр						
2008 оны 1-р сарын 1-нээр	16,875	2,015	2,577	852	-	22,319
Нэмэгдсэн	99	537	247	27	651	1,561
Дахин үнэлгээ	5,320	-	-	-	-	5,320
Худалдан борлуулсан	-	-	-	(7)	(511)	(518)
Данснаас хассан	-	(10)	(68)	(10)	-	(88)
2008 оны 12-р сарын 31-нээр	22,294	2,542	2,756	862	140	28,594
Илэрхийлж иш:						
Өртөөр	-	2,542	2,756	862	140	6,300
Үнэлгээгэр	22,294	-	-	-	-	22,294
	22,294	2,542	2,756	862	140	28,594
Хүримтлагдан элэгдэх						
2008 оны 1-р сарын 1-нээр	1,997	758	1,002	469	-	4,226
Тайлант жилд байгуулсан						
(Тодруулга 8)	274	250	288	132	-	944
Худалдан борлуулсан	-	-	-	(6)	-	(6)
Данснаас хассан	-	(14)	(60)	(10)	-	(84)
2008 оны 12-р сарын 31-нээр	2,271	994	1,230	585	-	5,080
Бүтгэлийн цэвэрдүн						
Өртөөр	-	1,548	1,526	277	140	3,491
Үнэлгээгэр	20,023	-	-	-	-	20,023
	20,023	1,548	1,526	277	140	23,514

МОНГОЛБАНК

САНХУҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2008 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

17. ҮНДСЭН ХӨРӨНГӨ (ҮРГЭЛЖЛЭЛ)

	Барилга байшин	Тавилга, тонног тохиромж	Компьютер	Тээврийн хэрэгсэл	Дусагчай барилга	Нийт
	2007 оны 12 сарын 31 сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг
Өргөг ба үзүүлэгээр						
2007 оны 1-р сарын 1-нээр Нэмэгдсэн	16,846 29	1,638 291 (3) 104 (15)	2,523 140 (7) -	776 128 (52) -	- 114 (1) (104) (9)	21,783 702 (63) -
Худалдан борлуулсан Шилжүүлсэн	-	-	-	-	-	-
Данснаас хассан	-	-	-	-	-	-
2007 оны 12-р сарын 31-нээр	16,875	2,015	2,577	852	-	22,319
Илэрхийллэх нь:						
Өргөөр	6,495	2,015	2,577	852	-	11,939
Үнелгээчээр	10,380	-	-	-	-	10,380
	16,875	2,015	2,577	852	-	22,319
Хүримтлалдсан элэгдэл						
2007 оны 1-р сарын 1-нээр Тайлант жилд байгуулсан (Тодруулга 8)	1,722	597	800	388	-	3,507
Худалдан борлуулсан	275	175 (3) (11)	283 (6) (75)	124 (43) -	-	857 (52) (86)
Данснаас хассан	-	-	-	-	-	-
2007 оны 12-р сарын 31-нээр	1,997	758	1,002	469	-	4,226
Бүтгэлийн цэвэр дүн						
Өргөөр	6,041 8,837	1,257 -	1,575 -	383 -	-	9,256 8,837
Үнелгээчээр	14,878	1,257	1,575	383	-	18,093

(а) Аадаёвхийн бүтээгдэхүүнийн төлбөртэй өөдөрний үзүүлэлтэй өөдөртэй аадаёвхийн төлбөртэй үзүүлэлтэй.

Үнэлгээ хийдэжин оноо Хондлонийн үзэгээч Хөрөнөө

2007 оны 12-р сарын 31 Хөрөнгийн Үнэлгээний Төв ХХК Барилга

Зах зээлийн үнэ

Дахин үнэлгэдсэн барилга байшиг түүхэн өртөөр нь тусгасан бол 2008 оны 12-р сарын 31-нээр байлаарх Банкны санхүүгийн тайландаа тусгаждах барилтын дансны цэвэр үнэ 563 сая төгрөг (2007 оны 12-р сарын 31-нээр 574 сая төгрөг) байсан.

(á) 1,727 нийт 8°атд°ае (2007 нийт 1,757 нийт 8°атд°ае) аадаёвхийн 8°атд°ае 20-аадаёвхийн 8°атд°ае 8°атд°ае.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2008 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

18. БУСАД АКТИВ

	2008 сая төгрөг	2007 сая төгрөг
Гадаадын санхүүгийн байгууллагуудаас авах авлага	13,896	12,826
Аж ахуйн нэгжүүдээс авах авлага	28,410	26,503
Бусад	484	2,416
	42,790	41,745
Хасах нь: Үнэ цэнийн бууралтын алдагдлын сан	(42,474)	(39,329)
	316	2,416

Аж ахуйн нэгжүүдээс авах авлагад Банктай хийсэн алтны опцион хэлцлийнхээ үүргийг биељүүлээгүй алт олборлогч компаниудаас авах 24.53 тэрбум төгрөг (2007 онд 22.96 тэрбум төгрөг)-ийн авлага орж байгаа.

Эдгээр үлдэгдлүүд нь Төв Банкны тухай хуулийн 23 дугаар зүйлийн “Засгийн газар болон банкнаас бусад хуулийн этгээд, иргэний мөнгөн хөрөнгийг хуримтлуулан хадгалах, төлбөр тооцоо хийх, зээлийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно” гэсэн заалтыг зөрчихөд хүргэсэн.

Бусад нь ажилтнуудад олгосон урьдчилгаа, урьдчилж хийсэн төлбөр, бичиг хэргийн болон аж ахуйн материал юм.

Бусад активын үнэ цэнийн бууралтын алдагдлын сан

Бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдлын сангийн тохируулгыг дор үзүүлэв. Үүнд:

	2008 сая төгрөг	2007 сая төгрөг
1 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар	39,329	45
Тайлант жилд нэмж байгуулсан (Тодруулга 7)	3,145	39,329
Данснаас хассан	-	(45)
12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар	42,474	39,329
Тусгай үнэ цэнийн бууралт	42,474	39,329
Тусгай үнэлгээгээр үнэ цэнийн бууралттай гарсан бусад активын тусгай үнэ цэнийн бууралтын дүнг хасахаас өмнөх нийт дүн	42,474	39,329

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2008 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

19. ГАРГАСАН ҮНЭТ ЦААС

	2008 сая төгрөг	2007 сая төгрөг
Үнэт цаасны өглөг	119,786	103,425

Энэ нь Банкнаас дотоодын банкуудад гаргасан үнэт цаас болно. Үнэт цаасны хугацаа нь нэг долоо хоногоос хорин найман долоо хоног (2007 онд нэг долоо хоногоос хорин найман долоо хоног) байна.

20. ГАДААД ӨР ТӨЛБӨР

	2008 сая төгрөг	2007 сая төгрөг
Барьцаатай		
Лондонгийн HSBC-ээс авсан зээл	962	1,216
Барьцаагүй		
Олон Улсын Валютын Сан (“ОУВС”)		
(i) ЯБӨХХ-ийн зээл	25,564	29,604
(ii) ОУВС-д байршуулсан валют		
- ОУВС-д байшувансан үнэт цаасны данс	96,162	90,268
- ОУВС дахь данс № 1	242	227
- ОУВС дахь данс № 2	6	6
Герман Улсын Засгийн газраас авсан зээл	14,486	14,258
Азийн Хөгжлийн Банк (“АХБ”)-наас авсан зээл	6,964	12,434
Дэлхийн банк ба ОУХА-д оруулсан хувь хөрөнгө	886	1,338
Нэгдсэн үндэсний хөгжлийн хөтөлбөрөөс авсан тусlamж	-	151
	144,310	148,286
	145,272	149,502

Лондонгийн HSBC-ээс авсан зээл

Үндсэн хөрөнгийн худалдан авалтыг санхүүжүүлэх зорилгоор Лондонгийн HSBC банкнаас 10 жилийн хугацаатайгаар авсан зээл юм. Үндсэн зээлийн эргэн төлөлт нь 2005 онд эхэлсэн бөгөөд хүүг HSBC банкны жилийн үндсэн хүүн дээр 1.75%-ийг нэмж тооцно. Зээлийн барьцаанд Тодруулга 17-д танилцуулсан барилгыг тавьсан.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2008 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

20. ГАДААД ӨР ТӨЛБӨР (ҮРГЭЛЖЛЭЛ)

Олон Улсын Валютын Сан (“ОУВС”) (үргэлжлэл)

- (i) Ядуурлыг бууруулах, өсөлтийг хангах хөтөлбөр (“ЯБӨХХ”)-өөр авсан зээл

Ядуурлыг бууруулах, өсөлтийг хангах хөтөлбөр (ЯБӨХХ, хуучин нэрээр Бүтцийн өөрчлөлтийг дэмжих хөтөлбөр)-ийн хүрээнд ОУВС-аас олгосон зээл нь 10 жилийн хугацаатай, жилийн 0.5% (2007 онд 0.5%)-ийн хүйтэй. Гүйцэтгэлийн шалгуур болон хөтөлбөрийн гүйцэтгэлийг хянаж үзсэний үндсэн дээр эдгээр зээл нь турван жилийн хугацаатайгаар олгогдож байна. Зээл болон түүний эргэн төлөлт нь Зээлжих тусгай эрхээр хийгдэнэ.

- (ii) ОУВС-гийн хувиарласан валют

ОУВС-д оруулсан хөрөнгийнх нь хувь хэмжээгээр ЗТЭ-ийг ОУВС-ийн гишүүн орнуудад хуваарилдаг. Тус хуваарилалт нь ОУВС-ийн хөрөнгийг илэрхийлэх бөгөөд түүнтэй тэнцэх хэмжээгээр ОУВС-аас ЗТЭ-ээр илэрхийлэгдсэн хөрөнгийг хүлээн авдаг. ОУВС-ийн нийт хөрөнгө нь жилийн эцсээр 50.976 сая ЗТЭ (2006 онд 50.976 сая ЗТЭ), буюу 90,501 сая төгрөг (2006 онд 89,371 сая төгрөг) байна.

Герман Улсын Засгийн газраас авсан зээл

Хоёр тусдаа хөтөлбөрийн хүрээнд олгогдож буй энэхүү зээл нь Герман Улсын Засгийн газраас жижиг, дунд аж ахуйн нэгжиг дэмжих зорилготой. Хоёр хөтөлбөрийн хүрээнд еврогоор олгогдож буй зээл нь 40 жилийн хугацаатай. Нэг дэх хөтөлбөрийн зээл нь 1995 онд олгогдож эхэлсэн, жилийн 0.75% (2007 онд 0.75%)-ийн хүйтэй. Үндсэн зээлийн эргэн төлөлт нь 2005 оноос эхэлсэн. Хоёр дахь хөтөлбөрийн зээл нь 2002 онд олгогдож эхэлсэн, жилийн 0.75% (2007 онд 0.75%)-ийн хүйтэй. Үндсэн зээлийн эргэн төлөлт нь 2012 оноос эхэлнэ.

Азийн Хөгжлийн Банк (“АХБ”)-наас авсан зээл

АХБ-ны зээл нь Монгол Улсад ядуурлыг бууруулах, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг дэмжих, хөгжүүлэх мөн Засгийн газар, төрийн бус байгууллагууд, дотоодын арилжааны банкуудад сургалтын болон зөвлөх үйлчилгээ үзүүлэх, хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх үндсэн зорилготой. Зээл нь жилийн 1% (2007 онд 1% - 1.5%)-ийн хүйтэй, 30-40 жилийн хугацаатай.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2008 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

20. ГАДААД ӨР ТӨЛБӨР (ҮРГЭЛЖЛЭЛ)

Дэлхийн банк болон Олон улсын хөгжлийн агентлаг (“ОУХА”)-т оруулсан хувь хөрөнгө

Энэ үлдэгдэл нь Банкнаас Дэлхийн банк ба ОУХА-т оруулсан хувь хөрөнгө юм.

Нэгдсэн үндэсний хөгжлийн хөтөлбөрөөс авсан тусlamж

Энэ нь Монгол Улсад банк бус санхүүгийн байгууллагуудыг хөгжүүлэх зорилгоор Нэгдсэн үндэсний хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд олгосон тусlamж юм. Энэхүү эх үүсвэрийг жижиг зээлээр дамжуулан орлого багатай хүмүүст олгож байна.

21. ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ХАДГАЛАМЖ

	2008 сая төгрөг	2007 сая төгрөг
Улсын төсвийн болон засгийн газрын бусад дансд	3,091	309
Сангийн яамны данс	207,605	603,023
	210,696	603,332

Улсын төсвийн болон засгийн газрын бусад дансд

Эдгээр харилцах дансууд нь Банкинд байршуулсан Засгийн газрын байгууллагуудын төгрөгийн харилцах дансууд юм. Эдгээр харилцах дансуудад хүү тооцдоггүй болно.

Сангийн яамны данс

Энэ нь Сангийн яамнаас Банкинд байршуулсан төрөл бүрийн харилцах, хадгаламжийн дансуудтай холбоотой. 91,420 сая төгрөгийн дүнтэй хугацаагүй, жилийн 0.5% - 2.0% (2007 онд 0.5%)-ийн хүйтэй хадгаламжийг эс тооцвол эдгээр хадгаламжууд нь хугацаагүй, хүүгүй хадгаламжууд юм.

22. ДОТООДЫН БАНКУУДЫН ХАДГАЛАМЖ

Эдгээр дотоодын банкуудаас Банкинд байршуулсан хадгаламж нь заавал байлгах нөөцөөс бүрдэх бөгөөд банкуудын бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгөнд тодорхой хувиар тооцож заавал байлгах нөөцийг тогтоодог.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2008 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

23. БУСАД ПАССИВ

	2008 сая төгрөг	2006 сая төгрөг
Нийгмийн хөгжлийн сан	5,783	2,750
Гаргасан, баримтуудтай аккредитивийн өглөгийн сан	28,862	27,889
Бусад өглөг	8,060	7,707
	42,705	38,346

24. ДҮРМИЙН САН

	2008 сая төгрөг	2007 сая төгрөг
Дүрмийн сан	5,000	5,000

Монголбанк нь 100 хувийн Төрийн өмч болно. Дүрмийн сан нь Банкны өөрийн хөрөнгө юм.

25. ЕРӨНХИЙ НӨӨЦИЙН САН

	2008 сая төгрөг	2007 сая төгрөг
1 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар	15,704	11,145
Хуримтлагдсан ашгаас шилжүүлсэн	5,130	4,559
12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар	20,834	15,704

Монгол Улсын Төв Банк (Монголбанк)-ны тухай хуулийн дагуу Төв банкны жилийн цэвэр ашгийн 40-өөс доошгүй хувийг ерөнхий нөөцийн санд хуваарилж, үлдэх хэсгийг Улсын төсөвт шилжүүлдэг.

МОНГОЛБАНК

САНХУУГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2008 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

26. БУСАД НӨӨЦ

	Борлуулахад бэлэн ноөц	Үндсэн хөрөнгийн дахин үзүүлэхийн нацуудэл	Валютын ханшийн хөрөүүлгийн ноөц	Нийт
2008 оны 1 дугээр сарын 1-ний өдрийн байдаар	1,469	3,019	9,391	13,879
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтын цэвэр ашиг	2,438	-	-	2,438
Дахин үнэллээ	-	5,320	-	5,320
2008 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдаар	3,907	8,339	9,391	21,637
2007 оны 1 дугээр сарын 1-ний өдрийн байдаар	-	3,019	9,391	12,410
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтын цэвэр ашиг	1,469	-	-	1,469
2007 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдаар	1,469	3,019	9,391	13,879

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2008 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

26. БУСАД НӨӨЦ (ҮРГЭЛЖЛЭЛ)

(i) Борлуулахад бэлэн нөөц

Энэ нөөц нь борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтуудын бодит үнэ цэнийн өөрчлөлтүүдээс бүрддэг.

(ii) Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний илүүдэл

Дахин үнэлгээний илүүдэл нь Банкны Ерөнхийлөгчийн 2002 оны тушаалаар гүйцэтгэсэн Банкны барилгын дахин үнэлгээнээс үүссэн.

(iii) Валютын ханшийн хөрвүүлгийн нөөц

Энэ нөөцийг гадаадад байршуулсан нөөцүүдийн дахин үнэлгээний бодит бус ашиг эсвэл алдагдлыг бүртгэхэд ашигладаг.

27. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН АЖИЛ ГҮЙЛГЭЭ

Нэг этгээд нөгөө этгээдийнхээ санхүүгийн буюу үйл ажиллагааны шийдвэрт мэдэгдэхүйцээр нөлөө үзүүлэх чадвартай бол холбоотой талууд гэж үздэг. Банк нь 100 хувийн төрийн өмч юм.

	2008 сая төгрөг	2007 сая төгрөг
Гол удирдах албан тушаалтинуудад олгосон нөхөн олговор		
Богино хугацаат тэтгэмж	152	84
Ажилд орсны дараахь тэтгэмжүүд		
- Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл	27	15
	<hr/>	<hr/>
	179	99

МОНГОЛБАНК

САНХУҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2008 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

28. САНХУҮГИЙН ХЭРЭГЛҮҮРИЙН БОДИТ ҮНӨ ЦЭНЭ

Санхүүгийн тайланд тусгайдсан санхүүтийн хэрэглүүрүүдийн дансны үнэ болон бодит үнүүдийг анти тус бүрээр нь дор харуулав. Энэхүү хүснэгт нь санхүүгийн бус хөрөнгө ба өр төлбөрийн бодит үнүүг багтаагаагүй болно.

Тодруулга	Дансны үнэ	Бодит үнэ	Хүлээн зөвшнөөрөгүй 0.13/гэрээ	Дансны үнэ	Бодит үнэ	Хүлээн зөвшнөөрөгүй 0.13/ гэрээ	
				2008	2008	2008	2007
<i>Санхүүгийн хөрөнгө</i>							
Бэлэн мөнгө	39,589	39,589	-	-	23,197	23,197	-
Галаадын санхүүгийн байгууллагас авлагы	12	212,898	212,898	-	831,192	831,192	-
Санхүүгийн хөрөнгө оруулалт - Борлуулажад бэлэн							
- ХБ дээр бүртгэлтэй галавд бонд	13	321,840	321,840	-	112,953	112,953	-
- ХБ дээр бүртгэлтэй энгийн хувьлаа	13	2,795	*	*	2,795	*	*
Урвуу бунаан худалдан авах хэлцүүд	14	237,278	237,278	-	64,582	64,582	-
Дотоодын банкуудад олгосон зээли	15	224,354	222,585	(1,769)	19,292	16,783	(2,509)
Сангийн заманд олгосон зээли	16	25,564	25,407	(157)	29,604	27,563	(2,041)
Бусад актив	18	-	-	-	-	-	-
<i>Санхүүгийн өр толбор</i>							
Гаргасан унот цаас	19	119,786	119,786	-	103,425	103,425	-
Гадаад өр төлбөр	20	145,272	139,841	5,431	149,502	138,418	11,084
Засгийн газрын байгууллагуудын хадгаламж	21	210,696	210,696	-	603,332	603,332	-
Дотоодын банкуудын хадгаламж	22	226,526	226,526	-	171,027	171,027	-
<i>Нийт бодит үнийн хүлээн зөвшнөөрөгүүгийн бодит бус отрчилалт</i>				3,505	6,534		

* Тодруулга 13-т орцасанчлан, хөрөнгийн биржээдээр бүртгэсэгүй энгийн хувьцааны бодит үнэ цэнийг үнэ цэнийгээний аргачлацуудыг эзэрхэсэгээжүүлжээ.
Нийт бодит үнийн хүлээн зөвшнөөрөгүүгийн бодит бус отрчилалт

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2008 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

28. САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮРИЙН БОДИТ ҮНЭ ЦЭНЭ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Дараахь аргачлал, таамаглалыг ашиглан санхүүгийн тайланд бодит үнэ цэнээр бүртгэгдээгүй санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнийг тодорхойлсон.

Бодит үнэ цэнэ нь бүртгэлийн дүнтэйгээ ойролцоо хөрөнгө

Бэлэн мөнгөнд хөрвөх чадвартай болон богино хугацааны (1 жилээс доош) санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн хувьд тэдгээрийн бодит үнэ нь дансны үнэтэй ойролцоо байдаг гэж таамагладаг. Энэ таамаглал нь Засгийн газрын байгууллагууд ба дотоодын банкуудаас Банкинд байршуулсан харилцахад мөн ашиглагдсан.

Тогтмол хүүтэй санхүүгийн хэрэглүүр

Хорогдуулсан өртгөөр илэрхийлэгдсэн тогтмол хүүтэй санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн бодит үнэ цэнэ нь ижил төстэй санхүүгийн хэрэглүүрүүдийн одоогийн зах зээлийн хүү болон тэдгээр санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг хүлээн зөвшөөрсөн үеийн зах зээлийн хүүний харьцуулалтаар тооцоологдоно. Тогтмол хүү төлдөг хадгаламжийн бодит үнэ цэнэ нь адилхан зээлийн эрсдэл болон хугацаатай зээлүүдийн мөнгөний зах зээлийн хүүгээр бууруулсан бэлэн мөнгөний урсгал дээр сууринна. Хөрөнгийн бирж дээр арилжаалагддаг өрийн хувьд бодит үнэ цэнэ нь зах зээлийн үнэ дээр үндэслэн тооцогдоно. Хөрөнгийн бирж дээр зах зээлийн үнэ нь байхгүй өрийн бодит үнийг тодорхойлоходо одоо зах зээл дээр байгаа хүүгийн хугацаагаарх бүтцийн муурьд үндэслэн харгалзах эргэн төлөгдөх хугацаагаар нь бууруулсан мөнгөн урсгалын загварчлалыг ашигласан.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2008 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

29. ХӨРӨНГӨ БА ӨР ТӨЛБӨРИЙН ХУГАЦААНЫ ШИНЖИЛГЭЭ

Дараахь хүснэгтэнд Банкны актив, пассивын Эргэн төлөгдөх, барагдах хугацаагаар нь харуулсан шинжилгээг харуулсан байна. Тодруулга 310.3 “Төлбөрийн чадварын эрсдэл ба эх үүсвэрийн удирдлага”-аас Банкны бууруулж тооцоогүй эргэн төлөлтийн гэрээт үүргүүдийг харна уу.

	12 хүргэлх сар	12 сараас дээш	Нийт
2008 оны 12 сарын 31	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг
Санхүүгийн хөрөнгө			
Бэлэн мөнгө	39,589	-	39,589
Гадаадын санхүүгийн байгууллагуудаас авах авлагын	212,898	-	212,898
Санхүүгийн хөрөнгө оруулалт- Борлуулахад бэлэн	128,273	196,362	324,635
Үрвuu буцаан худалдан авах хэлцлүүд	237,278	-	237,278
Дотоодын банкуудад олгосон зээл	216,952	7,402	224,354
Сангийн яаманд олгосон зээл	8,332	17,232	25,564
	843,322	220,996	1,064,318
Санхүүгийн бус хөрөнгө			
Алт, үнэт металлын	137,432	-	137,432
Үндсэн хөрөнгө	-	23,514	23,514
Бусад хөрөнгө	316	-	316
	137,748	23,514	161,262
Нийт	981,070	244,510	1,225,580
Санхүүгийн өр толбор			
Гаргасан үнэт цаас	119,786	-	119,786
Гадаад өр төлбөр	106,396	38,876	145,272
Засгийн газрын байгууллагуудын хадгаламж	210,696	-	210,696
Дотоодын банкуудын хадгаламж	226,526	-	226,526
	663,404	38,876	702,280
Санхүүгийн бус өр толбор			
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	407,210	-	407,210
Бусад өр төлбөр	42,705	-	42,705
	449,915	-	449,915
Нийт	1,113,319	38,876	1,152,195
Цэвэр	(132,249)	205,634	73,385

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2008 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

29. ХӨРӨНГӨ БА ӨР ТӨЛБӨРИЙН ХУГАЦААНЫ ШИНЖИЛГЭЭ (ҮРГЭЛЖЛЭЛ)

	12 хүртэлх сар	12 сараас дээш	Нийт
2007 оны 12 сарын 31	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг
Санхүүгийн хөрөнгө			
Бэлэн мөнгө	23,197	-	23,197
Гадаадын санхүүгийн байгууллагуудаас авах авлага	831,192	-	831,192
Санхүүгийн хөрөнгө оруулалт- Борлуулахад бэлэн	11,771	103,977	115,748
Үрвuu буцаан худалдан авах хэлцлүүд	64,582	-	64,582
Дотоодын банкуудад олгосон зээл	8,445	10,847	19,292
Сангийн яаманд олгосон зээл	5,846	23,758	29,604
	945,033	138,582	1,083,615
Санхүүгийн бус хөрөнгө			
Алт, үнэт металл	365,295	-	365,295
Үндсэн хөрөнгө	-	18,093	18,093
Бусад хөрөнгө	2,416	-	2,416
	367,711	18,093	385,804
Нийт	1,312,744	156,675	1,469,419
Санхүүгийн өр төлбөр			
Гаргасан үнэт цаас	103,425	-	103,425
Гадаад өр төлбөр	98,737	50,765	149,502
Засгийн газрын байгууллагуудын хадгаламж	603,332	-	603,332
Дотоодын банкуудын хадгаламж	171,027	-	171,027
	976,521	50,765	1,027,286
Санхүүгийн бус өр төлбөрүүд			
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	364,074	-	364,074
Бусад өр төлбөр	38,346	-	38,346
	402,420	-	402,420
Нийт	1,378,941	50,765	1,429,706
Пэвэр	(66,197)	105,910	39,713

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2008 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

30. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

30.1 ОРШИЛ

Эрсдэл нь банкны үйл ажиллагааны салшгүй хэсэг ба эдгээр эрсдэлийг байнгын илрүүлэлт, хэмжилт, хяналтын үйл явцуудаар дамжуулан удирддаг. Эрсдэлийн удирдлагын энэхүү үйл явц нь Банк мөнгөний бодлогоо үргэлжлүүлэн явуулах, Монгол Улсын банкны салбарын санхүүгийн тогтвортой байдал, бизнесийн тасралтгүй байдлыг баталгаажуулахад чухал үүрэгтэй. Банк нь зээлийн эрсдэл, хөрвөх чадварын эрсдэл, зах зээлийн эрсдэл гэх зэрэг эрсдэлд өртөж байдаг. Үүнээс гадна Банк нь үйл ажиллагааны, нэр хүндийн, хууль эрх зүйн эрсдэлүүдэд мөн өртөж болно.

Одоогоор Банк нь төвлөрсөн эрсдэлийн удирдлагын үйл явцтай байна. Банкны газар бүр өөрсдийн эрсдлийг хянах үүрэгтэй байдаг. Үүнд өөрсдийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэлүүдийг хянаж, шинжилж байх, шинэ бүтээгдэхүүний эрсдэлийг үнэлж үзэх зэрэг орно.

Банк нь Монгол Улсын Төв Банк учраас түүний эрсдэлүүд нь онцгой байdag ба тэдгээр эрсдэлүүдийг Банкны стратеги төлөвлөлтийн үйл явцаар дамжуулан хянаж, шинжилж байдаг. Үүнээс гадна Банк нь эрсдэлийн хяналтын стратегийг боловсруулах ба зарчим, хүрээ, бодлого, хязгааруудыг хэрэгжүүлэх ажлыг ерөнхийлөн хариуцах “Эрсдэлийн хороо”-г байгуулах боломжийг идэвхтэй хайж байна. Энэ хороо нь эрсдэлийн үндсэн асуудлуудыг хариуцах ба холбогдох эрсдэлийн шийдвэрүүдийг удирдах, хянан шинжлэх үүрэгтэй байх юм.

Эрсдэлийн удирдлагын бүтэц

Захирлуудын Зөвлөл нь эрсдэлүүдийг таниж тогтоох, хянахад эцсийн хариуцлага хүлээнэ. Гэсэн хэдий ч, эрсдэлүүдийг удирдах, хянаж шинжлэх үүрэгтэй бие даасан нэгжүүд байдаг.

Захирлуудын Зөвлөл

Захирлуудын Зөвлөл нь эрсдэлийн удирдлагын ерөнхий аргачлалаар хангах ба эрсдэлийн стратеги, зарчмуудыг батлах үүрэг хүлээнэ.

Хяналтын Зөвлөл

Хөндлөнгийн хяналтыг бий болгох үүднээс Банкны дотоод зохион байгуулалтаас гадна Хяналтын Зөвлөлийг байгуулсан ба энэ зөвлөл нь Банкны эрсдэлийн үйл явцыг ерөнхийд нь хянаж, шинжлэх үүрэгтэй.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2008 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

30. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

30.1 ОРШИЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Дотоод аудит

Банкны дотоод аудитын эрхэм зорилго бол Банк зорилгоо биелүүлэх, бодлого, төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхэд чиглэсэн өөрийн үйл ажиллагаануудад хэрэглэж буй эрсдэлийн удирдлагын системийн зохистой, үр нөлөөтэй байдлыг шалгах, үнэлэх явдал юм. Дотоод аудитын газар (ДАГ)-ын дүрэмд өөрийн үргийг Банкны мөрдэж буй бодлого, журмуудын төлөвлөлт, зохион байгуулалт, зохицуулалт, хэрэгжилтийг хянах; үйл ажиллагаа, системүүд нь хууль, журамд хэр нийцэж буйг шалгах; санхүүгийн ба үйл ажиллагааны мэдээллүүдийн найдвартай, цогц, аюулгүй байдлыг хянах зэрэг үйл ажиллагаанд хэрэглэгдэж буй бүх түвшний эрсдэлийн удирдлагын үр нөлөөг шалгах гэж тодорхойлсон байна.

Дотоод айдитын газар (ДАГ) нь ерөнхий болон тусгайлсан үйл ажиллагааны түвшинд эрсдэлийн үнэлгээг хийдэг. Эрсдэлийн түвшинг харгалзаж үзсэний үндсэн дээр хүн хүчийг зохистой хуваарилах явдлыг баталгаажуулах үүднээс эрсдэлийн ерөнхий үнэлгээг аудитын ажлын жилийн төлөвлөгөөг боловсруулах үед хийдэг бол эрсдэлийн тусгай үнэлгээг тодорхой нэг түвшний тодорхой асуудлууд дээр анхаарал хандуулах үед хийдэг. Одоогийн байдлаар Банкны ДАГ нь 2007 оноос 2011 он хүртэлх урт хугацаат аудитын хөтөлбөр ба 2007 оны аудитын жилийн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаага явуулж байна. Аудит нэн тэргүүнд шаардлагатай байгаа хэсгүүдийг тодорхойлоходо үйл ажиллагааны хэсэг нэг бүрд нөлөөлөх эрсдэлийн боломж ба зэргийг тусган харуулсан зарим нэг шалгуур үзүүлэлтүүдийг ашигладаг. Энэ зорилгоор зарим нэг шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулсан ба аудит хийгдсэн үйл ажиллагаа нэг бүр дээр шалгуур үзүүлэлтийг дүгнэж, жигнэсэн дундаж оноог гаргадаг.

Үйл ажиллагааны хэсэг бүрийн жигнэсэн дундаж оноонуудыг нэмж дүгнэх ба үүний дагуу эрсдэлийн зэргийг өндөр, дунд, бага гэж ангилна. Дотоод хяналтын системийг үнэлэх ажил нь мөн дотоод аудитын ажлын нэг чухал хэсэг юм. Банкны үйл ажиллагааг үр нөлөөтэй, эдийн застийн үр ашигтай, үр дүнтэй байлгах; санхүүгийн тайлагналын системийг найдвартай байлгах; бүх үйл ажиллагааг хууль, журамд нийцүүлэх зэрэг зорилтууддаа хүрэхийн тулд боловсруулсан бүх хэрэгслүүдийг дотоод хяналт гэж тодорхойлдог. Үнэлгээ нь мөрдэж буй горимууд нь зохистой, гүйцэтгэл нь зорилгодоо нийцэж байгаа гэдгийг баталгаажуулахыг зорьдог. ДАГ нь олж илрүүлсэн дутагдал, зөрчил ба өгөх зөвлөмжүүдээ удирдлагын хувьд Ерөнхийлөгчид, үйл ажиллагааны хувьд Хяналтын Зөвлөлд тайлагнадаг. Үнэлгээ бүрийн дараа ДАГ нь Банкны удирдлагатай ажлын үр дүн хэлэлцэг ба удирдлагын зүгээс авсан арга хэмжээний хэрэгжилтийг хянадаг.

Эрсдэлийн удирдлагын алба

Эрсдэлийн удирдлагын алба (“ЭУА”) нь гадаад валютын нөөцийн удирдлагын эрсдэлтэй холбоотой, бие даасан хяналтын үйл явцыг баталгаажуулах горимуудыг хэрэгжүүлэх, хянах үүрэгтэй. ЭУА нь Банк өөрийн гадаад валютын нөөцийг удирдаж байхдаа гадаад валютын нөөцийн удирдлагын стратегийн стандартууд, эрсдэлийн дүрмүүд, бодлого ба хязгааруудад хэр нийцэн ажиллаж байгааг хянаж, шинжлэх үүрэгтэй. Үүнээс гадна ЭУА нь мөн гадаад валютын нөөц ба тайлагналын системтэй холбоотой эрсдэлийг бүрэн хэмжсэн эсэхийг баталгаажуулах үүрэгтэй. Улсын гадаад валютын нөөцийн удирдах журамд заасны дагуу нөөцийн удирдлагын зорилго нь Банкны мөнгөний болон гадаад валютын бодлоготой нийцэж байх ёстой.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2008 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

30. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

30.1 ОРШИЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Эрсдэлийн удирдлагын алба (үргэлжлэл)

Гадаад нөөцийг барьж байхын гол зорилгууд нь:

- Мөнгөний бодлогыг дэмжих
- Гадаад валютын зах зээлийн гэнэтийн хөдөлгөөнийг хянах
- Засгийн газрын гадаад валютын өрийн төлбөрт баталгаа гаргах
- Үндэсний гамшиг эсвэл онцгой байдлын үед төлбөрийн хэрэгсэл болгон ашиглах

Гадаад нөөцийн эрсдэлийн удирдлага нь санхүүгийн ба үйл ажиллагааны эрсдлүүдийг стратегийн хувьд зөв удирдах, хянах замаар эдгээр зорилгуудыг биелүүлэхэд хувь нэмрээ оруулдаг. Гадаад эрсдэлүүдэд өртөх өртөлтийг хянах үүднээс Банк жил бүр хөрөнгийн сонголт ба хуваарилалтыг хийх стратегийг тодорхойлдог. Үүний тулд дараахь параметрүүдийг тодорхойлох шаардлагатай болдог. Үүнд (1) эзэмших валютууд ба хөрвөх валютуудын бэлэн олдох боломжийг бий болгоход шаардлагатай багцын бүтэц (2) төлбөрийн чадварын ба аюулгүй байдлын шаардлагуудыг хангасан хөрөнгө оруулалтын хэрэглүүрүүдийн зөвшөөрөгдөх хэмжээ, (3) хүүгийн түвшний эрсдэлийн өртөлтийг хязгаарлахад тавигдах хугацааны шаардлагууд.

30.2 ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛ

Зээлийн эрсдэл гэж харилцагч тал эсвэл үйлчлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүйн улмаас Банк алдагдал хүлээх эрсдлийг хэлнэ. Дотоодын мөнгөний бодлогын үйл ажиллагааны хувьд Банк нь өөрийн зээлийн эрсдэлийг бууруулахад барьцаа хөрөнгийг идэвхтэй ашигладаг. Төв Банкны дахин санхүүжилтийн журмын дагуу барьцаанд авч болох хөрөнгийн гол төрлүүдийг дор жагсаав. Үүнд:

1. Төв Банкны үнэт цаас
2. Засгийн газрын богино хугацаат үнэт цаасууд
3. Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллагын гишүүн орнуудын Засгийн газраас гаргасан ба Банк хүлээн зөвшөөрсөн үнэт цааснууд
4. ААА зэрэглэлийн болон хүлээн зөвшөөрөгдсөн, гадаадын санхүүгийн байгуулагуудын эзэмшдэг хөрвөх чадвар өндөртэй үнэт цааснууд
5. Банк хүлээн зөвшөөрсөн вексель
6. Монголбанк ба гадаадын банкууд дахь хугацаатай хадгаламж

Эрх бүхий зээлдэгч банкууд нь Банкнаас тогтоосон бүх зохистой харьцааг ханган ажиллах ёстай. Хэрэв зээлдэгч дотоодын банк нь эдгээр зохистой харьцаануудын аль нэгийг зөрчвөл Банк тухайн зээлдэгч банктай холбоотой үүсэж болох эрсдэлийн нийт хэмжээг хязгаарлах үүднээс дахин санхүүжилтийн үйл ажиллагааг зогсоно.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2008 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

30. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

30.2 ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Зээлийн эрсдэлийг хязгаарлахын тулд гадаад валютын нөөцөөр Засгийн газрууд ба олон улсын байгууллагуудын гаргасан AAA зэрэглэлийн үнэт цаасуудад хөрөнгө оруулалт хийдэг. Гадаад валютын хадгаламж ба мөнгөний зах зээлийн хэрэглүүрүүдийн зээлийн эрсдэлийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээний агентлагуудын үнэлгээгээр АА болон түүнээс дээш үнэлгээ авсан харилцагчидтай гүйлгээ хийх замаар хязгаарладаг. Харилцагч нь нэгээс олон үнэлгээний агентлагуудаас үнэлгээ авсан бол хамгийн бага үнэлгээг ашиглана.

Үүнээс гадна, бүх харилцагч талуудад тэдгээрийн зээлийн зэрэглэл, капитал, бусад хүчин зүйлүүдийг харгалзан үзсэний үндсэн дээр зээлийн хязгаар тогтоож өгдөг. Зээлийн хязгаарыг улирал бүр шинэчлэн тогтоодог ба тогтоосон хязгаарын нийцлийг өдөр бүр хянаж, шинжилж байдаг.

Зээлтэй холбоотой болзошгүй төлбөрийн эрсдэл

Банк өөрийн харилцагчдаа баталгаа гаргаж өгдөг ба энэхүү баталгааны улмаас Банк нь харилцагчийнхаа өмнөөс төлбөр хийх шаардлагатай болж болно. Эдгээр төлбөрийг харилцагчаас аккредитивийн гэрээний нөхцлийн дагуу цуглуулан авна. Эдгээр нь зээлтэй адил эрсдэлтэй ба эдгээр эрсдэлийг бууруулах хяналтын үйл явц ба бодлого нь зээлийнхтэй адил байна.

Эдгээр хэрэгслүүдийн гол зорилго нь харилцагчдыг шаардлагатай эх үүсвэрээр хангахад оршино. Баталгаа ба нээлттэй аккредитивууд нь харилцагч гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгэх чадваргүй болсон тохиолдолд Банк өмнөөс нь төлбөрийг нь барагдуулах цуцлагдашгүй үүрэг хүлээснийг илэрхийлдэг ба эдгээр хэрэгслийн эрсдэл нь зээлийн эрсдэлтэй ижил юм.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2008 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

30. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

30.2 ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Барьцаа хөрөнгө болон бусад зээлийн баталгаа, батлан даалтыг тооцохгүйгээр зээлийн учирч болзошгүй эрсдэлийн дээд хэмжээг авч үзвэл

Доорх хүснэгтэд тайлан тэнцлийн үзүүлэлт бүрийн хувьд зээлийн эрсдэлд өртөж болох дээд хэмжээг харуулсан байна. Барьцаа хөрөнгийн гэрээг ашиглан эрсдэлийг бууруулахаас өмнөх нийт дүнгээр өртөлтийн дээд хэмжээг илэрхийлсэн болно.

Тодруулга	Нийт өртөлтийн дээд хэмжээ 2008 сая төгрөг	Нийт өртөлтийн дээд хэмжээ 2007 сая төгрөг
Гадаадын санхүүгийн байгууллагуудаас авах авлага	12	212,898
Санхүүгийн хөрөнгө оруулалт- борлуулахад бэлэн	13	324,635
Урвуу буцаан худалдан авах хэлцлүүд	14	237,278
Дотоодын банкуудад олгосон зээл	15	224,354
Сангийн яаманд олгосон зээл	16	25,564
Бусад хөрөнгө	18	-
Нийт зээлийн эрсдэлийн өртөлт	1,024,729	1,060,418

Санхүүгийн хэрэгслүүдийг бодит үнээр нь бүртгэсэн бөгөөд дээр үзүүлсэн дүнгүүд нь үнэ цэнийн өөрчлөлтийн улмаас ирээдүйд үүсэж болох зээлийн эрсдэлийн өртөлтийг биш өнөөгийн зээлийн эрсдэлийн өртөлтийг харуулж байгаа болно.

Санхүүгийн хэрэглүүрийн бүлэг нэг бүрийн зээлийн эрсдэлийн дээд өртөлтийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг харгалзах тодруулгуудаас авна уу.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2008 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

30. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

30.2 ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Эрсдэлийн төвлөрөл

Барьцаа хөрөнгө эсвэл зээлийн чанарыг сайжруулах бусад арга хэрэгсэлүүдийг авч үзэхээс өмнөх байдлаар, санхүүгийн хөрөнгүүдийг газар зүйн байршилаар нь ангилан үзүүлэв.

	Нийт өртөлтийн дээд хэмжээ 2008 сая төгрөг	Нийт өртөлтийн дээд хэмжээ 2007 сая төгрөг
Монгол	252,712	49,726
Австрали	-	99,447
Австри	-	-
Белги	-	49,157
Франц	68,394	56,779
Герман	-	43,983
Хонг Конг	11,477	35,099
Япон	-	38,115
Люксенбург	-	31,022
Шинэ Зеланд	-	295
Орос	-	22,774
Сингапур	-	247,397
Швецарь	109,980	67,560
Их британи	48,788	124,565
